Монголын Хөдөлмөрийн
Аюулгүй Ажиллагаа Эрүүл Ахуйн
Менежментийн Хүрээлэн

# Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ба менежмент сургалтын багц

## Жижиг болон дунд байгууллагуудад зориулав






SafeWork

Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд болон байгаль орчны хөтөлбөр (SafeWork)

# Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ба эрсдэлийн удирдлагын сургалтын багц

## Жижиг болон дунд байгууллагуудад зориулав.

**Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Оффис, Женев хот**

Энэхүү бүтээлийн эх хувь нь Женев хот дахь Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын оффист “Жижиг болон дунд байгууллагуудад зориулсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ба менежментийн сургалтын багц” нэртэйгээр хэвлэгдсэн. Зохиогчийн эрх © 2013 Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага.

Монгол орчуулгын зохиогчийн эрх © 2016 Монголын Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа Эрүүл Ахуйн Менежментийн Хүрээлэн (OSHMI).

Орчуулагч: Б.Оюунтөгс (M.Sc) Хөдөлмөрийн Эрүүл Мэнд, Аюулгүй байдал ба Байгаль Орчны Менежментийн Магистр, Хойд Вэйлсийн Их Сургууль, Их Британи.

Албан ёсны зөвшөөрөлтэйгээр орчуулж, хувилав.

---

ОУХБ-ын хэвлэлүүдийн зориулалт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын туршлагад нийцтэй бөгөөд материал нь ОУХБ-ын зүгээр ямар нэг үзэл бодлын илэрхийлэл биш бөгөөд аливаа улс орон, бүс нутаг, газар нутаг болон тэдгээрийн эрх бүхий байгууллагууд, эсвэл тэдний төлөөллийн хуулийн статусын талаар харгалзаж үзээгүй болно.

Аливаа сэтгүүлийн өгүүлэл, сургалтын болон бусад материалуудад илэрхийлсэн үзэл бодлын талаарх үүрэг хариуцлагыг автор нь хүлээх бөгөөд ОУХБ үүнд ямар нэг дэмжлэг эсвэл баталгаажуулалт болох үндэсгүй.

Аливаа компани ба арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурдах нь ОУХБ-аас тэдгээрийг дэмжиж эсвэл баталгаажуулж буй хэрэг бус бөгөөд тэдгээрийг дурдахгүй байх нь мөн үгүйсгэж буй хэлбэр биш юм.

ОУХБ-ын хэвлэлүүд ба цахим бүтээгдэхүүнүүд нь томоохон номын худалдааны байгууллагууд болон ОУХБ-ын олон орон дахь оффисуудаар, мөн ОУХБ-ын өөрийн төв байранд худалдаалагдаж болно. ОУХБ-ын өөрийн төв байрны хаяг нь Щвейцарь улс, Женев 22, CX-1211, ОУХБ. Шинэ хэвлэлийн каталоги буюу жагсаалтыг дээрх хаягаар болон pubvente@ilo.org имэйл хаягаас үнэ төлбөргүй авч болно.

ОУХБ нь монгол орчуулгын хүчин төгөлдөр буюу бүрэн байдал, эсвэл тодорхой бус байдал болон алдаа дутагдал, тэдгээрээс үүдэн бий болж болох үр дагаваруудад хариуцлага хүлээхгүй.

Уншигч та энэхүү номны монгол орчуулгатай холбоотой санал хүсэлтээ Монголын Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа Эрүүл Ахуйн Менежментийн Хүрээлэн (OSHMI)-гийн доорхи албан ёсны хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: 92 тоот, 34-р байр, 15141, 5-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс Утас/Факс: 976-76113838,

Шуудангийн хайрцаг: 46/906,

И-Мэйл: training@oshmi.mn,

Вэб сайт: http://www.oshmi.mn

Монгол орчуулгын эх бэлтгэл болон хэвлэлтийг Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод хийв.

The original edition of this work was published by the International Labour Office, Geneva, under the title Training package on workplace risk assessment and management for small and medium-sized enterprises. Copyright © 2013 International Labour Organization.

Mongolian translation copyright © 2016 Occupational Safety and Health Management Institute of Mongolia (OSHMI).

Translated by: Ms.Oyuntugs Batbaatar, M.Sc in Occupational Safety, Health and Environment Management, University of South Wales, United Kingdom.

Translated and reproduced by permission.

---

The designations employed in ILO publications, which are in conformity with United Nations practice, and the presentation of material therein do not imply the expression of any opinion whatsoever on the part of the International Labour Office concerning the legal status of any country, area or territory or of its authorities, or concerning the delimitation of its frontiers.

The responsibility for opinions expressed in studies and other contributions rests solely with their authors, and publication does not constitute an endorsement by the International Labour Office of the opinions expressed in them.

Reference to names of firms and commercial products and processes does not imply their endorsement by the International Labour Office, and any failure to mention a particular firm, commercial product or process is not a sign of disapproval.

The ILO shall accept no responsibility for the validity or completeness of the Mongolian translation or for any inaccuracy, errors or omissions or for the consequences arising from the use thereof.

If you have any concern or comments regarding the translation in Mongolian, please send them to the below stated address or e-mail address of Occupational Safety and Health Management Institute of Mongolia.

Address: #92, Building 34, 5th khoroo, Chingeltei district, Ulaanbaatar 15141, Mongolia

Phone/Fax: 976-76113838

Post Office Box: 46/906

E-mail: training@oshmi.mn

Website: http://www.oshmi.mn

Mongolian edition was published in Ulaanbaatar capital city of Mongolia.

***Энэхүү сургалтын багцыг "Ажил дээрх аюулгүй байдал, эрүүл мэндийг эдийн засгийн тогтвортой хөгжилтэй уялдуулах нь: Онол, тунхаглалаас эхлээд арга хэмжээ, ял шийтгэл" (2009-2012) хэмээх Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (SIDA)-с санхүүжүүлсэн төслийн хүрээнд боловсруулав.***

Төсөл нь бүх ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг энэхүү салбар дахь арга зүйн болон мэдээллийн зөрүүг арилгаж буй глобал бүтээгдэхүүнийг боловсруулах замаар болон үндэсний гол оролцогчдыг үндэсний, орон нутгийн болон байгууллагын түвшинд хэрэгжүүлж болох практик арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжих замаар сайжруулах зорилготой. Төслийн гаралт нь сургалтын материал, практик хэрэгслүүд, бодлогын удирдамж байх ба эдгээр нь үндэсний болон орон нутгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чадавхийг дээшлүүлэхийг шаардах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого ба хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд туслах явдал байна.

# Агуулга


*Өмнөх үг* . . . 7

*Талархал* . . . 8

*Танилцуулга* . . . 9

*Сургалтын багцын талаар* . . . 12

## БҮЛЭГ 1. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ – 31 ХУУДАС

Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт болон нэр томъёо . . . 15

Аюул ба эрсдэл . . . 15

*Аюулгүй байдал ба эрүүл мэнд хоёрын ялгаа* . . . 16

*Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ.* . . . 17

*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн өнцгөөс бизнесийг тодорхойлох нь.* . . . 17

*Ажлын байрыг дундаа ашигладаг бол яах вэ?.* . . . 17

*Эрсдэлийн үнэлгээ хийх нь.* . . . 18

*Эрсдэлийн үнэлгээ гэж юу вэ?.* . . . 18

*Эрсдэлийн үнэлгээний таван шатлалт үйл явц.* . . . 19

*Эрсдэлийн үнэлгээний загварууд.* . . . 20

*Эрсдэлийн үнэлгээг хэн хийдэг вэ?.* . . . 20

*Ажилчдыг идэвхитэй оролцуулах.* . . . 22

АЛХАМ 1. Аюулыг илрүүлэх тодорхойлох . . . 23

АЛХАМ 2. Хэн хэрхэн хохирч буйг тодорхойлох . . . 25

АЛХАМ 3. Эрсдэлийг үнэл – эрсдэлийг хянах арга хэмжээ юу байж болохыг тодорхойлж, алийг нь сонгохыг шийд . . . 27

АЛХАМ 3.А: Одоогийн эрсдэлийн хяналтын арга хэмжээний хүрээнд та яг одоо юуг хийсэн байгаа вэ? . . . 28

АЛХАМ 3.Б. Эрсдэлийг хянах ямар арга хэмжээ хэрэгтэй вэ? . . . 29

АЛХАМ 4. Эрсдэлийг хянах арга хэмжээг хариуцах хүн болон хугацааг тодорхойлох . . . 38

АЛХАМ 5. Үр дүнг үнэлэх, эрсдэлийн үнэлгээндээ мониторинг хийх ба дүгнэн шинжлэх, шаардлагатай бол шинэчлэх . . . 43

## БҮЛЭГ 2. БАГШИЙН ХЭРЭГСЭЛ – 14 ХУУДАС

*Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх: Сургагч нарын шалгах хуудас.* . . . 46

*Эрсдэлийн үнэлгээгээр хийх арга хэмжээнүүд.* . . . 52

## БҮЛЭГ 3. ЗАРИМ АЖЛЫН БАЙРАНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖИШЭЭНҮҮД

*Эрсдэлийн үнэлгээний жишээ* . . . 61

*ЖИШЭЭ 1. Тоосго өрөх ажил.* . . . 62

*ЖИШЭЭ 2. Лавлах төв.* . . . 64

*ЖИШЭЭ 3. Үсчин.* . . . 66

*ЖИШЭЭ 4. Авто машины засварын цех.* . . . 68

*ЖИШЭЭ 5. Оффисын цэвэрлэгээ* . . . 70

*ХАВСРАЛТ: Бусад мэдээлэл* . . . 72

# Өмнөх үг

Ажлын байран дээрх эрсдэлийн үнэлгээ ба эрсдэлийн менежментийн энэхүү сургалтын багц нь ерөнхийдөө жижиг ба дунд бизнес (ЖДБ) эрхлэгчид болон жижиг дунд байгууллага /ЖДБ/-ын ажлын байран дээрх аюулгүй, эрүүл нөхцөл байдлыг сайжруулахад нь тус нэмэр болоход зориулагдсан.

Ажилтай холбоотой үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл нь хүний амь нас эрүүл мэндийг сүйтгэхээс гадна компанийн бизнесийг нь алдагдалд оруулах, дампууруулах, машин механизм тоног төхөөрөмж, барилга байшин нь эвдрэх, даатгалын зардлаа өсгөх зэрэг сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс жижиг дунд байгууллагуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин /МШӨ/ гарсан тохиолдолд санхүүгийн болон хэвийн үйл ажиллагаанд нь ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаа нь эдийн засгийн afford урсгалаараа явж чадахгүйд хүрдэг. Ийм учраас үйлдвэрлэлийн осол МШӨ-өөс урьдчилан сэргийлэхийн тулд энэхүү сургалтын багцыг боловсруулсан юм.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хувьд эзэд болон бизнес эрхлэгчдэд осол, өвчлөл гарсны дараа биш гарахаас нь өмнө аюулыг илрүүлдэг, арга хэмжээг яаж авах тэр нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад ямар чухал байдаг талаар сургана. Энэхүү сургалтын багцад өгүүлж байгаагаар, про-актив байх нь тийм хэцүү биш. Учир нь ажил олгогчид болон ажилчид өөрсдийнхөө сайн мэддэг ажлын байрныхаа эрсдэлийг үнэлэх гэж байгаа юм.

Гол зорилго нь жижиг, дунд байгууллага (ЖДБ)-ын ажил олгогчид/эздэд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж компанийнхаа ажлын байруудын эрсдэлийг үнэлэхэд оршино.

Энэхүү сургалтын багц нь зөвхөн ажил олгогчдоор зогсохгүй, ЖДБ-ын ажилтнууд, ХАБЭА-н орон тооны бус зөвлөл, хөдөлмөрийн байцаагчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд болон тэдгээрийн гишүүд гэх зэрэг эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг удирдахдаа энэхүү сургалтын материалыг ашиглаж болох бусад талуудад ч сонирхолтой гарын авлага болно.

Гарын авлага нь гурван модулиас бүрдэнэ.

Гол модуль нь эрсдэлийн үнэлгээг хийх таван алхмыг тусгасан байгаа. Энэхүү модулийн агуулга нь ажил олгогч болон ажилтнуудыг хэрхэн эрсдэлийн үнэлгээг зөв дараалалтай хийхэд сургах болно. Хоёр дахь агуулга нь сургагч багш нарын хэрэгсэл бөгөөд эрсдэлийн үнэлгээний сургалт явуулахыг нь дэмжиж, эрсдэлийн үнэлгээний хөтөлбөрөө төлөвлөхөд нь туслах юм.

Гуравдугаар хэсэг нь ЖДБ-уудын голчлон хамардаг салбаруудаас сонгож, эрсдэлийн үнэлгээний жишээг үзүүлсэн байгаа.

Би энэхүү сургалтын гарын авлага нь ажил олгогч болон ажилтнуудад ажлын байран дахь эрсдлээ зөв зохистой хянаснаар үргүй зардлыг бууруулсанаар ажил олгогч болон ажилтан хоёулаа үр дүнг нь хүртэж болох энгийн, үйл ажиллагаандаа ашиглахад бэлэн шийдлийг санал болгож байгаа гэдэгт найдаж байна.

***Сэйжи Мачида, Захирал.***
***Аюулгүй Ажиллацгаая.***

# Талархал

Энэхүү сургалтын гарын авлагын боловсруулах ажил нь Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (SIDA)-н оролцоогүйгээр хийгдэх боломжгүй байлаа.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөх ноён Питер Харст ОУХБ-г Малави дахь хэд хэдэн удаагийн өөр өөр хөдөлмөрийн салбарт төлөөлөн ажиллаж, энэхүү сургалтын гарын авлагыг нооргложж, сургалтын хөтөлбөрийг анх хэрэгжүүлэн туршсан. ОУХБ-ын Аюулгүй Ажиллагааны Хөтөлбөрийн хатагтай Анни Райс болон ноён Андрью Кристиан нар агуулгыг сүүлийн байдлаар бэлтгэхэд техникийн туслалцаа үзүүлсэн. SIDA-н Ахлах Техникийн Зөвлөх хатагтай Амэли Шмитт энэхүү бүтээгдэхүүнийг боловсруулах ажлыг зохицуулсан.

# Танилцуулга

Хэдийгээр жижиг дунд байгууллагууд (ЖДБ) нь дэлхий даяарх ихэнхи бизнесийг төлөөлдөг маш чухал хэсэг боловч, тэдний олонхи нь өсч хөгжиж, эсвэл ажилласаар байж чаддаггүй. Жил бүр, бүтээмж багатай байх асуудал, эсвэл чанар муутай бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, мөн маркетинг болон санхүүгийн асуудлууд мянга мянган ЖДБ-г дампуурахад хүргэдэг. Энэхүү саад бэрхшээл нь үргэлж ажлын эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх ажлын зохион байгуулалт муугаас шалтгаалсан байдаг. Иймэрхүү ЖДБ нь илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажлын орчин болон аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаа амархан сайжруулж, илүү сайн өрсөлдөх чадвартай байгууллага болох боломжтоо ашиглаагүй байдаг. Гэвч нөгөө талаас ЖДБ-ууд тийм эерэг өөрчлөлт хийх арга техник, хэрэгслүүдээр дутмаг байдаг нь нөлөөлдөг1.

ЖДБ-д аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцлийг сайжруулах гол хэрэгсэл буюу арга техникүүдийн нэг нь ажлын байрны эрсдэлийн үнэлгээ бөгөөд энэ нь байгууллагын эрсдэлийн менежментийн гол элемент юм. Эрсдэлийн менежмент нь олон тооны шийдлийг санал болгодог ба өөртөө компанийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн хороод, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (ХАБЭМ)-ийн сургалт ба мэдээлэл, ХАБЭМ-ийг сайжруулах зорилго зорилтуудаа тодорхойлох, эрсдэлийн талаар мэдээлэл солилцох асуудлыг багтаадаг.

Аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ бол дэлхий даяарх бизнесийн ертөнцөд улам өргөн хэрэглэгдсээр байгаа эрсдэлийн удирдлагын арга юм. Эрсдэлийн удирдлагын дэмжих хэрэгслийн хувьд эрсдэлийн үнэлгээ нь жижиг, дунд, том бүхий л хэмжээний байгууллага, компаниудад ажлын байраа илүү аюулгүй, эрүүл болгох, мөн бизнесийнхээ үр ашиг, өрсөлдөх чадварыг сайжруулахад нь туслах зорилгоор ашиглагдаж болно.

Эрсдэлийн үнэлгээ бол өөртөө туслах хэрэгсэл. Энэ нь ажил олгогчид болоод бизнесүүдийг ажиллах хүчнийхээ оролцоотойгоор аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой асуудлуудыг засах, зардлын хэмнэлттэй шийдлийг олж тогтоох боломжийг олгодог. Эрсдэлийн үнэлгээг ашиглан ажил олгогчид болон бизнесүүд ажлын байранд нь үүсч буй эрсдлүүдийг тодорхойлж, үнэлэх, мөн үр дүнд нь үндэслэн эрсдэлийг хянахын тулд тохиромжтой аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлдэг.2 Эрсдэлийн үнэлгээг хамгийн аюултай нөхцөл байдлууд хамгийн түрүүнд хянагдаж, хамгийн бага магадлалтай буюу хамгийн бага хохирол учруулах магадлалтай эрсдлүүдийг арай хожуу хянах зэргээр эрэмбэ тогтооход ашиглаж болдог. Энэ нь мөн зардлын хувьд үр ашигтай байдаг. Өдөр тутмын ХАБЭМ-н асуудлуудаа шийдвэрлэхдээ эрсдэлийн үнэлгээг ашигласнаар ЖДБ-ууд гадаад экспертүүд, зөвлөхүүд, эсвэл тэдэнд юу буруу байгаа, хэрхэн асуудлаа шийдэх вэ (хэдийгээр тэд мэдээж ийм хүмүүсээс зөвлөгөө, тусламж хүсдэг ч гэсэн) гэдэг дээр хэт хараат болохгүй байх (энэ нь их зардалтай байдаг)-с сэргийлүүлдэг. Эрсдэлийн үнэлгээг хэн ч хийсэн, бүр гаднаас үйлчилгээ авсан ч, эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах, үр дүнд нь суурилан сайжруулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх нь ажил олгогчийн гарцаагүй үүрэг хариуцлага байдаг.

ХАБЭМ-ыг үргэлж ойлгоход хэцүү, ажил олгогч болон менежерүүдийг бизнес хийхэд нь улам хэцүү болгодог маш их бичиг цаасны ажил, улаан тууз, зардал, уйтгартай дүрэм журмууд гэж хардаг. Бүр ингэж боддоггүй хүмүүс ч цөөн тооны осолтой, эсвэл бүр осолгүй байсан гэж итгэдэг бөгөөд ихэнхи ослоос өнөө үед зайлсхийх боломжгүй байдаг гэж итгэх нь бий.

Хүмүүс ерөнхий ойлголтоо ашиглаад сайн ажиллана гэдэгт найдах явдал үнэндээ ямар нэг зүйл буруу болох хүртэл л үргэлжилдэг. Энэ нь хэн нэг хүн нас барсан, эсвэл хүнд гэмтсэн гэсэн үг
тул хүн өөрөө ухамсраараа аюулгүй ажиллах ёстой гэсэн бодол нь гэнэтхэн маш буруу хандлага байсан нь харагдаж эхэлдэг. Маш олон ажил олгогчид хэн нэг ажилчнаа хүндээр бэртэж гэмтэхээс

---

[1] Жижиг Байгууллагуудын Ажлыг Сайжруулах нь. Женев, ОУХБ Ажлын Орчин ба Хөдөлмөр Эрхлэлтийн Хөтөлбөр, 2007, нэвтрэх: http://ww.ilo.org/travail/whatwedo/instructionmaterials/WCMS_152469/lang--en/index.htm.

[2] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны удирдамж. Женев, ОУХБ Аюулгүй Ажил, 2001, нэвтрэх: http://www.ilo.org/wcmsp5/groups/public/@dgreports/@dcomm/@publ/documents/publication/wcms_publ_9221116344_en.pdf.

нь өмнө ХАБЭМ-н асуудлыг илүү нухацтай авч үзэж байхгүй яав даа гэж харамсч амьдардаг. Тэгвэл, эрсдэлийн үнэлгээ нь ажил олгогчдод аливаа муу зүйл болохоос өмнө урьдчилж ажиллан, боломжит эрсдлүүдийг тодорхойлж, аливаа асуудал байгаа нь илэрсэн бол засч залруулах арга хэмжээг ямар нэг осол, эсвэл өвчлөл үүсэхээс өмнө авч хэрэгжүүлэх боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл эрсдэлийн үнэлгээ нь ажил олгогчдод бизнесээ илүү аюулгүй, эрүүл байдлаар явуулах, ажлын чанар ба бүтээмж сайжрахын ашиг тусыг хүртэхэд тусалдаг.

## Жижиг ба дунд байгууллага гэж юу вэ?

ЖДБ(айгууллага) гэсэн товчлол нь Европын холбооны орнууд болон Дэлхийн Банк, Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн Худалдааны Байгууллага гэх зэрэг олон улсын байгууллагуудад нийтлэг ашиглагддаг жижиг ба дунд хэмжээтэй байгууллагуудыг нэрлэдэг. “Жижиг ба дунд бизнес” буюу “ЖДБ(изнес)” гэсэн нэр томъёо нь Америкийн Нэгдсэн Улсад давамгай хэрэглэгддэг.

ЖДБайгууллага эсвэл ЖДБизнес гэдэг нь яг юуг бүрдүүлж байгаа талаар стандарт тодорхойлолт байхгүй. Гэхдээ Европын Холбоо энэ ойлголтын стандартчилж эхэлж байгаа. Аж ахуйн нэгж байгууллагууд Европын Холбооны 2003/361/EC удирдамжид заасан шалгууруудыг хангаж байвал микро, жижиг ба дунд байгууллага (ЖДБ) гэсэн ангилалд багтана. Үүнийг доор тайлбарлаж үзүүлэв. Мөн түүнчлэн, ажилтны тоо, нийт эргэлтийн хөрөнгийн хэмжээ, эсвэл балансын дүнгийн аль нэг юм уу, хэд хэдэн хязгаарт нь багтаж байгаа бол ЖДБ гэж тооцогдоно.

| Компанийн төрөл | Ажилтнууд | Эргэлтийн хөрөнгө | эсвэл | Балансын дүн |
|---|---|---|---|---|
| **Дунд хэмжээтэй** | < 250 | ≤ 50 сая евро | | ≤ 43 сая евро |
| **Жижиг** | < 50 | ≤ 10 сая евро | | ≤ 10 сая евро |
| **Микро** | < 10 | ≤ 2 сая евро | | ≤ 2 сая евро |

АНУ-д, жижиг бизнесийн тодорхойлолтыг засгийн газрын нэг хэлтэс болох Жижиг Бизнесийн Захиргаа, Хэмжээний Стандартын Оффис нь гаргасан байдаг. АНУ Хойд Америкийн Байгууллага Ангиллын Системийн кодчлогдсон салбар тус бүрээр хэмжээ тодорхойлох стандартыг сонгосон. Энэ ялгаа нь салбарын ялгааг илүү авч үзэх гэсэн зорилготой. “Жижиг бизнес”-ийг тодорхойлох ихэнхи нийтлэг стандарт хэмжээ нь дараах байдлаар тодорхойлогджээ:

→ Ихэнхи үйлдвэрлэлийн болон уул уурхайн салбарт 500 ажилтан.

→ Бөөний худалдааны салбарт 100 ажилтан.

→ Ихэнхи жижиглэн худалдаа болон үйлчилгээний салбарт жилийн орлого нь 7 сая ам.доллар.

→ Ихэнхи ерөнхий ба хүнд барилгын салбарт жилийн орлого нь 33.5 сая ам.доллар.

→ Бүх тусгай худалдааны гэрээтэй байгууллагуудад жилийн борлуулалт нь 14 сая ам.доллар.

→ Ихэнхи хөдөө аж ахуйн салбарт орлого нь 0.75  сая ам.доллар. 3

[3] АНУ-ын Жижиг Бизнесийн Захиргаа, Хэмжээний Стандартын Оффис, АНУ, нэвтрэх: http://www.sba.gov/content/summary-size-standards-industry.

## Яагаад жижиг ба дунд хэмжээтэй байгууллагад фокуслаж байна вэ?

Юуны өмнө, ЖДБ-ууд нь осол, өвчлөлийн тоогоор их өндөрт тооцогддог – жижиг байгууллагууд ослын тоогоороо 100-с дээш ажилтантай байгууллагаас 20 хувиар олон, 1000 ажилтантай байгууллагаас 40 хувиар олон тохиолдолтой байдаг. Энэхүү асуудлыг хэрхэн шийдэх вэ гэдгийг ойлгохын тулд бид жижиг байгууллагууд яагаад илүү эмзэг байдаг, мөн яагаад ЖДБ-уудын аюулгүй байдал, эрүүл мэндийн менежмент муу, ХАБЭМ-н дүрэм журмыг хэрэгжүүлэхдээ дутагдалтай байна вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй юм. Энэ нь дараах шалтгаантай байж болно:

→ Байгууллагад нь аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтэн дутмаг.

→ Гаднаас авах ХАБЭМ-н үйлчилгээг авах боломж дутмаг.

→ ЖДБ-уудын ажил олгогчид болон ажилчид хязгаарлагдмал туршлагатай, ихэвчлэн суурь муутай, богино хугацаанд л ажиллаж байгаа буюу бизнесээ эхлээд л шууд бизнесийн үйл ажиллагаанд хурдан орсон байдаг.

→ Мэдээлэл ба сургалт авах боломж хязгаарлагдмал.

→ “Аюулгүй” машин тоног төхөөрөмжийг юу бүрдүүлдэг талаар хязгаарлагдмал мэдлэгтэй.

→ ЖДБ-уудад холбоод бага байдаг (үйлдвэрчний эвлэлүүдтэй байх нь ХАБЭМ-н нөхцөл илүү сайжрахад хувь нэмэртэй байдаг).

→ Сайжруулалтын зардлыг хэмнэдэг – ЖДБ-н ажил олгогчид, нэг талаас, осол ба өвчлөл, түүнтэй холбоотой гарах зардал, нөгөө талаас, бүтээмж ба ашигт байдлын хоорондох уялдааг сайн олж хардаггүй.

Тиймээс, ЖДБ-ыг илүү эмзэг болгож байгаа олон хүчин зүйл байгаа – гэвч эдгээр нь эрсдэлийн үнэлгээ рүү ороод ирэхээр, тэдгээр нь зохицуулалтын хөгөнд бүжиглэх буюу харгалзан үзэж, шийдвэрлэх зүйлс болж ирдэг. Эрсдэлийн менежентийн нэг хэсгийн хувьд эрсдэлийн үнэлгээ нь олон оронд хуулийн шаардлага болсон. Ажил олгогчид ажлын байруудаа эрсдэлийн үнэлгээ хийх үүрэг хариуцлагыг хүлээж байгаа ч томоохон компаниудын ажил олгогчид энэ үүргээ өөрийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд шилжүүлэх боломжтой байдаг. Харин ЖДБ-ууд болон микро байгууллагуудад өөртөө аюулгүй байдал хариуцсан ажилтан ажиллуулах боломжгүй бйдаг. Харин байгууллагуудад зориулан эрсдэлийн үнэлгээг төлбөртэйгөөр хийж өгдөг ХАБЭМ-н үйлчилгээнүүд байдаг. Гэвч жижиг болон микро байгууллагуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг хянана гэдэг нь тийм хэцүү ажил биш. ЖДБ ажиллуулж байгаа ажил олгогчид ажилчиддаа мэдээлэл, заавар олгож итгэл бий болгох, тэдэнд туслах замаар өөрсдөө эрсдэлийн үнэлгээгээ хийж болно. Ажлынхаа талаар мэдэж байгаа, ерөнхий мэдлэгтэй, мөн энэхүү зааврыг уншиж судалсан ажил олгогч ажил дээрх боломжит эрсдлүүдээ тодорхойлж, осол ба өвчлөлөөс сэргийлэх буюу бууруулах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж чадна.

Энэ бол энэхүү сургалтын гарын авлагын зорилго: итгэлтэй байдлыг бий болгох, ЖДБ-уудын эзэд ба ажилчдыг хүчитгэж, өөрсдийн эрсдэлийн үнэлгээгээ хийх чадвартай байснаар ажил олгогчид, ажилчид аль аль нь ашиг шимийг нь хүртэх нөхцөл юм.

# Сургалтын багцын талаар

Эрсдэлийн үнэлгээг ингэж хийх ёстой гэж тогтоосон арга зам байхгүй, заримдаа толгой эргэмээр олон төрлийн мэдээлэл, арга аргачлалууд байдаг. Эдгээрт суурилан, мөн эдгээрийг авч үзсэнээр, бид энэхүү гарын авлагад их энгийн, хялбарханаар шууд авч хэрэгжүүлж болохуйц арга барилаар аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээ хийж болно гэж итгэсэн аргыг сонгон авч тайлбарлаж байна.

Сургалтын багц нь хэрэглэхэд амар материал агуулж байгаа ба эрсдэлийн үнэлгээ хийж үзүүлсэн олон жишээ, шууд аваад ашиглаж болох эрсдэлийн үнэлгээний загварыг багтаасан. Тэдгээрийн дэлхий даяарх ЖДБ-ууд аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартаа сайжруулж, бизнесийн гүйцэтгэлээ сайжруулахад ашиглаж болно.

## Зорилтот бүлэг

Гол зорилтот бүлэг нь ЖДБ-н ажил олгогч, ажилчид боловч бусад төрлийн байгууллагууд ЖДБ-тай хамтран ажиллах ажилдаа ашиглах, эсвэл тэднээс авдаг үйлчилгээгээ сайжруулахын тулд энэ гарын авлагад агуулагдсан мэдлэг, мэдээллийг ашиглах, сургалт зохион байгуулах, эсвэл ажилд нь эрсдэлийн үнэлгээ хийхдээ ашиглаж болно. Тэдгээр байгууллагуудад дараах орж болно:

→ Ажил олгогчдын байгууллагууд

→ Үйлдвэрчний эвлэлүүд

→ Бизнес хөгжлийн үйлчилгээ

→ Хөдөлмөрийн байцаагчид

→ Төрийн байгууллагууд, тухайлбал аюулгүй байдал эрүүл мэнд хариуцсан байгууллагууд

→ Хамтын ажиллагааны байгууллагууд4

→ Эмэгтэйчүүдийн байгууллагууд

→ Орон нутгийн Засгийн Газрын байгууллагууд

→ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн байгууллагууд

→ Бүтээмжийн институцууд

→ Бичил санхүүгийн институцууд

→ Нийгэм эдийн засгийн байгууллагууд.5

## Сургалтын багцын зорилго

Энэхүү сургалтын багц нь ЖДБ ажиллуулдаг буюу ЖДБ-д ажилладаг хүмүүс болон ЖДБ-уудтай хамтран ажилладаг буюу тэдэнд үйлчилгээ үзүүлдэг талуудад ажлын байран дахь ХАБЭМ-н нөхцлийг сайжруулахад нь туслах зорилгоор боловсруулагдсан. Энэ зорилгоо дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлж байна:

[4] "Хамтын ажиллагааны" гэсэн нэр томъёо нь өөрсдийн нийтлэг эдийн засгийн, соёлын болон нийгмийн хэрэгцээ болон ашиг сонирхлыг хангах зорилгоор сайн дураараа нэгдсэн хүмүүсийн буюу хамтран эзэмшиж, ардчилсан байдлаар хянаж явдаг байгууллагуудын автономит нийгэмлэгийг хэлж байгаа.

[5] Эдийн засгийн их том хувь нь зөвхөн хөрөнгө оруулагчдад гэлтгүй ашиг олох зорилгоор зохион байгуулагдсан байдаг. Нийгэм эдийн засгийн гэж нэрлэгддэг, хамтын ажиллагааны, хоёр талын нийгэмлэгүүд, ашгийн бус нийгэмлэгүүд, сангууд, нийгмийн байгууллагууд нь олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, сая сая ажлын байр бий болгодог. Бодлого тодорхойлогчид бизнесийн орчныг сайжруулах гэж ажиллахдаа, байгууллагуудын онцлог шинж чанарыг харгалзан үзэхэд хүчин зүтгэл гаргах хэрэгтэй, ялангуяа ЖДБ. Эх үүсвэр: Европын Комиссын Байгууллага ба Үйлдвэрлэл. ЖДБ. Нийгэм эдийн засаг - иш татсан баримт бичгүүд, нэвтрэх: http://ec.europa.eu/enterprise/policies/sme/promoting-entrepreneurship/social-economy/index_en.htm

→ Эрсдэлийн үнэлгээ нь ЖДБ-н ажил олгогчдод ажилтнуудтайгаа хамтран зардлын үр ашигтай байдлаар илүү байгууллагаа аюулгүй, эрүүл ажлын газар болгоход хэрхэн туслахыг үзүүлэх.

→ Эрсдэлийн үнэлгээ нь байгууллагын эрсдэлийн удирдлагын нэг хэсгийн хувьд хэрхэн ажил дээрх бэртэл гэмтэл, өвчлөлөөс сэргийлэхэд урьдчилан сэргийлэхийг үзүүлэх.

→ Ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх ерөнхий аргыг заах.

→ Эрсдэлийг хянахдаа хэрхэн хяналтын арга хэмжээний шатлалыг ашиглан арга хэмжээг сонгон авч, хэрэгжүүлэхийг үзүүлэх.

→ Эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийг хянах арга хэмжээгээ сонгож, хэрэгжүүлэх сайн туршлагыг жишээгээр үзүүлэх.

## Сургалтын багцыг хэрхэн хэрэглэх вэ

### *Дэвшүүлж буй таамгууд*

Энэхүү сургалтын багцыг дараах дөрвөн үндсэн таамагт суурилж боловсруулсан:

1. Хэрэв та жижиг бизнес эсвэл байгууллага ажиллуулдаг, ямар ажлууд хийгддэгийг ойлгодог гэдэгтээ итгэлтэй байгаа бол та эрсдэлийг удирдах ерөнхий стратегийнхаа нэг хэсэг болгон эрсдэлийн үнэлгээг өөрөө хийж чадна. Хэдийгээр танд тодорхой ур чадварын түвшин шаардлагатай ч та заавал аюулгүй байдал, эрүүл мэндийн эксперт байх хэрэггүй.
2. Эрсдэлийн үнэлгээг сайн хийхийн тулд та ба таны төлөөлөгчид үндсэн аргуудын талаар сургагдаж болно.
3. Ажилчид тань мөн эрсдэлийн үнэлгээний суурь сургалтанд сууж, (i) сайн эрсдэлийн үнэлгээ хийхэд чухал шаардлагатай ажлын туршлага болон оруулах саналаа оруулах, (ii) эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийг хянах арга хэмжээг ажилчдаа аюулд өртөхөөс нь **өмнө** хамгаалахын тулд хэрэгжүүлж, бодит туршлага болгоход тань туслах.
4. Аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлүүдийг хянах нь заавал тийм хүнд хэцүү биш бөгөөд харин ч таныг чухал зүйлсийг олж авахад тань тусалж болно.Үүнд заавал их зардал шаардлагагүй бөгөөд зөв хийх нь бизнесийг сайн утга учиртай болгоно. Мөн ослоос шалтгаалсан нөхөн олговрын хэмжээ багасах, ингэснээр ажилчдын амь насны болон ажил олгогчийн хариуцлагын даатгалд төлдөг төлбөр багасах зэрэг ашиг тустай.

### *Бүтэц ба агуулга*

Энэхүү сургалтын багцын гол модуль нь дараах зүйлсийг агуулна:

→ Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний таван алхам ба алхам тус бүрээр дасгал ажил.

→ Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцлийг сайжруулахын тулд ашиглах эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал ба тэдгээрийг сонгож хэрэгжүүлэх дараалал, дасгал ажлууд.

→ Сургалтын багц мөн дараах зүйлсийг агуулна:

→ ЖДБ-ууд эрсдэлийн үнэлгээ хийхдээ ашиглаж болон стандарт эрсдэлийн үнэлгээний загвар.

→ ЖДБ-ууд ажилладаг хэд хэдэн салбарт хийж үзүүлсэн эрсдэлийн үнэлгээний  жишээнүүд.

# БҮЛЭГ 1

## Эрсдэлийн үнэлгээний арга зүй – 31 хуудас

# Эрсдэлийн үнэлгээний ерөнхий. ойлголт болон нэр томъёо

Ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний гол концепци нь кино хальсанд гарч байгаа кино шиг тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Энэ нь ажлын байран дахь тодорхой нэг нөхцөл байдлын зургийг аваад өнгөрөхтэй ижил зүйл биш. Ажлын байран дахь хяналт шалгалт л ийнхүү тухайн нэг цаг үеийн нөхцлийг шалгаад өнгөрдөг.

Хэдийгээр ажлын байранд хийсэн аливаа хяналт шалгалтын мэдээллийг эрсдэлийн үнэлгээ хийхдээ ашиглах нь үр ашигтай байдаг ч, бид хяналт шалгалт ба эрсдэлийн үнэлгээ хоёрын ялгааг мэддэг байх шаардлагатай.

Эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх болон энэ үйл явцад багтдаг таван алхмыг нарийвчлан авч үзэхийн өмнө, зарим үндсэн ойлголт болон нэр томъёог тодорхой тайлбарлах хэрэгтэй болов уу.

## Аюул ба эрсдэл

Аюул ба эрсдэл гэдэг үгсийг өдөр тутмын яриандаа хольж хэрэглэх нь түгээмэл байдаг. Гэхдээ, эрсдэлийн үнэлгээ хийхдээ эдгээр ойлголтонд төөрөлдөхөөс сэргийлж, тодорхойлолтыг нь ойлгох, хооронд нь ялгаж чаддаг болох нь чухал юм.

**Аюул** гэдэг нь хүний эрүүл мэнд ба аюулгүй байдалд, эсвэл аливаа эд хөрөнгө, тоног төхөөрөмж, байгаль орчинд хохирол учруулж болох бүхий л зүйлийг хэлнэ. Хохирол учруулах боломжийг аливаа химийн бодис, машин тоног төхөөрөмж, ажлын муу арга барил бий болгож байж болно.

Тиймээс, аюул нь ажилд ашиглагдаж буй түүхий эд материал, тоног төхөөрөмж (багаж хэрэгсэл, машин механизм, гэх мэт), аюултай бодис (тоос, өвчин үүсгэгч микро организмууд, химийн бодисууд, хортон устгагч, дуу чимээ, гэх мэт), тээвэрлэлт, дайвар бүтээгдэхүүн, ажлын байрны аюултай орчин, ажлын байрны муу зохион байгуулалт, ажиллах арга барил, хандлага гэх зэрэг хүнийг гэмтээж, хохироож, өвчлүүлж болох бүхий л зүйл юм. Бүхий л ажлын байранд тоо томшгүй олон аюул оршин байдаг (Ажлын байран дахь аюулыг илрүүлэх талаар Үйл ажиллагаа 1-с үзнэ үү).

**Эрсдэл** гэдэг бол аюулын хүний бие, эд хөрөнгө, тоног төхөөрөмж, эсвэл орчин тойронд гэмтэл, хохирол учруулах магадлал ба учруулах хор хохирлын түвшинг хэлдэг бөгөөд хор хохирлыг урт хугацаанд гарах үр дагаварыг ч хамруулан тооцдог.

**Эрсдэл = Хор хохирлын түвшин x Учрах магадлал**

Аюултай нөхцөл байдал үүсч болох магадлалыг, тухайн нөхцөл байдлаас үүдэн бий болох хор хохирлын түвшинд үржүүлсэн үржвэрийг Эрсдэл гэнэ6.

**Аюул гэдэг бол тухайн нэг химийн бодис эсвэл үйл ажиллагаа өөрөө байдаг, харин эрсдэл бол өөр. Эрсдэлийн түвшин нь түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхээс хамааран өөр өөр байж болно.** Тухайлбал: Хортон устгагч бол өөрөө хортой бодис, тиймээс хортон устгагчийг цацах нь газар тариалан эрхлэгчдэд ноцтой эрүүл мэндийн эрсдэл үүсгэдэг. Гэхдээ тухайн

[6] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны гарын авлага: Женев, ОУХБ, Аюулгүй Ажил, 2001, Үгсийн тайлбар, хуудас 19-20.

газар тариалан эрхлэгч хортон устгагчийн аюулыг зохистой хянаж чадсан бол, эрсдэл нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна гэсэн дүгнэлт гарч болно.

Үүнтэй нэгэн адилаар цахилгаан/220 вольт болон түүнээс дээш/ хүчдэл ч өөрөө аюултай, харин гүйдэл тусгаарлагч бүрээс, автомат унтраалгын систем, гал хамгаалагч, хуримтлагдсан цахилгаан энергийг шавхагч багаж төхөөрөмж, эсвэл хүчдэл/вольт/ хувиргагч трансформатор ашигласнаар эрсдэлийн түвшинг нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байлгаж болно.7

Эрсдэл хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд байгаа эсэхийг үнэлэхэд, эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж байгаа ажилтнуудын хүйс, нас ба ерөнхий эрүүл мэндийн хүчин зүйлсийг анхаарч үзэх нь чухал. Мөн тэдгээр ажилтнууд яг ямар ажил үүрэг гүйцэтгэдгийг бодолцох хэрэгтэй.

## Аюулгүй байдал ба эрүүл мэнд хоёрын ялгаа

Эрсдэлийн үнэлгээ хийхэд, аюулгүй байдлын аюул ба эрсдэл, эрүүл мэндийн аюул ба эрсдэл гэсэн тусдаа ойлголтыг ашигладаг тул эдгээрийн хоорондын ялгааг анхаарч авч үзэх хэрэгтэй. Энэ нь ялангуяа, ажлын байран дахь аюулд өртсөнөөр урт хугацаанд бий болох эрүүл мэндийн үр дагаврыг үнэлж, зохих эрсдэлийн хяналтыг бий болгох тохиолдолд илүүтэй ашиглагдана.

**Аюулгүй байдлын аюул ба түүнээс үүдэх эрсдэл** нь илүү баримттай байдаг тул ажил олгогчид энэ талд илүү ойлголттой байж, анхаарал тавьдаг. Тухайлбал, хаалт хамгаалалтгүй үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж, тасдагч машин зэрэг нь илэрхий аюул. Ийм машин төхөөрөмжөөс болж ажилтан гэмтэхэд үр дүн нь тэр дороо нүдэнд илэрхий харагдана.

**Эрүүл мэндийн аюул ба түүнээс үүдэх эрсдэл** нь ихэнхидээ бага баримтжуулагдсан байдаг тул ажил олгогч энэ асуудлыг шууд хариуцан шийдвэрлэхдээ хойрго байдаг. Ажлаас шалтгаалсан эрүүл мэндийн асуудал нь урьдчилан мэдэгдэж илрэхгүй, зарим тохиолдолд амьдралд маш хожуу илрэх тохиолдол ч байдаг. Эрт оношилж, хэт хүндрүүлэхээс нь өмнө өвчнөөс урьдчилан сэргийлэх нь нэгэнт хохирсон эрүүл мэндийг улам муудахаас, цаашлаад амь насыг аврахад чухал нөлөөтэй. Дахин давтагдсан, бага хэмжээгээр аюулд өртөж байгаа процесс долоо хоногоор, сараар, жилээр үргэлжилж байгаа бүгдийг анхааран авч үзэх хэрэгтэй. Дараах жишээ байж болно:

→ Хортон устгагч (шавьж устгагч, мөөгөнцөр устгагч, зэрлэг устгагч, гэх мэт) химийн бодист хордох. Нэн даруй нөлөө үзүүлж “хурц” хордлогод орохоос гадна, зарим хортон устгагч нь 20 ба түүнээс дээш жилийн дараа илэрдэг хорт хавдар үүсгэдэг байх жишээтэй. Ийм үр нөлөө нь ихэвчлэн бага хэмжээгээр боловч байнга хордсоных байдаг.

→ Органик ургац эсвэл амьтны тоосонцорын нөлөө нь олон жилийн хугацаанд бий болдог багтраа /астма/ үүсгэж болно. Энэ нь мөн л урт хугацаанд давтагдсан нөлөөллөөс үүдэлтэй бөгөөд дахин дахин сэдэрдэг урт хугацааны өвчин болон “багтраа сэдрэх” гэж нэршсэн хурц хэлбэрийн өвчлөлд хүргэж болзошгүй.

**Ажлын стресс**: Эрсдэлийн үнэлгээнд стрессийн нөлөөг мөн анхааран авч үзэх хэрэгтэй. Стресс байгаа үгүйг тодорхойлоход амар биш бөгөөд мөн л урт хугацаанд хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлдэг. стресс нь “нийгэм-сэтгэл зүйн аюул” -ын төрөлд багтана.

7

## Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ

Бизнесийн эсвэл аж ахуйн нэгж байгууллагын хэмжээ болон эрсдэлийн түвшин, аюулуудаас хамааран эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ өөр байж болно. Эрсдэлийг үнэлгээг дараах түвшинд аюулгүй байдал ба эрүүл мэндийг үнэлэхэд ашиглаж болох юм:

→ Байгууллагын бүхий л үйл ажиллагаа, үйл явц, нийт ажилтныг хамруулан байгууллагын хэмжээнд,

→ Машин засварын цех гэх зэрэг тодорхой нэг хэсэг ажлын байрыг, эсвэл тодорхой тооны ажилтан юм уу, ажилтнуудын бүлгийг хамруулан,

→ Тодорхой бүлэг, ажилтнууд болон ажилтнуудын бүлэгт аюул учруулж болох үйл ажиллагаа эсвэл үйл явцыг, тухайлбал хүнд ачаа өргөдөг үйл ажиллагааг, хамруулан хийж болно.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн өнцгөөс бизнесийг тодорхойлох нь

Зарим тохиолдолд бизнесийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, түүний бүрэлдэхүүн хэсэг гэхчлэн өөр өөр нэр томъёог хэрэглэн байгууллагыг тодорхойлдог. Аюулгүй байдал, эрүүл мэндийн талаас бол, “**ажлын байр**” гэдэгт хөдөө аж ахуйн салбар, фермийн эдлэн газар, барилгын талбай, жижиг засварын газар, том засвар үйлчилгээний төв, агуулах, оффис гэхчлэн бүхий л хүн ажилладаг байршил орно. “**Байгууллага**” гэдэгт томоохон нэгж, эсвэл “**аж ахуйн нэгж байгууллагыг”** бүхэлд нь ойлгоно. Иймд, эрсдэлийн үнэлгээг байгууллагын хэмжээнд олон тооны ажлын байрыг хамруулан хийх үү, олон эдлэн газар болон малын саравчтай фермд хийх үү, олон жижиг хэсгүүдтэй засварын цэгт хийх үү, эсвэл зөвхөн нэг ажлын байранд хийх үү гэдгээ сонгох шаардлагатай юм. Хэрэв байгууллага жижиг бол нэг л ажлын байртай байж болох бөгөөд энэ тохиолдолд “ажлын байр” ба “байгууллага” гэдэг ойлголтод нэг л газрыг хэлнэ.

## Ажлын байрыг дундаа ашигладаг бол яах вэ?

Хэрэв та ажлын байраа өөр ажил олгогчтой, эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй хамтран ашигладаг бол та хоёр хоёулаа:

→ Аль нэг тал нь нөгөө талдаа нөлөөлж болох өөрийн үйл ажиллагааны онцлог эрсдлүүдийг хэлж,

→ Аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлүүдийг хянах асуудал дээр хамтран ажиллах хэрэгтэй.

Нөгөө ажил олгогч юм уу, хувиараа хөдөлмөр эрхлэгч хүндээ таны явуулж буй үйл ажиллагаа тэдэнд ямар эрсдэлийг бий болгож байгаа, түүнийг хянах талаар та ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагаа хэлэх нь зайлшгүй шаардлагатай. Мөн та өөрийн тань ажилтнууд болон ажлын байранд тэднээс ирж болох эрсдлүүдийг бодолцох ёстой.

Хоёр өөр байгууллагын ажилтнууд нэг ажлын байранд ажиллаж байгаа тохиолдолд, эрсдэлийн үнэлгээ хийхээр томилогдсон хоёр талын ажилтнууд хоорондоо эрсдлүүд болон тэдгээрийг хяналтандаа авахын тулд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл солилцох хэрэгтэй.

# Эрсдэлийн үнэлгээ хийх нь

## Эрсдэлийн үнэлгээ гэж юу вэ?

Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ гэдэг нь хүний биед гэмтэл, өвчлөл учруулж болох юу танай байгууллагад, эсвэл үйл ажиллагаанд байна вэ гэдгийг анхааралтайгаар шалгаж буй явдал юм. Эрсдэлийн үнэлгээ хийснээр та ажилтнууд болон олон нийтэд учруулж болох аюул, эрсдлээс урдчилан сэргийлэхийн тулд эрсдэлийг хянах арга хэмжээг хангалттай авч хэрэгжүүлсэн байгаа юу, эсвэл хэрэгжүүлэх шаардлагатай байна уу гэдгийг жигнэж үзэх юм. Зорилго нь нэг ч хүн бэртэж гэмтэхгүй, эсвэл өвчлөхгүй байх юм.

Эрсдэлийн үнэлгээ хийхэд байгууллагад оршин байгаа аюулуудыг тодорхойлж (тэдгээр нь эрхэлж байгаа үйл ажиллагаанаас үүдэлтэй байна уу, эсвэл ажлын орчноос болж байна уу гэдгийг хамт тодорхойлно), тэдгээрт харгалзах эрсдэлийн түвшин хэр байгаа вэ гэдгийг үнэлнэ. Эрсдэлийн түвшин ямар түвшинд байгааг тодорхойлоходоо хэдийнэ авч хэрэгжүүлж эхэлсэн эрсдэлийг хянах арга хэмжээнүүд юу байна, эсвэл авч хэрэгжүүлээгүй тул шинээр төлөвлөж хийх шаардлагатай арга хэмжээнүүд юу байна вэ гэдгийг харгалзан үзэж, нэг ч хүнийг гэмтээхгүйн тулд юу хийх ёстойг шийднэ. Эрсдэлийн үнэлгээний үр дүн нь ажил олгогчдод ямар арга хэмжээг авч хэрэгжүүлснээр эрсдэлийг амжилттай хянах вэ гэдэг дээр сонголт хийхэд нь туслах ёстой. Ажилтнууд болон бусад талууд ажил олгогчид эрсдэлийг хянах тохиромжтой(тохиромжтой гэдэг нь компаниас гарах зардал ба арга хэмжээний үр дүн хоёрыг балансалж сонгохыг хэлнэ, орч.) арга хэмжээ аваагүйгээс үүдэн аюулд өртөхгүй байх, аюулаас хамгаалагдах эрхтэй. Хууль таныг эрсдэлийг устгах ёстой гэж шаардахгүй, харин хүмүүсийн эрүүл мэндийг чадах чинээгээрээ хамгаалахыг шаардаж байгаа. Үүний тулд та эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг хянах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ёстой юм.8

Эрсдэлийн үнэлгээ нь тухайн үнэлгээ хийх үед оршин байсан бодит нөхцөл байдал дахь эрсдэлийн түвшинд зориулсан арга хэмжээг л авч үздэг. Аюул БҮРийг тусад нь авч үзэж, хэний аюулгүй байдал ба эрүүл мэндэд нөлөөлөх вэ, ямар үр дагавартай байх вэ гэдгийг тодорхойлох нь чухал. Учир нь аюул бүр магадлалын түвшин ба хохирол учруулах хэмжээгээрээ ялгаатай тул эрсдэлийг нь хянахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь ч өөр байна.

**Эрсдэлийн үнэлгээний түлхүүр нь: үйл явцыг хэтрүүлэн хүндрүүлэхгүй байх.** Эрсдэлийн үнэлгээ хийхдээ, тухайн үнэлгдэж буй ажлын нөхцөл байдал нь илүү аюулгүй, эрүүл болоход анхаарч, түүний тулд эрсдэлийг хянах ямар арга хэмжээ авах вэ гэдгийг шийдэхэд л төвлөрөх нь чухал. Иймд, эрсдэлийн зэрэг нь хэр байна вэ гэдгийг тогтоохын тулд урт удаан цаг зарцуулж ярилцах, тэр алхам дээр гацах хэрэггүй юм. Эрсдэлийг хянах арга хэмжээг сонгож, тэдгээрийг хэрхэн бодитоор хэрэгжүүлэх вэ гэдэгт л төвлөр. ЖДБ дахь эрсдлүүд болон тэдгээрийг хянах аргууд нь ялангуяа таны хэдийн мэддэг зүйлс байх нь элбэг бөгөөд хэрэгжүүлэхэд амархан байдаг. Тухайлбал, хэрэв танай ажилтнууд хүнд бараа материал өргөдөг ажил хийдгээс нуруугаа өвтгөх аюултай бол, эсвэл ажлын байранд хальтирах, бүдрэх аюул оршин байдаг бол та эдгээр онцлогоо аль хэдийнэ мэдэж байж болно. Ийм тохиолдолд, та тухайн мэдэгдэж байгаа эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохистойгоор хэрэгжүүлсэн байна уу гэдгээ шалгаж болно. Та өөрөө холбогдох менежерүүд болон ажилтнуудыг оролцуулан эрсдэлийн үнэлгээгээ хийж болно. Аль болох олон ажилтныг оролцуулж, үнэлгээний үр дүнг тэд гаргасан байхыг нь дэмжээрэй.

[8] Хөдөлмөрийн Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын Удирдах Газар, Их Британи, нэвтрэх хаяг: http://www.hse.gov.uk/pubns/indg163.pdf.

## Эрсдэлийн үнэлгээний таван шатат үйл явц

Эрсдэлийн үнэлгээг хийх хамгийн энгийн бөгөөд шууд ашиглаж болохуйц аргаар хийе гэвэл ажил олгогч, эсвэл энэ ажилд томилогдсон ажилтны төлөөлөл та, бүх ажилтнуудаа оролцуулан дараах таван алхмыг дагаж хийгээрэй:

**Алхам 1:** **Аюулыг илрүүл /тодорхойл.**

**Алхам 2:** **Хэн хэрхэн хохирч болохыг тодорхойл.**

**Алхам 3:** **Эрсдэлийг үнэл – эрслдийг хянах арга хэмжээ юу байж болохыг тодорхойлж, алийг нь сонгохыг шийд, ингэхдээ дараах хоёр дэд алхмыг хэрэгжүүл:**

***Алхам 3.А:*** *одоогийн байдлаар эрсдэлийг хянах гэж хэрэгжүүлж буй ямар арга ` хэмжээнүүд байна вэ гэдгийг тодорхойл*

***Алхам 3.Б:*** *Эрсдэлийг хянах ямар арга хэмжээнүүд шинээр хэрэгжүүлж болох вэ гэдгийг тодорхойл*

***3.А ба 3.Б-д*** *заасан хяналтын арга хэмжээг тодорхойлохдоо "эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал"-ыг ашиглан, аль арга хэмжээг сонгохыг шийдээрэй:*

- Эрсдэлийг хянах арга хэмжээ 1: Аюулыг устгах буюу орлуулах
- Эрсдэлийн хянах арга хэмжээ 2: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерингийн аргуудыг ашиглах
- Эрсдэлийг хянах арга хэмжээ 3: Аюулгүй ажиллах арга барил, туршлага, зохион байгуулалт, мэдээ мэдээлэл түгээх, сургалт өгөх аргуудыг ашиглах
- Эрсдэлийг хянах арга хэмжээ 4: Эрүүл ахуй ба ахуй байдлыг сайжруулах аргууд
- Эрсдэлийг хянах арга хэмжээ 5: Хүнийг хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах арга
- Эрсдэлийг хянах арга хэмжээ 6: Эрүүл мэндийн үзлэг, эмчийн хяналтын үзлэгүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх (эмчийн хяналтын үзлэгт төрөл бүрийн шинжилгээ, рентген зураг багтана, орч.)

**Алхам 4:** Эрсдэлийг хянах аль арга хэмжээг хэн хэрэгжүүлэх вэ, хэзээ хийх вэ гэдгийг бүртгэх. Тухайн хяналтын арга хэмжээгээ хэрэгжүүлэх (хэн нь юуг хийх вэ, хэзээ гэхэд хийсэн байх вэ гэдгийг шийдсэн байна).

**Алхам 5:** Эрсдэлийн үнэлгээгээ дахин хянаж, дүгнэн шинжилж, шаардлагатай бол дахин шинэчилж хийх.

## Эрсдэлийн үнэлгээний загварууд

Дээрх таван алхамд суурилсан, шууд аваад ашиглаж болохоор эрсдэлийн үнэлгээний загвар хуудсыг энд үзүүлж байна. Ажил мэргэжлийн олон өөр салбарын эрсдэлийн үнэлгээнүүд энэхүү загварыг ашиглан хийгддэг (Бүлэг 3-г үзнэ үү). Дараагийн хуудсанд эрсдэлийн үнэлгээ хийх үе шатуудыг энгийнээр тайлбарлан хүргэж байна.

## ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗАГВАР **Байгууллагын нэр:** **Хэлтэс/нэгж:** **Огноо:**

<table>
<tr><th>АЛХАМ 1:</th><th>АЛХАМ 2:</th><th>АЛХАМ 3:</th><th></th><th colspan="3">АЛХАМ 4:</th></tr>
<tr><th>Ямар аюул байна вэ?</th><th>Хэн хэрхэн хохирч болох вэ?</th><th>Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?</th><th>Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?</th><th colspan="3">Эрсдэлийг хянах арга хэмжээг бодитоор хэрхэн хэрэгжүүлэх вэ?</th></tr>
<tr><td rowspan="2">Аюулуудыг илрүүл:<br>▪ Ажлын байрыг тойрон алх<br>▪ Ажилтнуудаас ямар аюул байгаа гэж бодож байгаа талаар нь асуу<br>▪ Үйлдвэрлэгчээс өгсөн аливаа заавруудыг шалга<br>▪ Үйлдвэрчний эвлэл, эсвэл ЖДБ-уудын холбоо гэх зэрэг байгууллагуудтай холбогдож нийтлэг аюулуудын талаар мэдээлэл ав<br>Урт хугацаанд муугаар нөлөөлдөг аюулуудыг бүү мартаарай.</td><td rowspan="2">Хүмүүсийг бүлэглэн ангил. Ингэхдээ дараах зүйлсийг санаарай:<br>▪ Зарим ажилтнууд тодорхой хэрэгцээтэй<br>▪ Ажлын байран дээрээ байнга байдаггүй хүмүүс<br>▪ Хэрэв та өөр байгууллага, эсвэл хүмүүстэй ажлын байраа хувааж ашигладаг бол таны ажил тэдэнд ямар аюул учруулж болох талаар бод<br>▪ Олон нийт, орчны ард иргэдийг бодолц<br>Тухайн нэг аюул нь хэрхэн хохирол учруулах талаар тодорхой бичих.</td><td rowspan="2">Аливаа хохирол учрах магадлалыг бууруулсан, эсвэл хохирлын ноцтой байх түвшинг бууруулсан ямар нэг арга хэмжээ хэрэгжүүлж байвал тэдгээрийг жагсаан бичих.</td><td rowspan="2">Та эрсдэлийг хамгийн үр дүнтэй аргаар багасгах ёстойгоо санаарай (Энэ нь заавал хамгийн үнэтэй арга замыг биш, ажил олгогчийн зардлыг нь гаргаж болохуйц арга хэмжээг, түүний ашиг тустай харьцуулан үнэлснээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэхийгээ сонгохыг хэлж байгаа, орч.). Үүнийг хийх хялбар арга нь та одоо эрсдэлийг ямар аргаар хянаж байгаа сайн туршлагаа харьцуулж үзэх юм. Хэрэв одоо хийж байгаа ба хийх гэж байгаа хоёрын хооронд ялгаа байвал, нэмэлтээр юу хийх шаардлагатайг жагсаан бичнэ.</td><td colspan="3">Хянах арга хэмжээг эрэмбэлэхээ бүү мартаарай. Өндөр эрсдэлтэй, ноцтой үр дагавартай эрсдлүүдийг хамгийн түрүүн хяналтандаа авахаар төлөвлөөрэй.</td></tr>
<tr><td>Хэн хийх</td><td>Хэзээ хийх</td><td>Хийсэн эсэх</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td colspan="3"></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td colspan="3"></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td colspan="3"></td></tr>
<tr><th>Алхам 5.</th><th></th><th></th><th></th><th colspan="3"></th></tr>
<tr><td colspan="7">Өөрийн хийсэн эрсдэлийн үнэлгээгээ цаашид ажлаа улам сайжруулахын тулд, эсвэл хамгийн багадаа хоцрогдож хуучруулахгүйн тулд эргэн хяна. Ажлын байранд чинь томоохон өөрчлөлт орсон бол эрсдэлийн үнэлгээгээ дахин шалгаж, шаардлагатай бол өөрчлөлт хийж байгаарай.</td></tr>
<tr><td colspan="7">Үнэлгээ хийсэн: ....................................................... (Гарын үсэг)</td></tr>
</table>

## Эрсдэлийн үнэлгээг хэн хийдэг вэ?

Олон оронд, эрсдэлийн үнэлгээ хийх нь ажил олгогчийн үүрэг байдаг.

Ажил олгогч дараах үүрэгтэй:

→ Ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой бүхий л асуудалд ажилтны эрүүл, аюулгүй байдлыг хангах.

→ Эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах; ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх хүнийг сонгох, тэр хүнийг ур чадвартай байлгах.

→ Эрсдэлийг үнэлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

→ Ажилтнууд болон тэдгээрийн төлөөлөлтэй ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний зохион байгуулалт, үнэлгээ хийх хүмүүс болон эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх.

→ ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийдэг байх.

→ Үнэлгээний бүртгэлүүд хөтлөх, ингэхдээ юун түрүүн ажилчид ба/буюу тэдний төлөөлөлтэй зөвлөлдөх, эсвэл тэднийг ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд оролцуулах, бүртгэлүүдийг тэдэнд ил болгох.

→ Аюулд өртөж болох хүн бүрийг аливаа аюул, түүний хор хохирол, аюулаас хэрхэн өөрсдийгөө хамгаалж, урьдчилан сэргийлж байх талаар мэдээлэлтэй байлгах.

Хэрэв та ажил олгогчийн хувьд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх чадвартай итгэлтэй биш байвал та ажилтнуудыг бэртэл гэмтэл, өвчлөлөөс сэргийлж, хамгаалах үйл ажиллагааг явуулах хэн нэг ур чадвартай хүнийг томилж болно.

Хэрэв та ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх хэн нэг төлөөлөгчийг томилсон бол тэр хүн эсвэл хүмүүс юун түрүүн “ур чадвартай” байх хэрэгтэй ба ур чадвартай байна гэдэгт тэд ажлын байр болон хийдэг ажлуудын талаар сайн мэдлэгтэй, сайн туршлагыг хаанаас олж, хэрхэн ашиглах хэрэгтэйг мэддэг, танаас олгосон эрх мэдэлтэй байхыг хэлнэ. Ур чадвартай хүн гэдэг нь гүйцэтгэдэг ажил үүрэг болон түүнийг хийх ажлын орчны талаар сайтар мэдлэгтэй, аюулыг илрүүлж, ЖДБ төрөл болон түвшинг тодорхойлох, эрсдэлийг хянах талаар ойлголттой, бодит амьдрал дээр эрсдэлийг хянах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой талаас төлөвлөх чадвартай, мөн эдгээр үүргээ биелүүлэхэд хэрэгцээтэй эрх мэдэлтэй хүний хэлнэ.

Хэрэв байгууллага дотроосоо хэн нэг хүнийг томилж хийлгэх боломж байхгүй бол, гадаад талаас тодорхой ур чадвартай хүн юм уу, байгууллагын үйлчилгээг авч болно. Энэ тохиолдолд, тэдгээр гаднаас ирэх хүн эсвэл байгууллага нь танай үйл ажиллагааны онцлогийн талаар мэддэг, эрсдэлийг нь үнэлэх чадвартай эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй.

ЖДБ-ын хувьд, ихэнхи тохиолдолд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх хүн нь аюулгүй байдал, эрүүл мэндийн эксперт байх хэрэггүй байдаг, харин дараах зүйлсийг хийх ур чадварыг харуулж байх хэрэгтэй:

1. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх аргын талаар ерөнхий ойлголттой.
2. Энэ ойлголтоо ажлын байран дээрээ ашиглах чадавхитай. Үүнд дараах зүйлс шаардлагатай:
   *a.* аюулгүй байдал, эрүүл мэнд асуудлуудыг тодорхойлох;
   *b.* авах арга хэмжээний хэрэгцээг үнэлж, эрэмбэлэх;
   *c.* эрсдэлийг устгах эсвэл бууруулах боломжууд, тэдгээрийн давуу талыг санал болгох;
   *d.* тэдгээрийн үр нөлөөг үнэлэх;
   *e.* аюулгүй байдал, эрүүл мэндийн сайжруулалт болон сайн туршлагыг сурталчлан таниулах.

3. Туслалцаагүйгээр эрсдэлийг зохих түвшинд үнэлж чадахгүй тохиолдол үүсвэл асуудлыг тодорхойлж, хэн нэгнээс туслалцаа авах талаар зөвлөлдөх чадвартай байх.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг хэнээр хийлгэх вэ гэдэг дээр сүүлийн шийдвэрийг ажил олгогч гаргана. Дараах хүмүүс хийж болно:

- Ажил олгогч өөрөө,
- Ажил олгогчоос томилсон ажилтан(ууд),
- Хэрэв байгууллага дотоод нөөц боломжоороо хийж чадахгүй бол гадны үнэлэгчид болон үйлчилгээ үзүүлэгчид.

**Хэн ч ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг гардан хийсэн байсан, тэр байтугай гадны үйлчилгээ үзүүлэгч хувь хүн эсвэл байгууллага ч хийсэн бай, тухайн үнэлгээний эцсийн хариуцлагыг ажил олгогч хүлээдэг.**

## Ажилчдыг идэвхитэй оролцуулах

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг үргэлж ажилчдыг оролцуулж хийж байх ёстой гэдгийг санаарай. Ажилчид өөрсдөд нь аюул учруулж болох зүйлсийн талаар үргэлж сайн мэдэж байдаг бөгөөд тэдгээр аюулаас үүдсэн эрсдэлийг хэрхэн хянах талаар тодорхой санаа, саналтай байдаг. Мөн тэд хяналтын арга хэмжээг хэрхэн бодит амьдралд хэрэгжихүйц байдлаар, үр ашигтай-зардлаар хийх шийдлийг олоход тань тусална.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх нь ажилчдын үүрэг хариуцлага биш – энэ бол ажил олгогчийн үүрэг хариуцлага – гэхдээ ажилчдыг идэвхитэй оролцуулах нь эрсдэлийг илүү сайн үнэлж, зохистой бөгөөд зардал-үр ашгийн харьцаа сайтай ЖДБ хяналт тогтоох боломжийг нэмэгдүүлдэг.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг ажил олгогч, эсвэл үнэлгээ хийгдэх газраас өөр газар ажилладаг хэн нэг ажил олгогчийн төлөөлөгч хийх ёсгүй. Тэд ажилчид болон ажилчдын төлөөллийг заавал оролцуулах хэрэгтэй. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх процессын өөрийнх нь талаар ажилчидтай зөвлөлдөж, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үр дүнд гарсан аливаа дүгнэлт болон түүний үр дүнд авахаар болсон хяналтын арга хэмжээний талаар мөн тэдэнд мэдээлэл өгч байх хэрэгтэй.

# АЛХАМ 1. АЮУЛЫГ ИЛРҮҮЛЭХ /ТОДОРХОЙЛОХ

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн эсэх |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Алхам 5. | | | | | | |

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний хамгийн эхний алхам бол ажлын байрны бүхий л хэсгүүдийг судалж, ямар нэг хохирол учруулж болох аюул байна уу гэдгийг тодорхойлно. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний процессын хамгийн чухал алхмуудын нэг нь энэ юм. Илрүүлээгүй аюулыг удирдаж чадахгүй шүү дээ. Тиймээс, энэ алхмыг маш сайн нарийвчлалтай, нямбай хийх нь чухал.

Хэрэв та ажлын байранд өдөр бүр ажилладаг бол зарим аюулыг анзаарахгүй байх боломжтой. Тиймээс, аюулыг илрүүлэхдээ дараах зүйлсийг анхаараарай.

Ажил олгогч, эсвэл томилогдсон ажилтны хувьд, эсвэл ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж буй гадны талын хувьд та дараах зүйлсийг хийх ёстой:

→ Ажлын байрны эргэн тойрноор алхаж, ямар зүйлс аюул учруулж болохоор байгааг сайтар ажиглана.
→ Чухам ямар үйл ажиллагаа, үйл явцууд хамгийн их аюултай байна, мөн ажлын байрны аль хэсэг илүү аюултай байгааг тодорхойлно (та шалгах хуудас хөтөлбөл үр дүнтэй байж болно, учир нь ямар ч тохиолдолд ажигласан зүйлсийнхээ талаар тэмдэглэл хөтөлж, түүнийгээ ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний нотлох баримт болгон ашиглах нь чухал байдаг).
→ Ажилчид болон тэдний төлөөллөөс хийдэг ажлынх нь аюулын талаар, ажлын байрны осол болон өвчлөлөөс хэрхэн сэргийлж болох талаар асууж ярилцана. Танд эсвэл гадны талуудад ажиглагдаагүй ямар нэг чухал зүйлсийг тэд мэдэж байх болох шүү дээ.
→ Өмнө гарч байсан осол болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн талаарх түүхийг судална. Энэ нь тэр бүр ил анзаарагдаад байдаггүй аюулуудыг илрүүлэхэд тустай байдаг.
→ Эрүүл мэнд болон аюулгүй байдалд урт хугацаанд хор хөнөөл учруулж байж болзошгүй аюулуудыг бүү мартаарай (тухайлбал, өндөр түвшний дуу чимээ, хортой химийн бодист өртөж буй аюул байж болно).
→ Хэрэв та ямар нэг салбарын холбоо, үйлдвэрчний эвлэл, эсвэл нийгэмлэгийн гишүүн бол тэдэнтэй холбогдож асуу. Тэд маш хэрэгтэй мэдээлэл, заавраар хангадаг.
→ Аливаа химийн бодис болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс өгсөн заавар, гарын авлага, эсвэл мэдээллийн хуудсыг шалгана. Тэдгээр мэдээллүүд бодитой аюулын талаар анхааруулга өгч, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгсөн байдаг.
→ Таны илрүүлж чадаагүй ямар нэг аюул үлдсэн эсэхийг ажилчдаасаа асууж, ярилцаарай.

Аюулыг илрүүлэхэд тань хэрэгтэй туслах хэрэгслүүд:

- Ажлын байранд хийсэн өмнөх хяналт шалгалт, судалгааны тайлан мэдээ
- Аюул/ослын талаарх бичгэн болон аман тайлангууд
- Ажиглалт
- Хэрэв байгууллагад байдаг бол аюулгүй байдал, эрүүл мэндийн хороод / ХАБЭА-н зөвлөл/
- Анхааруулах санамж, тэмдэг
- Үйлдвэрлэгчээс өгсөн мэдээллийн хуудас
- Үйлдвэрлэгчээс өгсөн гарын авлага, заавар
- Зөвлөхүүдийн өгсөн тайлан

Доорх хүснэгтийн эхний баганад мод боловсруулдаг байгууллагад нийтлэг ажиглагддаг гурван аюулыг жишээг тэмдэглэсэн байгаа. Эдгээр нь зөвхөн жишээ бөгөөд таны ажлын байранд үүнээс олон тооны аюул байгаа бол бүгдийг нь энэ жишгээр жагсааж бичнэ.

| **Алхам 1** | **Алхам 2** | **Алхам 3** | | **Алхам 4** | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | **Хэн хийх** | **Хэзээ хийх** | **Хийсэн эсэх** |
| Модны тоосонд өртөх | | | | | | |
| Машин тоног төхөөрөмж | | | | | | |
| Гар ажиллагаа | | | | | | |
| **Алхам 5.** | | | | | | |

# АЛХАМ 2. ХЭН ХЭРХЭН ХОХИРЧ БУЙГ ТОДОРХОЙЛОХ

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн эсэх |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Алхам 5. | | | | | | |

Та илрүүлсэн АЮУЛ БҮРт хэн хэрхэн өртөж буй талаар тодорхой мэдэж байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, та ажилтнуудаа болон байгууллагын гадна талд байгаа олон нийтийг дотор нь бүлэглэн ангилж, хэн аюулд өртөж байгаа вэ, хэрхэн эрсдэлд ажиллаж байгаа вэ, тэдний аюулгүй байдал, эрүүл мэндэд ямар сөрөг үр дагавар учирч байж болох вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй юм.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний энэ хэсэгт хүмүүсийг нэрээр нь оноож бичнэ гэсэн үг биш юм. Харин тухайн нэг аюулд ямар хүмүүс өртөж байж болохыг тодорхой онцлогоор нь бүлэглэн харуулахыг хэлж байгаа юм. Тухайлбал, “мод боловсруулдаг хэсэгт ажиллаж байгаа ажилтнууд” гэж хэлэхэд хангалттай юм. Эсвэл “засварын цехт ажиллаж байгаа ажилтнууд”, “агуулахын ачигчид”, “залуу ажилчид” гэх зэргээр бүлэглэн ангилж бичнэ. Хэрэв тоо нь мэдэгдэж байгаа бол нийт хэдэн ажилтан тухайн бүлэгт хамрагдсаныг тэмдэглэн бичвэл хэрэгтэй байх болно.

Ажилчдаас гадна “бусад хүмүүс”-ийг мөн тодорхойлж, таны илрүүлсэн аюулд яг ямар хүмүүс өртөж байгаа талаар тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь, танай байгууллагад түүхий эд материал хүргэж ирдэг хүмүүс, эсвэл эцсийн бүтээгдэхүүнийг ирж авдаг хүмүүс; цэвэрлэгчид эсвэл засварын ажил хийдэг хүмүүс; харилцагчид; ажлын байрны эргэн тойрон дахь олон нийт, иргэд (жишээ нь, барьж байгаа эсвэл засвар хийж байгаа барилгын хажуугийн гудамжаар явж байгаа хүмүүс). Эдгээр хүмүүсийг эрсдэлд байгаа хүмүүс гэж авч үзэх бөгөөд тэдний тухайн нөхцөлд оршин байгаа нь ажлын байранд нэмэлт эрсдэл авчирч байна уу гэдэгт мөн анхаарал хандуулах хэрэгтэй. Хүмүүс яг хэрхэн хохирч байж болох вэ гэдгийг мөн тодорхой болгох хэрэгтэй. Ямар төрлийн бэртэл гэмтэл, эсвэл өвчлөлийн асуудлуудыг таны илрүүлсэн аюул ажилчдад эсвэл бусад хүмүүст үүсгэж байгаа вэ гэдгийг тодорхойлно. Ингэхдээ, аюулгүй байдалд нь шууд үзүүлэх нөлөө, эрүүл мэндэд нь нөлөөлж байж болох үр дагавар, мөн эрүүл мэндэд урт хугацаанд гарах сөрөг үр дагавар буюу хожуу илэрч, эсвэл оношлогдож болох өвчлөлүүдийг анхааран авч үзэж, үнэлнэ (Бүлэг 1-н “ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний ойлголт ба нэр томъёо” гэсэн хэсгийг 9-р хуудаснаас үзнэ үү).

Мөн аюулгүй байдал, эрүүл мэндийн хувьд эмзэг бүлгийн хүмүүс хэн байж болохыг тодорхойлж, энэ онцлогоор нь хүмүүсийг бүлэглэж болно. Шинэ эсвэл залуу ажилчид, шинэ эх эсвэл хүүхдээ хүлээж буй жирэмсэн эх, тухайн нэг ажлыг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй байгаа иргэн гэх мэт жишээг татаж болно.

Өмнө дурдсанчлан, аюул БҮРийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учруулах үр нөлөөг тодорхойлж, хэн эрсдэлд байна, хэрхэн эрсдэлд орж байна гэх зэргийг тодорхойлох нь чухал. Учир нь

эрсдэлийг хянах арга хэмжээ нь тухайн нэг аюулын хүнд хохирол учруулах хохирлын түвшин, эсвэл учирч болох магадлалын түвшинг бууруулахад чиглэдэг тул аюул бүрийн онцлогийг сайтар анхааран тусгах хэрэгтэй. Дараах хүснэгтэнд, мод боловсруулдаг ажлын байранд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний хоёр дахь алхмыг хэрхэн хийж, бичиж тэмдэглэхийг харуулав. Илрүүлсэн аюул бүрээр, түүнд өртөх ажилчдын бүлгийг тодорхойлж, бүртгэнэ. Энэхүү хүснэгт нь таамаг байдлаар бөглөсөн, жишээ байдлаар бөглөгдсөн гэдгийг санаарай.

| **Алхам 1** | **Алхам 2** | **Алхам 3** | | **Алхам 4** | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | **Хэн хийх** | **Хэзээ хийх** | **Хийсэн эсэх** |
| Модны тоосонд өртөх | Нийт ажилтнууд (35) уушигны өвчлөлд өртөх эрсдэлтэй, тухайлбал модны тоос амьсгалснаас астма/багтраа/-аар өвдөх боломжтой.<br>Машины операторууд (15) өртөх эрсдэл илүү өндөр байна.<br>Хатуу модны тоос хорт хавдар, ялангуяа хамрын хорт хавдар үүсгэдэг. | | | | | |
| Дугуй хөрөө, босоо зүсэгч, зорогч гэх зэрэг машин тоног төхөөрөмж | Машины операторууд (15) болон бусад ажилтнууд машины эргэлдэх хэсэг, ялангуяа хөрөөний ирэнд, хүрсэн тохиолдолд ноцтой гэмтэх, бүр нас барж ч болох аюул байна. | | | | | |
| Гар ажиллагаа | Хүнд болон овор ихтэй, мод хөрөөдөх тавцан, зүсэгч хөрөөдөгч машин тоног төхөөрөмж гэх зэргийг зөөснөөр булчин шөрмөсний өвчлөлд өртөж болно. Жишээ нь, нуруу өвдөдөг болох.<br>Тэд мөн багаж хэрэгсэлтэй ажиллах, өргөгчтэй ажиллах явцдаа зүсэгдэх эрсдэлтэй байна. | | | | | |
| **Алхам 5.** | | | | | | |

# АЛХАМ 3. ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛ – ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭ ЮУ БАЙЖ БОЛОХЫГ ТОДОРХОЙЛЖ, АЛИЙГ НЬ СОНГОХЫГ ШИЙД

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн эсэх |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Алхам 5. | | | | | | |

Алхам 1-г хийхдээ та аюулуудаа тодорхойлж, Алхам 2-т хэн тэрхүү аюулд өртөж байж болохыг илрүүлсэн. Ингэхдээ аюулд өртөж байж болох ажилтнуудын тоог тодорхой бүлэгт ангилан тооцоолж, залуу ажилчид, шинэ болон хүүхдээ хүлээж буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх зэргээр эмзэг бүлгүүдийг мөн анхааран тусгасан байгаа.

Тодорхойлсон аюул тус бүрт “эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал”-ыг ашиглан зохих арга хэмжээг сонгоно. Энэхүү сургалтын багцад ашигласан эрсдэлийг хянах арга хэмжээ нь нийт 6 шатлалтай:

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 1: Аюулыг устгах буюу орлуулах

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 2: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерингийн аргуудыг ашиглах

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 3: Аюулгүй ажиллах арга барил, туршлага, зохион байгуулалт, мэдээ мэдээлэл түгээх, сургалт өгөх аргуудыг ашиглах

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 4: Эрүүл ахуй ба ахуй байдлыг сайжруулах аргууд

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 5: Хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах арга

→ Эрсдэлийг хянах арга хэмжээ 6: Эрүүл мэндийн/эмчийн хяналтын үзлэгүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх.

Эдгээр эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал нь олон жилийн турш бодит амьдрал дээр хэрэгжиж ирсэн ажил олгогч, ажилтнууд, хөдөлмөрийн байцаагчид, аюулгүй байдал эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон бусад олон талын туршлагад үндэслэн боловсруулагдсан болно.

Кофены тариаланд хортон устгагч цацсан жишээг (31-р хуудсыг үзнэ үү) энэхүү ЖДБ хяналтын арга хэмжээний шатлалыг тодорхой тайлбарлахад ашиглаж болно. Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлалыг сонгож, хэрэгжүүлэхдээ юун түрүүнд тухайн ажлын орчныг бүхэлд нь хамгаалахад шаардлагатай арга замуудыг тодорхойлж, хэрхэн хянах вэ гэдгээ шийдэх бөгөөд тухайн нэг хүнийг хамгаалах аргад төвлөрөхгүй. Тухайлбал, таны хийсэн ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үр дүнд машин тоног төхөөрөмжөөс цацагдаж байгаа тоосонцорууд гол эрсдэл болох нь тогтоогдвол тоос бууруулах, эсвэл тоосыг хязгаарлах арга хэмжээ авч ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг төлөвлөсөн нь дээр. Энэ нь тухайн ажлын орчин дахь бүх хүнийг хамтад нь хамгаалж байгаа

хэрэг бөгөөд тухайн ажилтан нэг бүрт тоосноос хамгаалах маск зүүлгэнэ гэж уушгийг нь ямар нэг түвшинд хамгаалж болох юм гэсэн тооцололтойгоор төлөвлөснөөс илүү үр дүнтэй. Учир нь маск зүүлээ гээд тоосыг хэдэн хувь шүүх, тэр нь яг ямар өвчлөлөөс хэр зэрэг хамгаалах вэ гэдэг нь нарийн тооцоологдоход хүндрэлтэй, мөн ач холбогдлын хувьд тухайн аюулыг өөрийг нь арилгах, эсвэл орлуулах нь чухал бөгөөд хамгийн сүүлийн түвшинд Хүнийг хамгаалах хэрэгсэл олгохоор төлөвлөх ёстой. Үүний нэгэн адилаар, ихээхэн дуу чимээ гаргадаг машины дуу чимээг багасгах арга хэмжээ авах ёстой бөгөөд энэ нь ажилтан бүрт чихэвч зүүлгэж, сонсголыг нь хамгаалах гэж оролдохоос илүү үр дүнтэй.

Эрсдэлийг хянах арга хэмжээ 6 буюу эрүүл мэндийн/эмчийн хяналтын үзлэгүүд нь ажилтнууд аливаа ажлын байрны аюулд хэр өртөж байна вэ гэдгийг анхаарах бус, харин тухайн ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс хэр сайн хамгаалж байна вэ гэдгийгээ хэмжих зорилготой арга хэмжээ байх ёстой. Ямар нэг өвчлөл илэрч байгаа бол түүнийг оношилж, өвчин цаашид газар авч улмаар хүнд архаг хэлбэрт шилжих, эсвэл амь насанд аюул учруулахаас сэргийлэх арга хэмжээг авснаар тухайн нэг ЖДБ сөрөг үр нөлөөг багасгаж чадна. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний 3-р алхам нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд тэдгээр нь тус бүртээ эрсдэлийг хянах арга хэмжээний шатлалыг ашиглана:

## АЛХАМ 3.А: ОДООГИЙН ЖДБ ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ТА ЯГ ОДОО ЮУГ ХИЙСЭН БАЙГАА ВЭ?

Та илрүүлсэн аюулуудынхаа заримынх нь эрсдэлийг хянах арга хэмжээг хэдийнэ авч хэрэгжүүлсэн байх магадлал өндөр. Ийм тохиолдолд, та аюул тус бүрээр эрсдэлийг хянах арга хэмжээ нь хэр үр дүнтэй хэрэгжиж, ажилтнууд болон бусад хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалж байгаа вэ гэдгийг үнэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, та өөрийн олж авсан мэдээлэлд (болон компанид байгаа сайн туршлагад) үндэслэн, авч хэрэгжүүлж буй эсвэл авч хэрэгжүүлсэн тэдгээр эрсдэлийг хянах арга хэмжээ нь хэр үр нөлөө үзүүлж байгааг үнэлнэ гэсэн үг.

Ийнхүү одоо хэрэгжиж байгаа ЖДБ хяналтын арга хэмжээний үр дүнг тодорхойлж, үнэлэх нь цаашид ямар нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ гэдгийг илүү үр ашигтай, зардал багатайгаар хэрэгжүүлж болохыг тодорхойлоход тань туслах юм.

Хэрэв 3.А алхмын үнэлгээний үр дүнд, тухайн нэг аюулд зориулан хэрэгжүүлж буй эрсдэлийг хянах арга хэмжээ нь үр дүнтэй байна гэж гарвал, дахин өөр арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэггүй (зөвхөн тухайн нэг аюулд) тул 3.Б баганад “Өөр арга хэмжээ хэрэггүй” гэж тэмдэглэхэд болно.

Хэрэв тодорхой нэг аюулд эрсдэлийг нь бууруулах арга хэмжээ байхгүй байна, эсвэл байгаа арга хэмжээ нь эрсдэлийг хангалттай бууруулж чадахгүй байна гэж тогтоогдвол, та Алхам 3.Б рүү шилжиж, “Аюулыг хэрхэн хянах хэрэгтэй вэ?” гэдгийг шийдэн, хяналтыг хэрэгжүүлэх хэрэгтэй болно.

## АЛХАМ 3.Б. ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ ЯМАР АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГТЭЙ ВЭ?

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | **Хэн хийх** | **Хэзээ хийх** | **Хийсэн эсэх** |
| | | | Эрсдэлийг хянах арга хэмжээ 1: Аюулыг устгах буюу орлуулах.<br>Эрсдэлийг хянах арга хэмжээ 2: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерингийн аргуудыг ашиглах<br>Эрсдэлийг хянах арга хэмжээ 3: Аюулгүй ажиллах арга барил, туршлага, зохион байгуулалт, мэдээ мэдээлэл түгээх, сургалт өгөх аргуудыг ашиглах<br>Эрсдэлийг хянах арга хэмжээ 4: Эрүүл ахуй ба ахуй байдлыг сайжруулах аргууд<br>Эрсдэлийг хянах арга хэмжээ 5: Хүнийг хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах арга<br>Эрсдэлийг хянах арга хэмжээ 6: Эрүүл мэндийн/эмчийн хяналтын үзлэгүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх. | | | |
| | | | Дээрхийн адил | | | |
| | | | Дээрхийн адил | | | |
| **Алхам 5.** | | | | | | |

### Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлалыг хэрхэн ашиглах вэ

Илрүүлсэн аюул тус бүрт, Алхам 3-ыг хэрэгжүүлэхдээ хамгийн түрүүнд Эрсдэлийг хянах арга хэмжээ 1-ийг авч хэрэгжүүлэхээр эрмэлзэх бөгөөд боломжгүй тохиолдолд дараагийн үе шат руу шилжсээр, хамгийн сүүлийн сонголтонд ЖДБ арга хэмжээ 6-г сонгоно.

***Эрсдэлийг хянах арга хэмжээ 1:***

### Аюулыг устгах буюу орлуулах

Эрсдэлийг хянах арга хэмжээг сонгохдоо аль болох 1-р арга хэмжээ буюу Аюулыг устгах, эсвэл орлуулахыг эрмэлзэх нь зүйтэй. Ингэснээр, аливаа аюулд өртөж байсан буюу өртөх гэж байсан хүмүүсийг тухайн аюулаас бүрэн хамгаалж чадах бөгөөд хэн нэгэн хүнийг ноцтой гэмтэхээс хамгаалж буй хэрэг юм.

Эрсдэлийг хянах арга хэмжээ 1-ийн жишээнд дараах орж болно:

- → Хортой хортон устгагч хэрэглэхийн оронд, оригиналь байдлаар фермийн ажлаа хийх
- → Эсвэл агаарт их цацагддаг хорноос илүү яг тухайн хэсэгт нь дусаж хүртдэг шингэн хэлбэрийн илүү бага хортой хортон устгагчаар орлуулах.
- → Өөр бодис хэрэглэх, эсвэл өөр аргаар ажиллах зэрэг илүү бага эрсдэлтэй боломжийг хэрэгжүүлэх. Өөр аргаар ажиллана гэдэг нь тухайн нэг ажлын үйл явцуудыг өөрчилж эрсдэлийг багасгаж болохыг хэлнэ, тухайлбал уусгагчтай будаг хэрэглэхийн оронд усан суурьтай будаг хэрэглэх нь илүү бага эрсдэлтэй байх болно.
- → Зарим машин багаж хэрэгслийг арай бага аюултай багаж хэрэгслээр орлуулж болно
- → Асбестыг зах зээл дээр олон байдаг аюулгүй бодисоор орлуулах нь үр дүнтэй байж болно.
- → Дуу чимээ ихтэй машиныг дуу чимээ бага гаргадаг машинаар сольж болно.
- → Өндөр шилэн барилгуудын цонхыг сольж, гадна талаас нь угаахад аюултай нөхцөл байдлыг өөрчилж дотроосоо угааж болдог аюулгүй процессоор сольж болно.

Хэрэв та Эрсдэлийг хянах арга хэмжээ 1-д тодорхойлсон арга хэмжээнүүдээ амжилттай хэрэгжүүлж чадвал, таны дараагийн ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнүүд хийгдэхгүйгээр ЭНД ХҮРЭЭД ЗОГСОНО. Учир нь та тух айн нэг аюулыг устгаад, байхгүй болгочихсон шүү дээ. Иймээс, зөвхөн тухайн нэг аюулд та дахин Эрсдэлийг Хянах Арга Хэмжээ 2-6-г хийх хэрэггүй юм.

Харин, таны тодорхойлсон аюулд эрсдэлийг устгах юм уу, орлуулах боломжгүй гэж гарсан бол та дараагийн арга хэмжээ болох Эрсдэлийг хянах арга хэмжээ 2-луу шилжиж, хяналтын арга хэмжээг тодорхойлох, сонгох, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Энэ ажиллагаа Эрсдэлийг хянах арга хэмжээ 6-руу хүртэл үргэлжилж болно.

### Эрсдэлийг хянах арга хэмжээ 2:

## Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерчлэл

Эрсдэлийг устгах юм уу, орлуулах боломжгүй бол дараагийн шийдэл нь илрүүлсэн аюулын эрсдэлийг бууруулахад тухайн ажилд ашиглаж буй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи ба инженерчлэлийн арга хэмжээг өөрчлөх явдал байна. Эрсдэлийг хянах арга хэмжээ 2 нь тухайн нэг хүнийг хамгаалахаас илүү, ажлын орчин дахь хүмүүсийг хамтад нь хамгаалдаг тул сайн арга гэж тооцогддог. Сайн туршлагыг харах, сайн зөвлөгөөг хайх нь энэ шатны арга хэмжээнд маш чухал. Иймэрхүү санаачлагын жишээнд дараах энгийн бөгөөд хямд төсөр арга хэмжээ багтана:

Машин механизмыг газардуулах – Үйлдвэрлэгчээс зохих хамгаалалт нь ирээгүй, эсвэл хуучирсан стандартаар угсрагдсан бол сайжруулсан хаалт хамгаалалт хэрэгтэй болно.

Дуу чимээ ихтэй машиныг дуу тусгаарлагч хаалтаар хаах, хэдийгээр дууг нь бүрэн тусгаарлахгүй ч ядаж бууруулж болно.

- → Зарим аюултай үйл явцыг бүрэн тусгаарлах ба/буюу хаах, тухайлбал рентген зураг авдаг өрөөг тусгаарлаж болно.
- → Өндөрт ажиллах цэгүүдийн ойролцоо шатны хашлага хийх.
- → Хүнд ачаа зөөхдөө энгийн түрдэг тэрэг юм уу, гар тэрэг ашиглах.
- → Ажиллах тавцан болон юм тавих тавиуруудыг тохиромжтой өндөрт байлгах, мөн ажилтны суух суудлыг тохиромжтой байлгах.
- → Ажлын хэрэгслүүдийг хүний өндөрт тохируулан байрлуулах, тухайлбал аливаа өлгүүр, тавиур, багаж хэрэгслийг хүн авахын тулд өлмийгөө өргөх, дээш хэт эвгүй байрлалаар сунах, шат хэрэглэх шаардлагатай байх хэрэгтэй.
- → Химийн бодис болон хортон устгагчдыг гараар бэлтгэхийн оронд зориулалтын хутгах болон дүүргэх систем хэрэглэх.
- → Энгийн тоос зайлуулагч тоног төхөөрөмж ашиглах – яндантай хиншүү сорогч байж болно.

→ Сайн гэрэлтүүлгээр хангаж болно.

→ Энгийн, зардалд хэмнэлттэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерчлэлүүд зөвхөн нэг ажилтны биш, бүлэг ажилтнуудыг тодорхой аюулаас хамгаалж, эрсдэлийг огцом бууруулдаг.

### *Эрсдэлийг хянах арга хэмжээ 3:*

## Аюулгүй ажиллах арга, туршлага, зохион байгуулалт, мэдээлэл ба сургалт

Таны ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ мөн аюулгүй ажиллах арга барил, практик юу байж болохыг анхааран үзэж, ажлыг хэрхэн зохион байгуулах, сургалт ба мэдээллийг хэрхэн сайн өгөх вэ гэдгийг тусгах хэрэгтэй. Дахиад, одоогоор ямар хяналтын арга хэмжээ хэрэгжүүлээд байгаа, цаашид ямар арга хэмжээг нэмж хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа вэ гэдгээ тодорхойлно.

Байгууллагын хувьд аюулыг хэрхэн энгийн, зардалд хэмнэлттэй аргаар эрсдэлийг хянах арга замуудын нэг нь “аюулгүй ажиллагааны систем” гэж нэрлэгддэг аюулгүй ажиллах арга, практикийг сургалт ба мэдээлэл өгөх үйл явцтай нэгтгэсэн арга хэмжээ байдаг. Ажлын байранд гарсан олон осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин зүгээр л ажил олгогч нь аюулгүй ажиллах арга барил, практик, зохион байгуулалтыг бий болгоогүй, менежер, супервайзор, ажилтнуудаа хангалттай мэдээлэл өгөөгүй, эсвэл аюулгүй байдал эрүүл мэндтэй холбоотой журмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөв сургаагүйгээс үүдсэн байдаг.  Ажлыг аюулгүй зохион байгуулна гэдэг нь ажил олгогч, менежер, супервайзоруудын ажиллах хүчээ зөв зохион байгуулж, ажилтнуудтайгаа сайн хамтран ажиллахыг хэлнэ. Аюулгүй байдал, эрүүл мэндийн зохион байгуулалтыг сайжруулж, бизнесийн үр ашигтай байдлыг дээшлүүлэх нь тийм зардалтай ажил биш бөгөөд эрсдэлийг хянах арга хэмжээ нь үргэлж их энгийн бөгөөд амархан хэрэгждэг ажлууд байдаг.

Жишээлбэл, эрсдэлийг хянах арга хэмжээ 3-ын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж болно:

→ Ажилтан, супервайзор, менежерүүддээ тоног төхөөрөмжийг хэрхэн аюулгүй ажиллуулах, эсвэл аливаа ажлыг хэрхэн аюулгүй гүйцэтгэх талаар тодорхой, ойлгомжтой заавар, журам гарган танилцуулж мөрдүүлэх, хэрэгтэй бол заавар ба журам нь бичгээр байж болно.

→ Аюулгүй байдал, эрүүл мэндийн зохих мэдээллийг өгөх – гарын авлага, заавар, аливаа сав баглаа боодлын шошго, хаягжуулалт, анхааруулах тэмдэг, химийн бодисын аюулгүй байдлын бүртгэлийн хуудас гэх мэт мэдээлэл түгээж буй бүхий л хэрэгслүүдээр дамжуулан мэдээлэл өгч болдог (мэдээллийг тухайн ажлын орчинд ойлгогдох хэл дээр өгөхийг анхаарна, тухайлбал Монгол компанид Монгол хэл дээр, гадаад ажилтантай тус ажилтанд ойлгогдох хэл дээр байх хэрэгтэй).

→ Ажлын байрны орчинг шинэчлэн сайжруулах – жишээ нь, ажилтнууд ажлаа хийхийн тулд ачааны машин явдаг замыг хөндлөн гарч, зөөх бараагаа очиж авдаг бол энэ аргыг өөрчилж, ачаа буулгадаг машин нь зам гарахааргүй газарт ачаагаа буулгадаг болгож болно. Энэ нь ачигчдыг замын хөдөлгөөнөөс үүдэн гэмтэх эрсдлээс сайтар хамгаална.

→ Ахуйдаа цэгцтэй, цэвэрхэн байх – ажлын байраа цэвэр эмх цэгцтэй, орох гарах гарцыг үргэлж нээлттэй байлгаж, юмаар таглахгүй байх, аливаа тоостой орчинг ашиглаж тоос бужигнуулахаас өмнө усаар чийгшүүлж байх.

→ Ажил олгогч таныг төлөөлөн ажилтнуудын аюулгүй байдлыг хангуулж, тэдэнд сургалт өгөх гэж байгаа менежер, супервайзоруудаа өөрсдийг нь сайн сургаж, зохих зааврыг өгөх. Заавар, сургалтанд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг ажлын байранд хэрхэн хийх талаар мэдээлэл багтаж болох юм.

→ Менежер ба супервайзоруудаа дагаж мөрдөх ёстой дүрэм журам, зааврыг ойлгомжтой, тодорхой өгөх.

→ Менежер ба супервайзоруудаа аюулгүй байдал, эрүүл мэндийг хангуулахад нь шаардлагатай эрх мэдлийг хангалттай олгох.

→ Таныг буюу боссыг, эсвэл аль нэг удирдах ажилтан ажлын байрандаа байхгүй байхад хэрхэн аюулгүй байдал, эрүүл мэндийг хангуулах талаар, мөн аюултай нөхцөл байдал эсвэл онцгой байдал үүсвэл хэрхэн ажиллах талаар тодорхой журамтай байх.

→ Менежер ба супервайзоруудаа аливаа машин механизмын газардуулгыг засч, эсвэл сольж

хийгээгүй бол ажлыг зогсоож байх талаар заавар өгөх, мөн тэгж үйл ажиллагааг зогсоох эрхийг бүрэн өгөх.

→ Менежер ба супервайзоруудаа таныг эзгүйд аливаа машин механизмын газардуулгыг шинээр захиалж авах эрх мэдэл олгох.
→ Ажилтнуудаа аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар сургалт өгөх, үүнд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний сургалт багтана.
→ Ажлын байрны ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд ажилтнууд оролцох оролцоог сайжруулах, үүнд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийг хянах арга хэмжээнд оролцох оролцоог оруулж тооцно.
→ Өндөр эрсдэлтэй ажил эрхэлдэг ажилтнуудад тусгайлсан сургалт өгөх.

### *Эрсдэлийг хянах арга хэмжээ 4:*
## Эрүүл ахуй ба сайн сайхан байдал

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний дараагийн алхам нь одоо хэрэгжүүлж байгаа эрүүл ахуйн хэрэгслүүд нь одоогийн аюулын түвшинд хэрэглэж байхад тохиромжтой байна уу, эсвэл эрсдэлийг хянах арга хэмжээг нэмж авах шаардлагатай байна уу, гэдгийг тодорхойлох шат байна.

Хяналтын арга хэмжээнүүдийн ихэнхи нь аливаа аюулд өртөхөөс хатуу хамгаалахгүй боловч, аюулыг нь багасгаж ажлыг илүү ээлтэй болгоно. Тухайлбал дараах байдлаар эрүүл ахуй, сайн сайхан байдлыг сайжруулж болно:

→ Ажлын байранд угаалгын болон ариун цэврийн үндсэн хэрэгслүүдийг байлгах.
→ Химийн бодисоор бохирлогдсон ажлын хувцсыг цоожтой шүүгээнд хадгалж байх, ийм хувцсыг ажилтнууд гэр лүүгээ авч явахыг хориглох.
→ Анхны тусламжийн энгийн хэрэгслийг бэлэн байлгах, тодорхой ажилтнуудыг үүнийг хэрэглэхэд сургах.
→ Тариалангийн талбай, малын хороо, эсвэл барилгын талбайд ажилладаг ажилтнуудыг цэвэр ус ба эмнэлэгийн анхны тусламжийн хайрцгаар хангах.

### *Эрсдэлийг хянах арга хэмжээ 5:*
## Хүнийг хамгаалах хэрэгсэл

Үүний дараа Эрсдэлийг хянах арга хэмжээ 5-руу шилжинэ. Хамгаалах гутал, бүтэн биеийн хувцаснаас гадна, хүнийг хамгаалах хэрэгсэл (ХХХ) гэдэг нь таны авч хэрэгжүүлж буй бусад эрсдэлийг хянах арга хэмжээнүүдэд зөвхөн нэмэлт болгон хэрэглэх хяналтын арга хэмжээ юм.

ХХХ-ийн хэрэглээг хамгийн бага байлгаж, ажилтныг аюулаас хамгаалах гол арга болгохгүй байх, эсвэл ажилтныг урт хугацаанд хамгаалах хэрэгсэл өмсөхийг шаардахгүй байх нь зөв юм. Гэхдээ Таны ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ 2 ба 4-р арга хэмжээг зэрэг хэрэглэж, хэсэг бүлэг хүнийг эрсдлээс хамгаалахад чиглэж байж болно. Тухайлбал, та дуу чимээ ихтэй машины дууг аюулгүй түвшинд хүртэл бууруулж чадсан бол тус машинтай харьцаж ажилладаг ажилтнуудыг чихэвч байнга зүүхийг шаардах хэрэггүй юм. Үүний нэгэн ижилээр, тоос үүсгэдэг тоног төхөөрөмжийн ялгаруулж буй тоосыг соруулан авдаг болсон бол ажилтнуудыг байнга маск зүүхийг шаардах хэрэггүй. Гэвч, аюулгүй байдал, эрүүл мэнд гэхээр эрсдэлийг хянах хамгийн анхны бөгөөд цорын ганц хэрэгслээр хүнийг хамгаалах хэрэгслийг сонгодог нь харамсалтай. Эдгээр хүнийг хамгаалах хувцас, хэрэгсэл ажилтныг хамгаалж чаддаггүй. Байнгын хамгаалах хувцас өмсөх нь биед таатай бус бөгөөд хэрэглэж буй хүндээ тийм ч сайн таардаггүй. Хүн бүр өөр галбир, хэмжээтэй бөгөөд нэг размерын хувцас бүх хүнд таарахгүй. Хүнийг хамгаалах хэрэгсэлд дараах багтана:

**Бүтэн биеийн хувцас;**

→ Нүдний хамгаалалт;
→ Гутал

- → Бээлий
- → Сонсгол хамгаалалт
- → Амьсгал хамгаалах хэрэгсэл /Тоос болон химийн бодис амьсгалагч/
- → Тоосны маск
- → Каска
- → Нойтон орчны эсвэл хүйтний улирлын хувцас.

Хэрэв та ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээрээ ХХХ хэрэгтэй гэж шийдсэн бол яг ямар хэрэгслийг, юуг хамгаалах гэж олгох, ямар төрлийнхийг олгох вэ гэдгийг дэлгэрэнгүй бичнэ. Бээлий, тоосны маск, химийн бодис амьсгалагч эсвэл өөр хэрэгслээр хангах бол тэрхүү хэрэгслээ хэрхэн цэвэрлэж, хадгалж байх ёстой, хэр давтамжтай хэрэглээд шинийг авч байх ёстой зэргийг тайлбарлах хэрэгтэй. **ХХХ-ийг ажилтнаас ямар нэг төлбөр авалгүй, ажил олгогчоос үнэгүй хангах ёстой**г санаарай. Сайн туршлагыг судлан, хэрэгтэй бол ямар ХХХ сонгох вэ гэдэг дээр зөвлөгөө аваарай.

**ХХХ-ийн талаар бодохдоо дараах зүйлсийг санаарай:**

- → Эрсдэлийг хянах өөр аргуудыг юун түрүүн харгалзан үзэж, танилцах хэрэгтэй. ХХХ-ийг ямагт хамгийн сүүлийн сонголт байлгаж, зарим тохиолдолд хэрэгжүүлэхээр сонгосон бусад хяналтын аргыг дэмжихэд зориулан төлөвлөж болохыг санаарай. ХХХ хэзээ ч эхний, эсвэл цорын ганц сонголт байх ёсгүй бөгөөд энэ нь дангаараа ажилтныг хамгаалж чадахгүй.
- → Техникийн болон инженерчлэлийн хяналтууд (Эрсдэлийг хянах арга хэмжээ 2) нь хамт олныг хамтад нь урт хугацаанд хамгаалдаг бөгөөд нэгж ажилтан бүрт ХХХ авч өгөх, түүнийг нь тогтмол сольж байх, арчилж цэвэрлэж хадгалж байхаас ямагт илүү хямд байдаг.
- → Хамтад нь хамгаална гэдэг нь тухайн орчинд ажилладаг ажилтнуудыг бүхэлд нь хамгаалдаг байхад ХХХ бол зөвхөн тухайн нэг ажилтныг л хамгаална.
- → ХХХ-ийг сонгох бол ажилтнуудыг заавал оролцуулж байгаарай. Учир нь тэдгээр ажилтнууд л ямар ажил хийдэг, ямар аргаар хийдэг, хаана нь ямар алдаа гарч өөрсдийг нь гэмтээх боломжтой байдгийг мэднэ шүү дээ.

### *Эрсдэлийг хянах арга хэмжээ 6:*

## Эрүүл мэндийн/Эмчийн үзлэг хяналт

Та ЖДБ-ын эрсдлийн үнэлгээндээ, өндөр эрсдэлтэй ажил хийж байгаа ажилтнуудаа зохих ур чадвартай мэргэжлийн анагаах ухааны хүний эрүүл мэндийн болон эмчийн үзлэгт хамруулж байх арга хэмжээг анхааран үзэж, төлөвлөх хэрэгтэй.

Өмнө дурдсанчлан, эрүүл мэндийн ба эмчийн үзлэгүүд нь ажилтныг аюулаас хамгаалж байгаа хэрэг биш, харин хамгаалж буй арга хэмжээ нь үр дүнтэй ажиллаж, ажилтныг хамгаалж байна уу гэдэгт мониторинг хийх арга хэрэгсэл юм. Гэхдээ энэ арга хэмжээ нь эрсдэлийг бууруулахад тусалдаг. Та аюултай бодист (химийн бодис, тоос, бичил биетнүүд, дуу чимээ гм) хордохоос хамгаалж,эрсдэлийг хянах арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн байсан ч ажилтнууд өвчин туссан шинж тэмдэг илэрсээр байдаг, гэхдээ голцуу амьдралын хожуу үед. Тиймээс, иймэрхүү мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг эрт илрүүлж, хяналтандаа авахын тулд эрүүл мэндийн үзлэгүүд тогтмол хийж байх хэрэгтэй. Жишээ нь:

Тоос амьсгалах нь астма болон бусад урт хугацааны уушигны өвчлөлд хүргэнэ.

Уусгагч гэх зэрэг химийн бодисууд Дэрматитис (dermatitis) гэгддэг арьсны үрэвсэлт өвчин үүсгэнэ.

- → Органик фосфор агуулсан хортон устгагч, жишээ нь шавьж устгагч, амьтны/хонины хамуу устгагч, гэх зэрэг нь мэдрэлийн системийг хордуулна.
- → Тогтмол 85-90 децибиллийн дуу чимээ гаргадаг машин нь сонсголд муугаар нөлөөлнө.

Эрүүл мэндийн/Эмчийн үзлэгт дараах багтаж болно:

→ Биологийн болон биологийн бус нөлөөг хянах, үүнд тодорхой аюултай химийн бодисын нөлөөллийг илрүүлэх цусаар шинжилгээ авч болно.
→ Сургагдсан супервайзор гэх зэрэг ажил хариуцсан хүн тогтмол хяналт хийж, ажилтнуудын арьсан дээр ямар нэг арьсны өвчний тууралт гарч уу, гэдгийг шалгаж болно.
→ Сонсголын тест.
→ Уушигны үйл ажиллагааны тестээр аюултай тоосонцорт өртсөн уушигны өвчлөлийг хянах.
→ Ажилтнуудын өвчний шалтгаанаар ажилдаа ирээгүй өдрүүдийг хянаж, ажлаас шалтгаалсан шалтгаанаар эмч хэвтэн эмчлүүлэхийг зөвлөсөн эсэхийг нягталж болно.
→ Тодорхой нэг аюулын нөлөөллийг илрүүлэх зорилгоор эрүүл мэндийн/эмчийн үзлэг хийх арга хэмжээг тодорхойлох нь ердийн эрүүл мэндийн үзлэгээс ялгаатай. Энэ хоёрын ялгааг мэдэхгүй байх тохиолдол олон. эрүүл мэндийн/эмчийн үзлэг нь тухайн нэг аюул эсвэл асуудалд тусгайлан чиглэсэн байдгаараа онцлог.

Дүгнэхэд, эрсдэлийг хянах арга хэмжээний шатлалыг сонгохдоо тухайн аюулыг устгах буюу орлуулахад зорих ёстой бөгөөд боломжгүй бол техник, тоног төхөөрөмж, инженерчлэлийн арга хэмжээг аюулгүй ажиллагааны арга, практик, зохион байгуулалт, мэдээлэл, сургалттай хослуулах хэрэгтэй. Зорилго нь аюулд өртөж болох ажилтнуудыг хамтад нь хамгаалах явдал бөгөөд хүнийг хамгаалах хэрэгслийг зөвхөн бусад тусгай аюулаас ажилтныг хамгаалах зорилгоор хэрэглүүлэх ба урт хугацаанд өмсүүлэхээс татгалзах нь зүйтэй (гэхдээ ажлын гутал, бүтэн биеийн хамгаалалтын хувцас зэрэг стандарт хэрэгслүүдийг байнга хэрэглэж болно). Мөн эрүүл ахуйн болон сайн сайхан байдлын арга хэмжээг тодорхойлж, урт хугацаанд аюулд өртсөнөөр өвчин үүсгэж болзошгүй аюулын нөлөөлийг хэмжих зорилгоор ямар эрүүл мэндийн/эмчийн үзлэгийг төлөвлөж хийх асуудлыг анхаарах үзэх нь зүйтэй.

Доорх хүснэгтэнд, мод боловсруулах ажлын байранд хийгдэж буй ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний дараагийн шатны (3.А ба 3.Б алхам) баганыг бөглөе. Илрүүлсэн аюул тус бүрт бид эрсдэлийг бууруулахад ашиглаж болох арга хэмжээг бичих бөгөөд 3.А алхамд одоо хэрэгжиж байгаа арга хэмжээ, 3.Б алхамд цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг бичнэ. Энэ бол зөвхөн таамгаар жишээ болгон үзүүлж байгаа жишээ бөгөөд аль нэг ажлын байранд шууд авч хэрэглэж болох жишээ бус гэдгийг санаарай.

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3.А | Алхам 3.Б | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | **Хэн хийх** | **Хэзээ хийх** | **Хийсэн эсэх** |
| Модны тоосонд өртөх | Нийт ажилтнууд (35) уушигны өвчлөлд өртөх эрсдэлтэй, тухайлбал модны тоос амьсгалснаас астма-аар өвдөх боломжтой.<br>Машины операторууд (15) өртөх эрсдэл илүү өндөр байна.<br>Хатуу модны тоос хорт хавдар, ялангуяа хамрын хорт хавдар үүсгэдэг. | - Тоосыг хурдан зайлуулдаг.<br>- Гар угаах сайн хэрэгсэл болон шүршүүр хүртээмжтэй байдаг.<br>- Агаарт тархсан тоосноос хамгаалах маскаар хангасан, үргэлж шинэчлэн олгодог. | - Тоос гаргаж буй машин тус бүрийг тоос зайлуулах хэрэгслээр тоноглох (тоос сорогч машин, агааржуулагч)<br>- Ажилтнуудад хуурай модны тоосыг шүүрдэж болохгүй, оронд нь тоос сорогч ашиглах, эсвэл шүүрдэхийн өмнө норгож байхыг сануулах.<br>- Машины операторыг тоос ялгаруулагч машиныг ашиглах болон үндсэн тохиргоо, засвар үйлчилгээ хийхтэй холбоотойгоор мэргэжлийн хүнээр сургах. | | | |
| Дугуй хөрөө, босоо зүсэгч, зорогч гэх зэрэг машин тоног төхөөрөмж | Машины операторууд (15) болон бусад ажилтнууд машины эргэлдэх хэсэг, ялангуяа хөрөөний ирэнд, хүрсэн тохиолдолд ноцтой гэмтэх, бүр нас барж ч болох аюул байна. | - Бүх машинд үйлдвэрлэгчээс өгсөн заагврын дагуу хаалт хамгаалалт хийгдсэн.<br>- Газардуулгыг тогтмол шалгаж, сайн ажиллаж байгаа эсэхийг нь баталгаажуулсан.<br>- Ажилтнууд машин дээр ажиллахдаа аюулгүй байхад хангалттай зай талбайтай.<br>- Ажилтнууд машиныг хэрхэн аюулгүй ашиглах талаар мэргэжлийн хүнээс сургалт авсан. | - Мод таслагч хөрөөг ажиллуулж буй машинд тоормос суулгах, ингэснээр модыг тасалж модны тоос цацруулах хугацааг богиносгох.<br>- Ирээдүйд зөвхөн тоормосны хяналттай машин худалдаж авч байх.<br>- Модны зоргодос бага гаргадаг машин авч хэрэглэж болох боломжийг судлах.<br>- Ажилтнуудтай уулзаж, машины хаалт хамгаалалт хугацаандаа шалгагдаж, ямар нэг алдаа дутагдал гарсан бол тэр дор нь тайлагнаж байгаа эсэхийг дахин шалгах.<br>- Машиныг аюулгүй ашиглах талаарх мэдээллийн хуудсыг зөвхөн ажлын талбайд бус, амралтын өрөө, хоолны өрөө гэх зэрэг байршлуудад давхар байрлуулах. | | | |
| Гар ажиллагаа | Хүнд болон овор ихтэй, мод хөрөөдөх тавцан, зүсэгч хөрөөдөгч машин тоног төхөөрөмж гэх зэргийг зөөснөөр булчин шөрмөсний өвчлөлд өртөж болно.<br>Жишээ нь, нуруу өвддөг болох.<br>Тэд мөн багаж хэрэгсэлтэй ажиллах, өргөгчтэй ажиллах явцдаа зүсэгдэх эрсдэлтэй байна. | Ажилтнууд гар ажиллагааг зөв хийх талаар сургалтанд суусан.<br>Мужааны вандан болон машины ширээнүүд зохимжтой өндөрт байрласан.<br>Гараар ажил хийх ажилтнуудад бат бэх, зузаан бээлий олгосон. | Боломжтой бол мод хураах хэсгийг ажлын талбайн яг дэргэд байгуулж, хүнд ачаа зөөвөрлөх зайг багасгах.<br>Ажилтнуудад хуучин өмсч байсан бээлий нь урагдах юм уу, элэгдэхэд шинэ бээлий хүсч, авч байхыг сануулах.<br>Хүнд ачаа өргөдөг хэсэгт бэртэл гэмтлээс сэргийлэхийн тулд хавтан тээвэрлэгч гэх зэрэг өргөх зөөх хэрэгсэл ашиглах. | | | |
| **Алхам 5.** | | | | | | |

## *Эрсдэлийг хянах арга хэмжээний талаар бодох нь –*
## *Кофе тариалдаг талбайд хортон устгагч цацах жишээ*

Менежер кофе тариалдаг талбайд хортон устгагч ашигласнаас хорддог асуудалд шийдэл олоход туслахаар ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийж байна. Хортон устгагч цацах үеэр төлөвлөснөөс хол очиж байгаа тул ажилчид тухайн бодист өртөж байгаа, мөн ажилчид өөрсдөө хортон устгагч цацсан хэсэгт эргэж орж болох цагийн хуваарийг зөрчиж болоогүй байхад нь орсноос хорддог байна. Одоогоор талбайд ажилладаг ажилчид харьцангуй сул хордсон шинж тэмдэг илэрсэн хүсээгүй үр дүнгүүд хэд хэд гарсан байгаа. Эдгээр тохиолдлуудыг төрийн байгууллагуудад тайлагнасан ба байгууллагын эзэн болон менежер аюулгүй байдал, эрүүл мэндийн гүйцэтгэлийг энэ тал дээр сайжруулах хэрэгтэй байгааг ухамсарлаж байгаа.

**Алхам 1: Аюулыг илрүүлэх**

Аюул нь хортой шавьж устгагчийг мотортой агаар үлээгч төхөөрөмжөөр дамжуулан цацахад төлөвлөөгүй хол зайд хүрдэг тул ажилчид тухайн бодисыг амьсгалахад хүргэдэг гэдэг нь тогтоогдсон. Хоёр дахь аюул нь ажилчид хор цацсан орчинд эргэн орж ажиллаж болох хугацаанаас өмнө орж, химийн бодист өртдөг явдал.

**Алхам 2: Хэн хэрхэн эрсдэлд байна вэ?**

Талбайд ажилладаг 28 ажилтан хортой шавьж устгагчийг цацах үеэр өртөх эрсдэлтэй (хордуулсан агаараар амьсгалах) ба хор цацсан бүст цагаасаа өмнө эргэн орсноор мөн хордох (хортон устгагч арьсанд нэвчих) аюултай. Ажилчдын 10 нь насанд хүрсэн эмэгтэй, 8 нь насанд хүрсэн эрэгтэй, зургаа нь залуу эмэгтэй ажилчин (18-аас доош насны) ба 4 нь залуу эрэгтэй ажилчин (18-аас доош насны).

**Алхам 3: Эрсдэлийг үнэлэх – эрсдэлийг бууруулах ямар арга хэмжээ шаардлагатай вэ**

**3.А: Одоогоор юу хийж байгаа вэ?**

Менежер хортон цацах систем нь талбайд ажиллаж буй ажилтнуудад хэт ойр байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Энэ нь ургацын талбай дахь ажлын зохион байгуулалт ба дүрэм журам мөрдөх байдал тааруу байгаагаас үүдэлтэй бөгөөд ялангуяа хор цацах ажил хийхдээ ажилтнуудад сануулга өгдөггүй байна.

Мөн хор цацсан бүст эргэж орохыг зөвшөөрсөн цагийг ажилтнууд баримталдаггүй болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэрээр хортон устгагчийн савлагаан дээр сануулан бичсэн эргэж ороход аюулгүй гэж үзэж болох хугацааг зөрчин, ажилчдыг орж ажиллах зөвшөөрлийг өөрөө өгдөг байна.

**3.Б: Цаашид юу хийх шаардлагатай вэ – Эрсдэлийг бууруулах арга хэмжээ**

Одоо менежер нь эрсдэлийг хянах арга хэмжээг боломжийн хэрээр системтэйгээр хэрэгжүүлэх хэрэгтэй. Тодорхой эрсдэлийг хянах арга хэмжээг сонгож, тухайн нэг асуудалд ашиглаж болно гэж үзсэн бол товч тайлбартайгаар санал болгох хэрэгтэй.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 1: Аюулыг устгах буюу орлуулах*. Энэ бол үргэлж хамгийн сайн шийдэл. Гэхдээ, энэ кейст тариалангийн талбайн эзэн органик фермингийн аргыг хэрэглэдэггүй. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үр дүнд аюулыг устгана гэж сонгож болохоorгүй байгаа тул өөр арга хэмжээ авах ёстой гэж дүгнэгдсэн. Орлуулах арга нь мөн л энэ тохиолдолд ашиглаж болохгүй ба учир нь тариалангийн талбайн эзэн химийн бодисоор шавьж устгах ажлаа үргэлжлүүлэн хортон амьтныг устгахаар шийдсэн байгаа.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 2: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерчлэл*. Хортон устгагчийг цацаж буй моторжуулсан агаар үлээгч нь сайн ажиллагаатай бөгөөд хамрах ёстой хүрээнээсээ хальж хордуулж байгаагийн шалтгаан бус. Харин энэ нь салхитай цаг агаараас хамаарч байгаа бөгөөд цацаж эхлэхэд салхины хурдаас хамааран зарим тохиолдолд маш хол газар хүрдэг байна.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 3: Аюулгүй ажиллагааны арга, туршлага, зохион байгуулалт, мэдээлэл ба сургалт.* Менежер нь хор цацдаг ажилчид болон талбайд ажилладаг ажилтнуудтай зөвлөлдөн, химийн бодист хордохгүй байх хамгийн сайн арга нь аюулгүй ажиллагааны туршлагыг нэвтрүүлж, ажлын зохион байгуулалтаа сайжруулах, үүнийг мэдээлэл ба сургалттай хослуулах гэж тодорхойлжээ. Дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

Салхитай үед хор цацах ажил хийхгүй (Шийдвэрийг хор цацах багийн ахлах ажилтан гаргана).

→ Хор цацах багийн ахлах ажилтан талбайн ажилчдыг хариуцсан супервайзорт хэзээ, хаана хор цацах талаар тогтмол мэдээлэл өгнө. Мөн тэрээр талбайн эзэн ба менежерт энэ талаараа бичгэн хувилбарыг илгээж байх болно. Энэ нь талбайн супервайзор хор цацах үеэр ажилчдаа химийн бодист хордох аюулаас бүрэн хамгаалж чадна.

→ Хор цацах хэсгийн ахлагч нь ажилтнуудаа хор цацаж байх үеэр талбайд аль нэг талбайн ажилтан харагдвал ажлаа яаралтай зогсоож, энэ талаар өөрт нь мэдэгдэж байхыг зааварлана. Ингэснээр, тэрээр талбайн ажилчдыг аюулгүй зайд холдуулна. Энэхүү аюулгүй байдлын арга хэмжээг хортон устгадаг багийн гишүүдэд сургалтаар дамжуулан танилцуулна.

→ Талбайн ажилчид өөрсдийг нь ажиллаж байх үеэр хортон цацдаг баг ойр ажиллаж байгааг харвал өөрсдийн ахлахтаа яаралтай мэдээлнэ. Ингэснээр тэд хор цацаж буй орчноос аюулгүй зайд холдоно.

→ Хор цацдаг баг болон талбайд ажилладаг багийн ажилчид, ахлагчид хортон устгагчийг үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчээс өгсөн мэдээлэлд үндэслэн хор цацсан орчинд эргэн орохыг зөвшөөрсөн цаг хугацааг баримтална. Эргэн орох аюулгүй цагийн талаарх бичгэн мэдэгдлийг талбайн менежерийн оффист хүргүүлнэ. Энгийн анхааруулах тэмдэг, үүн дотор гавлын ясны болон зөрүүлсэн ясны зурагтай хорыг анхааруулсан тэмдгүүдийг, хор цацаж буй бүст зохих зайнд байршуулна.

→ Аливаа өвчлөл үүсэх магадлалын талаар тариалалтын үеэрх осол ба өвчний бүртгэлийн номд бүртгэнэ.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 4: Эрүүл ахуй ба сайн сайхан байдал.* Ажилчдын хувийн эд хэрэгсэл ба хоол хүнсийг хийх түгжээтэй сав, мөн угаалгын өрөөг төв оффист ойр байрлуулах, тэр нь хор цацах бүсээс хангалттай хол байх. Энд өөр арга хэмжээ авах хэрэггүй.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 5: Хүнийг хамгаалах хэрэгсэл.* Ажлын шинэ журмууд ажилчдыг төлөвлөөгүй хол цацагдсан хоронд өртөхгүй байх, хор цацсан бүст зөвшөөрөгдсөн цагаас өмнө эргэж орохгүй байх нөхцлийг хангаж, хортон устгагчийн үйлдвэрлэгчээс өгсөн аюулгүй байдлын зөвлөгөөг яг баримтална. Тиймээс хүнийг хамгаалах хэрэгсэл ба хувцас ядаж хортон устгагчид өртөхөөс хамгаалах зорилгоор хэрэглэгдэх шаардлагагүй.

*Эрсдэлийг хянах арга хэмжээ 6: Эрүүл мэндийн/Эмчийн үзлэг хяналт.* Энэ нь эрсдэлийг хянах шууд арга хэмжээ биш боловч тодорхойлолтын дагуу хортон устгагч нь хортой химийн бодис тул ажилчид үүнд өртөх суурь эрсдэл байсаар байгаа. Иймд (18-аас доош насны) залуу ажилчид хөдөлмөрийн эрүүл мэндийг хянах зорилгоор нийслэлд саяхан байгуулагдсан олон улсын төслийн хүрээнд цусны шинжилгээнд хамрагдана.

**Дүгнэлт**

Ажлын журам, харилцан мэдээлэл солилцох, сургалт өгөх, мэдээлэл өгөх арга хэмжээг сайжруулна гэдэг нь тариалангийн талбайн эзэн ба менежер цаашид супервайзорууд болон ажилчдад хортон устгагчийг аюулгүй цацах талаар тодорхой заавар өгнө гэсэн үг юм. Ингэснээр тариалангийн ажил сайн зохион байгуулалттайгаар явагдах бөгөөд супервайзор ба ажилтнууд аюулгүй ажиллах журмын талаар сайтар сургагдана. Түүнчлэн, удирдлагууд эрсдэлийг хянах арга хэмжээ тогтвортой хэрэгжиж, осол гэмтэл ба өвчлөлөөс зохих ёсоор сэргийлж байгаа эсэхийг тогтмол хянаж байх юм.

# АЛХАМ 4. ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭГ ХАРИУЦАХ ХҮН БОЛОН ХУГАЦААГ ТОДОРХОЙЛОХ

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн эсэх |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Алхам 5. | | | | | | |

ЖДБ хяналтын арга хэмжээг Алхам 3.Б-р хийхээр шийдсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээгээ хийх хэрэгтэй. Мөн та арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг хариуцах ажилтныг томилж, хийсэн байх цаг хугацааг тодорхойлох, хийсний дараа бүртгэл хөтлөх огноог мөн тогтох хэрэгтэй. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг Алхам 4-ийн хүрээнд хийхэд гурван гол үүрэг хариуцлага бий:

→ Байгууллагын ямар ажилтан үүнийг хариуцах вэ?

→ Хэзээ арга хэмжээ авах вэ?

→ Хэзээ арга хэмжээг авч эхлэх вэ?

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээр тодорхойлсон хяналтын арга хэмжээ тус бүрт хариуцах хүн, дуусгасан байх хугацааг тодорхойлох ёстой гэсэн үг юм. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээр төлөвлөсөн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн бол эргэн тэмдэглэл хийж байх хэрэгтэй.

Эрсдэлийг үнэлэхэд нэг дор засч сайжруулж болох олон асуудлыг илрүүлэх нь нийтлэг байдаг. Тиймээс, хэрэгжүүлэх арга хэмжээнээс алийг нь хэзээ хэрэгжүүлэх эрэмбийг тогтоох шаардлагатай бөгөөд хамгийн ноцтой эрсдэлтэйг нь хамгийн түрүүн хянахаар төлөвлөнө. Энэ нь таныг ажилчдаа хамгаалахад туслах бөгөөд эрсдэлийг хянах арга хэмжээг үр дүнтэй бөгөөд үр өгөөжтэй болгодог. Аливаа ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд, ЖДБ-ын эрсдлийн зэрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбийг тодорхой хэмжээнд тухайн хүний үзэмж ба үнэлэмжинд суурилж тогтоодог. Гэвч, таны тогтоосон эрэмбэ зайлшгүй шалтгаантай гэдгийг харуулах хэрэгтэй. Юуны түрүүнд энэ нь тун хүнд даалгавар шиг санагдаж болно, гэвч “энгийн байлга” гэдэг дүрмийг санаж хий, хэрэгтэй бол зөвлөгөө ба сайн туршлагаас суралц. Өмнө дурдсанчлан, эрсдэл бол аливаа гэмтэл бэртэл эсвэл өвчлөл үүсэх магдалалыг хохирол үүсгэх түвшинд нь үржүүлсэн хэмжигдэхүүн юм. Энэ тохиолдолд, хэрэв та ЖДБ-ын эрсдлийн зэргийг тогтоох гэж байгаа бол хэд хэдэн асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай. Тухайлбал:

→ Осолд хүргэх нөхцөл байдал үүсэх ***магадлал хэр өндөр вэ?*** Энэ нь ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх үеийн нөхцөл байдал бөгөөд ажлыг явуулж байгаа тухайн үеийн бодит үйл ажиллагаа ба хэрэгжүүлж байгаа ослоос сэргийлэх арга хэмжээнүүдэд суурилах ёстой. Осол гарах магадлал байхгүй байна уу, эсвэл бүр өндөр магадлалтай байна уу, ямар нэг зүйл болохоор хүлээгдэж байгаа зүйл ажиглагдав уу, эсвэл гарцаагүй болох гэж байна уу? Ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ – хэт яаруу ажиллаж байж болох жишээтэй, эсвэл ажлын орчин нөхцөл аюултай, машин тоног төхөөрөмжийг ашиглахад хэцүү байдаг ч байж болох.

→ Гарч магадгүй байгаа ослын ***үр дагавар*** юу байж болох вэ? Хамгийн муугаар бодоход ямар үр дүнд хүрэх вэ? Хэрэв ажилтан мод боловсруулдаг машины ойр хальтирч юм уу, бүдэрч унавал, зүгээр өнгөрөөж болох (эмчилгээ хэрэггүй) эсвэл бага зэргийн (зүссэн буюу

шалбарсан бол анхны тусламж үзүүлэх) гэмтэл авч болохоос эхлээд маш хүнд гэмтэх буюу машинд хэрчигдэж нас барах ч аюул байж болно.

→ ЖДБ хамрах хүрээ ба эрсдлийн зэрэг нь ямар байна? Өөрөөр хэлбэл, осол гарлаа гэхэд үр дагавар нь хэр ноцтой вэ – хэдэн хүн, ажил, машин тоног төхөөрөмж, хэрэглэгч үйлчлүүлэгч, эсвэл бүтээгдэхүүний багцууд өртөх вэ?

Доорх хүснэгтэнд эрсдэлийг хэрхэн үнэлэх заавры г танд танилцуулна. Мөн та Үйл ажиллагаа 4 (хуудас 56)-т заасан арга хэмжээг ашиглаж, ЖДБ эрсдлийн зэргийг тодорхойлох шалтгаанаа болгох, тодорхойлсон эрсдэлийг хянахад зориулан авах арга хэмээгээ эрэмбэлэх боломжтой.

## ЖДБ матриц ашиглах

Ихэнхи жижиг бизнесийн байгууллагууд ЖДБ матриц ашиглах хэрэггүй. Гэвч, иймэрхүү хэрэгсэл танд тодорхой нэг асуудалд холбогдох ЖДБ эрсдлийн зэргээ тодорхойлоход тань тусална. ЖДБ матрицыг ашиглавал эрсдэлийн зэргийг магадлал болон хохирлын зэргийг тодорхой түвшинд ангилж гаргадаг. Доор үзүүлсэн матрицад оруулж бичсэнээр утгыг гаргана. ЖДБ эрсдлийн зэрэг нь аль арга хэмжээг хамгийн түрүүнд авах вэ гэдгийг тогтоох бөгөөд мэдээж хамгийн эрсдэлтэйгээс нь эхлэнэ. Матрицыг ашиглах нь эрсдэлийг хянах арга хэмжээгээ эрэмбэлэхэд тустай. Энэ нь олон төрлийн үнэлгээнд тохиромжтой байдаг бөгөөд илүү цогц бөгөөд төвөгтэй нөхцөл байдалд ашиглахад зохимжтой. Гэвч, энэ нь магадлалыг зөв үнэлэхэд тодорхой туршлага ба чадвар шаардана. Үүнийг буруу хийх нь чухал арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй өнгөрөх эсвэл шаардлагагүй ажил хийхэд хүргэнэ. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг энэ л аргаар хийх ёстой гэсэн шаардлага байхгүй тул та маш олон төрлийн ЖДБ матрицыг олж авч болох бөгөөд тэдний олонхи нь томоохон байгууллагад ашиглахад зориулагдсан байдаг. Тиймээс, энэхүү хичээл нь ЖДБ-т зориулсан тул хамгийн хялбар бөгөөд гурав, гурван үзүүлэлтээр хэмждэг, шууд хэрэглэхэд ойлгомжтой бөгөөд хялбар матрицыг сонгосон байгаа. Энэ нь ЖДБ эрсдлийн зэрэг болон хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбийг тогтоох гэж хэт их зүйл бодож, ярилцаж сунжруулснаас гол фокусаа алдахаас бас зайлсхийхэд тусална.

## ЖДБ матрицын жишээ

| | | Боломжит хохирол буюу үр дагавар | | |
|---|---|---|---|---|
| | | Бага зэрэг хохирол учруулна | Дундаж хохирол учруулна | Их хохирол учруулна |
| Тохиолдож болох магадлал | Бага магадлалтай | Бага эрсдэлтэй | Бага эрсдэлтэй | Дундаж эрсдэлтэй |
| | Магадлалтай | Бага эрсдэлтэй | Дундаж эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй |
| | Их магадлалтай | Дундаж эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй |

Энэхүү гурвыг харьцах гурав хэмжээтэй матриц нь ЖДБ эрсдлийн зэргийг тодорхойлж, авах арга хэмжээг эрэмбэлэхэд ашиглах үзүүлэлт болгон тооцоолох субъектив үзүүлэлт болж өгдөг.

**а)** Боломжит *үр дагавар буюу хохирлын зэргийг,* бид дараах гурван төрлийн хохирлын түвшнээр ангилж гаргахыг санал болгож байна:

- **Бага зэрэг хохирол учруулна:** Энэ нь бага зэргийн анхан шатны тусламж үзүүлэх, эсвэл ажлын явцыг богино хугацаанд зогсооход хүргэсэн жижиг бэртэл гэмтэл буюу өвчлөлийг хэлж болно. Энэ түвшинд хэн нэг хүн хоёр өдрөөс дээш хугацаагаар чөлөө авахгүй.

- **Дундаж хохирол учруулна:** Энэ тохиолдолд, хүн эргэн хэвийн байдалдаа орох хүртэл түр хөдөлмөрийн чадвар алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчин, эсвэл ноцтой бэртэл авах боломжтой ба энэ нь гараа хугалах, булчин шөрмөс сунах буюу тасрах зэрэг байж болох жишээний. Гэмтэл ба өвчлөл нь хохирогчийг нилээд хугацаанд ажлаас нь хөндийрүүлнэ. Ажил олгогч хоёр ба түүнээс дээш өдөр ажлаа зогсоож, өвчин буюу бэртлээс нь шалтгаалсан алдагдсан цагийн хохирол амсана.
- **Их хохирол учруулна:** Ноцтой бэртэл гэмтэл, өвчин, эсвэл нас барсан тохиолдол гарч болох бөгөөд урт хугацааны буюу бүрмөсөн гэмтэж, өвчилж, эсвэл нас барж болно. Тухайлбал, дуу шуугианаас үүдэлтэй сонсгол муудах явдал нь бүрмөсөн өвдөж буйн жишээ юм. "Амьдралыг өөрчлөх түвшний гэмтэл" бол энэ тохиолдолд нийтлэг, хөлөө тайруулах, гараа тайруулах, хараагүй болох зэрэг жишээ байж болно.

**b)** Муу зүйл тохиолдох магадлалын хувьд, дараах гурван түвшин байж болно:

- **Бага магадлалтай:** Хэн нэгэн хохирох магадлал бараг байхгүй, эсвэл маш бага байх.
- **Магадлалтай:** Хэн нэгэн гэмтэх буюу өвчлөх магадлал өндөр байх.
- **Өндөр магадлалтай:** Хэн нэг хүн бэртэж гэмтэх, өвчлөх нь бараг тодорхой тохиолдол.

**c)** *ЖДБ хамрах хүрээг* авч үзвэл, ЖДБ эрсдлийн зэргийн гурван түвшин байж болох ба тэдгээр нь эрсдэл үүсэх магадлал ба учрах хохирлын зэргийн үржвэрээр тооцогдоно:

- **Бага эрсдэлтэй:** Бага зэргийн гэмтэл буюу өвчин тусах эрсдэл байж болно. Ямар нэг зүйл тохиолдох магадлал нь бага, хор хохирол нь багаас дунд зэрэг байж болно.
- **Дундаж эрсдэлтэй:** Эрсдэл учрах магадлал бага байсан ч, хүнд хохирол учруулах түвшин нь өндөр байвал дундаж эрсдэлтэйд тооцогдоно. Мөн магадлалын түвшин ихсэхэд хүн гэмтэх буюу өвчлөхөд учрах хохирлын түвшин нь харилцан хамааралтайгаар нэмэгдэх тохиолдлыг дундаж эрсдэлтэйд бас авч үзэж болно. Өөрөөр хэлбэл, үр дагавар нь бага, дунд, их байж болно.
- **Өндөр эрсдэлтэй:** Өвчлөл, гэмтэл учрах буюу нас барах тохиолдол үүсэхэд учрах хохирлын түвшинд дундаж буюу өндөр магадлалтай бол ЖДБ эрсдлийн зэргийг өндөр гэж үзнэ. Энэ тохиолдолд тухайн нөхцөлд ЖДБ түвшинг хүлээн зөвшөөрөх нь хамгийн эхэнд авч хэрэгжүүлж эхлэх арга хэмжээг тодорхойлж, өндөр буюу хүлээн зөвшөөрөгдөхгүй хэмжээний эрсдэлийг хянахад тусална. Дундаж түвшний эрсдэл нь мөн хүлээн зөвшөөрөгдөхгүй түвшинд тооцогдож болох ба энэ нь тухайлбал осолд орж хүн мөрөө хугалж, эрүүл мэндийн улмаас ажиллаж чадахгүй цагаа алдаж байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөхгүйд тооцогдож болно.

Нөхцөл байдлыг засах арга хэмжээг аль болон хурдан авах ба ингэхдээ хурдан эхэлж болохуйц, гэхдээ бага зардал шаардахуйц арга хэмжээг боломжийн хэрээр сонгоно, тухайлбал мэдээлэл ба сургалт өгөх ажил байж болно. Бага эрсдэлтэй нөхцөлд авах арга хэмжээ нь яаралтай биш болович амархан, бага зардлаар хийж болох арга хэмжээг сонгон, аль болох хурдан эхлүүлж байх хэрэгтэй. Эдгээрийг өндөр эрсдэлтэй нөхцлийг хянах гэж буй арга хэмжээтэй хамт авч хэрэгжүүлж байсан ч болох бөгөөд авч хэрэгжүүлэх боломж л байгаа бол заавал хойш тавих хэрэггүй юм.

Зарим арга хэмжээг хялбархан хэрэгжүүлж болдог. Тухайлбал: ажлын журмыг өөрчлөх, үүнд аж ахуйн ажлыг хийх хуваарийг өөрчлөх гэх зэрэг орж болно. Бусад нь бага зэргийн цаг ба хүч хөдөлмөр шаардаж болно. Жишээ нь: дуу чимээ ихтэй машиныг дууны хамгаалалттай бүрээсээр бүрэх, тоос буюу утаа их ялгаруулдаг машинд агааржуулах систем суурилуулах гэх зэрэг. Цаг хугацааг тухайн нэг зүйлийг бүрэн сайжруулахад хэр их хугацаа хэрэгтэйг үндэслэлтэйгээр тооцсон байх хэрэгтэй.

Ажилчид хийгдэх гэж буй өөрчлөлтийн талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй ба боломжтой бол өөрчлөлтийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд оролцож байх хэрэгтэй. Нэмэлт сургалт хэрэгтэй ба ялангуяа эрсдэлийг хянах арга хэмжээ нь ажлын арга барил, туршлагыг өөрчлөх ажлыг багтаасан бол сургалт заавал хэрэгтэй болно.

Доорх хүснэгтэнд, бид мод боловсруулах ажлын байрыг жишээ болгон ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний дөрөв дэх алхмыг хийн, хүснэгтийг үргэлжлүүлэн бөглөнө. Энэ жишээнд, бид хариуцах хүнийг голчлон "менежер" эсвэл "супервайзор" байхаар санал болгосон. Бодит амьдрал дээр хариуцах хүнийг нэрээр нь зааж, хийх ажил ба үүрэг хариуцлагыг тохоон томилж өгөхийг санал болгож байна.

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3.А | Алхам 3.Б | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | **Хэн хийх** | **Хэзээ хийх** | **Хийсэн** |
| Модны тоосонд өртөх | Нийт ажилтнууд (35) уушигны өвчлөлд өртөх эрсдэлтэй, тухайлбал модны тоос амьсгалснаас астма-аар өвдөх боломжтой. Машины операторууд (15) өртөх эрсдэл илүү өндөр байна. Хатуу модны тоос хорт хавдар, ялангуяа хамрын хорт хавдар үүсгэдэг. | - Тоосыг хурдан зайлуулдаг.<br>- Гар угаах сайн хэрэгсэл болон шүршүүр хүртээмжтэй байдаг.<br>- Агаарт тархсан тоосноос хамгаалах маскаар хангасан, үргэлж шинэчлэн олгодог. | - Тоос гаргаж буй машин тус бүрийг тоос зайлуулах хэрэгслээр тоноглох (тоос сорогч машин, агааржуулагч)<br>- Ажилтнуудад хуурай модны тоосыг шүүрдэж болохгүй, оронд нь тоос сорогч ашиглах, эсвэл шүүрдэхийн өмнө норгож байхыг сануулах.<br>- Машины операторыг тоос ялгаруулагч машиныг ашиглах болон үндсэн тохиргоо, засвар үйлчилгээ хийхтэй холбоотойгоор мэргэжлийн хүнээр сургах. | Менежер<br><br>Супервайзор<br><br>Менежер | 2013.03.31<br><br>2013.05.15 (Яаралтай)<br><br>2013.11.05 | 2013.10.04<br><br>2013.05.15<br><br>2013.10.15 |
| Дугуй хөрөө, босоо зүсэгч, зорогч гэх зэрэг машин тоног төхөөрөмж | Машины операторууд (15) болон бусад ажилтнууд машины эргэлдэх хэсэг, ялангуяа хөрөөний ирэнд, хүрсэн тохиолдолд ноцтой гэмтэх, бүр нас барж ч болох аюул байна. | - Бүх машинд үйлдвэрлэгчээс өгсөн зааврын дагуу хаалт хамгаалалт хийгдсэн.<br>- Газардуулгыг тогтмол шалгаж, сайн ажиллаж байгаа эсэхийг нь баталгаажуулсан.<br>- Ажилтнууд машин дээр ажиллахдаа аюулгүй байхад хангалттай зай талбайтай.<br>- Ажилтнууд машиныг хэрхэн аюулгүй ашиглах талаар мэргэжлийн хүнээс сургалт авсан. | - Мод таслагч хөрөөг ажиллуулж буй машинд тоормос суулгах, ингэснээр модыг таслаж модны тоос цацруулах хугацааг богиносгох.<br>- Ирээдүйд зөвхөн тоормосны хянагчтай машин худалдаж авч байх.<br>- Модны зоргодос бага гаргадаг машин авч хэрэглэж болох боломжийг судлах.<br>- Ажилтнуудтай уулзаж, машины хаалт хамгаалалт хугацаандаа шалгагдаж, ямар нэг алдаа дутагдал гарсан бол тэр дор нь тайлагнаж байгаа эсэхийг дахин шалгах.<br>- Машиныг аюулгүй ашиглах талаарх мэдээллийн хуудсыг зөвхөн ажлын талбайд бус, амралтын өрөө, хоолны өрөө гэх зэрэг байршлуудад давхар байрлуулах. | Менежер<br><br>Менежер<br><br>Менежер<br><br>Супервайзор<br><br>Менежер | 2013.07.01<br><br>2013.05.13<br><br>2013.05.20<br><br>2013.05.15 (Яаралтай)<br><br>2013.05.15 | -<br><br>2013.05.13<br><br>2013.05.24<br><br>2013.05.15<br><br>2013.05.13 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Гар ажиллагаа | Хүнд болон овор ихтэй, мод хөрөөдөх тавцан, зүсэгч хөрөөдөгч машин тоног төхөөрөмж гэх зэргийг зөөснөөр булчин шөрмөсний өвчлөлд өртөж болно. Жишээ нь, нуруу өвддөг болох.<br>Тэд мөн багаж хэрэгсэлтэй ажиллах, өргөгчтэй ажиллах явцдаа зүсэгдэх эрсдэлтэй байна. | - Ажилтнууд гар ажиллагааг зөв хийх талаар сургалтанд суусан.<br>- Мужааны вандан болон машины ширээнүүд зохимжтой өндөрт байрласан.<br>- Гараар ажил хийх ажилтнуудад бат бэх, зузаан бээлий олгосон. | - Боломжтой бол мод хураах хэсгийг ажлын талбайн яг дэргэд байгуулж, хүнд ачаа зөөвөрлөх зайг багасгах.<br>- Ажилтнуудад хуучин өмч байсан бээлий нь урагдах юм уу, элэгдэхэд шинэ бээлий хүсч, авч байхыг сануулах.<br>- Хүнд ачаа өргөдөг хэсэгт бэртэл гэмтлээс сэргийлэхийн тулд хавтан тээвэрлэгч гэх зэрэг өргөх зөөх хэрэгсэл ашиглах. | Менежер<br><br>Супервайзор<br><br>Менежер | 2013.06.15<br><br>2013.05.15 (Яаралтай)<br><br>2013.06.01 | 2013.06.14<br><br>2013.05.15<br><br>2013.05.25 |
| **Алхам 5.** | | | | | | |

## АЛХАМ 5. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЖДБ-ЫН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНДЭЭ МОНИТОРИНГ ХИЙХ БА ДҮГНЭН ШИНЖЛЭХ, ШААРДЛАГАТАЙ БОЛ ШИНЭЧЛЭХ

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн эсэх |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Алхам 5. | | | | | | |

Эрсдэлийг хянах арга хэмжээг хэрэгжүүлэх нь ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үйл явцын төгсгөл биш юм. ***Үр дүнгээ бүртгэнэ:*** Алхам 5-д, үр дүнгүүдээ бүртгэн үзүүлж, илрүүлсэн аюулуудыг ноцтой нь бичиж тэмдэглээд, тухайн аюулын эрсдэлд ажилтнуудын ямар бүлэг, эсвэл бусад талууд өртөж байгааг бичнэ. Алхам 4-т тэмдэглэгдсэн, хэрэгжүүлэх гэж буй эрсдэлийг хянах арга хэмжээ, түүнийг хариуцах хүн болон хийгдсэн байх ёстой хугацаа зэрэг бусад мэдээллийг ойлгомжтой бүртгэн хөтөлж, ажилтнууд, супервайзорууд болон ХАБЭА-н байцаагч нарт уншигдахуйц байдлаар байршуулах хэрэгтэй.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үр дүнг хөтлөхөд тавигдах тусгай формат байхгүй. Энэхүү гарын авлагад жишээ болгон оруулсан хүснэгт нь ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний логик дарааллыг харуулах зорилгоор боловсруулагдсан бөгөөд та өөрийн хүссэн хэлбэр загвартай, энгийн, ойлгомжтой форматыг ашиглаж болно. Бодит байдал дээр, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үр дүн бол энд үзүүлсэн жишээнээс илүү нарийвчлалтай байдаг. Та яг ажил дээрээ эрсдэлийг үнэлгээ хийвэл, энд үзүүлсэн жишээнээс илүү олон төрлийн үйл явцад илүү олон тооны аюулыг илрүүлэх болно. Харин бид энд зөвхөн модны тоос, аюултай машин тоног төхөөрөмж, гар ажиллагаа гэсэн гурван аюулд төвлөрсөн. Харин мод боловсруулах үйл ажиллагаанд уг нь бол илүү олон төрлийн аюул, эрсдэл байгаа. Тэдгээр нь химийн бодист хордох, дуу чимээ, хальтирах, бүдрэх, унах, авто машинууд, цахилгааны аюул, гал гэх мэт байна.

ЖДБ-т зориулсан ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ нь академик баримт бичиг байх албагүй. Хэдийгээр зарим тохиолдолд ХАБЭА-н мэргэжлийн хүмүүс болон экспертүүд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний баримт бичгийг хөтөлдөг ч, угтаа бол энэхүү баримт бичиг нь аж ахуйн нэгжийн ажил олгогчдод зориулсан бөгөөд тэд хэрэглэж, эрсдлээ олж харж, хянах арга хэмжээг зөв зохистой хэрэгжүүлэхэд нь ойлгомжтой, энгийн байх ёстой юм. Тиймээс, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний онолын гэхээс илүү практикт хэрэглэхэд тохиромжтой, мөн нарийн нямбай үнэлгээ хийхэд зориулагдсан байх ёстой юм. Энэ нь дараах шаардлагыг хангах ёстой:

→ Үнэлгээг зөв хийсэн байх.

→ Гол ноцтой аюулуудыг бүрэн илрүүлж, авч үзсэн байх, тухайн аюулд өртөж болох хүмүүсийн тоо болон эмзэг бүлгийнхнийг тооцоолсон байх.

→ Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь компанийн зардал, үр ашгийн балансыг хангахуйц бөгөөд үүний дараа үлдэх ЖДБ-ын эрсдлийн зэрэг нь бага байх.

Энэхүү бичсэн бүртгэл нь ажил олгогч, супервайзор, ажилтнууд болон тэдний төлөөлөлд нэгэн адил

хэрэгтэй зүйл бөгөөд үйл ажиллагаандаа ашиглаж байхын тулд хадгалагдаж байх хэрэгтэй. Ашиглана гэдэг нь хүн бүрийг тодорхой аюулын талаар мэдлэгтэй байлгах болон холбогдох эрсдэлийг нь бууруулахад хэрэгтэй арга хэмжээг авахад ашиглагдана гэсэн үг юм. ЖДБ-ын  үнэлгээ нь ХАБЭА-н эсвэл хөдөлмөрийн байцаагчдын сонирхдог зүйл юм. Учир нь тэд тухайн байгууллагын ажил олгогч хуулиар шаардсан эрүүл, аюулгүй ажлын байраар ажилтнуудаа хангах үүргийг биелүүлсэн эсэхийг харах хэрэгсэл болдог юм.

**Хяналтын арга хэмжээний үр дүнг хянах:** Та мөн эрсдэлийг хянах арга хэмжээнийхээ үр дүнг хянаж, мониторинг хийж байх хэрэгтэй болно. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээр тодорхойлсон сайжруулах арга хэмжээнүүд хэрэгжиж үү? Тодорхойлсон аюул тус бүрт ЖДБ-ын эрсдлийн зэрэг багасч, аюулд өртөх хүмүүс илүү сайн хамгаалагдаж уу? Сайжруулсан эрсдэлийг хянах арга хэмжээг үр дүнтэй хэвээр байгаа эсэхийг хэн хянаж, мониторинг хийж байх вэ? Хэн таны аюултай машин механимын газардуулгыг шинэчилсэн байдлыг хянаж байх вэ? Хэн таны суурилуулсан агаар цэвэршүүлэгч, эсвэл тоос соруулагч тоног төхөөрөмж тоос болон хиншүүг үр дүнтэй шүүсээр байгаа эсэхийг шалгаж, баталгаажуулж байх вэ?

**ЖДБ-ын эрсдлийн үнэлгээндээ дүн шинжилгээ хийж, шинэчлэх**: ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ бол нэг удаа хийгээд өнгөрдөг ажил биш. Цагаас цагт байнга эргэн хянагдаж, илүү олон давтамжтай чаддаггүй юм аа гэхэд жилдээ ядаж нэг удаа дүгнэн шинжлэгдэж байх ёстой эд. Хэрэв та бизнесээ явуулахдаа л анхаараад байвал ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээ дахин хянахаа мартахад тун ч амархан, даанч ямар нэг осол гарч, бүх зүйл оройтсон байх нь элбэг. Тэгвэл, яагаад яг бодоо ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээ дахин хянах өдрийг товлож болохгүй гэж? Яг одоохон үүнийг тэмдэглэж аваад, жилийн ажлын төлөвлөгөөндөө оруул.

ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээ дахин нэг хараарай. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийснээс хойш танай байгууллагын үйл ажиллагаа, ашигладаг тоног төхөөрөмж зэрэгт ямар нэгэн өөрчлөлт орж уу? Хийх шаардлагатай ямар нэг сайжруулалт байгаа юм биш биз? Ажилтнууд тань ямар нэг асуудал байгааг олж харж уу? Осол болон осолд дөхсөн тохиолдлоос та ямар нэг сурч үлдсэн үү? Тийм бол, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээ үргэлж хамгийн сүүлийн үед нөхцөл байдалд нийцсэн байлгахад анхаарна уу.

Маш цөөн тооны ажлын байр л хэвээрээ байдаг. Хурдан, эсвэл удаан хугацаанд, та ямар шинэ тоног төхөөрөмж, химийн бодис, үйл ажиллагааны шинэ технологийг нэвтрүүлж, шинэ аюулыг үүсгэх л болно. Тиймээс, хийсэн байгаа, эсвэл хийж байгаа ажлаа тогтмол хянаж, дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Жил бүр, та одоо хаана байгаа, та ажлаа үргэлж сайжруулж, эсвэл хамгийн багадаа өөрийн хүрсэн үр дүнгээсээ ухрахгүй байхын тулд юу хийх хэрэгтэйгээ албан ёсоор үнэл.

Хэрэв томоохон өөрчлөлт гарсан бол заавал нэг жил болохыг бүү хүлээ. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээ дахин шалгаад, шаардлагатай бол өөрчлөн сайжруул. Хэрэв боломжтой бол, ямар нэг зүйлийг өөрчлөхөөсөө өмнө ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг хийж, аюул эрсдэлийг нь бодох нь хамгийн сайн байдаг. Энэ тохиолдолд, та өөртөө илүү уян хатан ажиллах боломжийг олгоно.

# БҮЛЭГ 2

## Багшийн хэрэгсэл – 14 хуудас

# Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх: Сургагч нарын шалгах хуудас

Энэхүү сургалтын багцад, бид идэвхитэй сурах арга барилын чухлыг онцлон авч үзнэ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь “Таны ажил дээрх эрүүл мэнд ба аюулгүй байдал” гэсэн нэртэй CD-ROM гаргасан.9 Энэ нь илүү нарийвчлан боловсруулсан зааварлагчийн удирдамжийг10 агуулсан. Бид хамгийн чухал элементүүдийг сонгосон ба доорх шалгах хуудсуудад дахин боловсруулж оруулав. Эдгээр нь сургагч багш нарыг ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үйл ажиллагааны талаар сургалт өгөхдөө сургалтаа төлөвлөх, явуулах, үнэлэхэд туслах мэдээллээр хангах болно.

## Гол зарчмууд

Юуны өмнө, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний сургалтанд маш сайн зохицдог, ерөөс орчин үеийн сургалтын арга зүйд суурь болж буй гол зарчмууд байдаг. ЖДБ-ын үнэлгээ гэдэг бол лекц сонсоод сурч болдог академик даалгавар биш. Энэ нь ажлын байранд хийгддэг аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулахад гардан хийдэг арга аргачлал, тиймээс оролцогч талуудыг өөрсдийн танил нөхцөл байдалд бүрэн оролцоотойгоор ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийлгэх илүү сайн арга зам юу вэ? Дараах шалгах хуудсанд гол зарчмуудаас заримыг нь үзүүллээ.

**ШАЛГАХ ХУУДАС: Сургалтын гол зарчмууд**

- Хийж байж сурдаг – Оролцогчид өөрсдийнхөө хийх хэрэгтэй зүйлсийг хийж байвал илүү сайн сурдаг.
- Хамтын ажиллагаа – Боловсролын үйл ажиллагаанд бүх хүнийг оролцуулж, мэдлэг, туршлага, чадварыг нэгтгэвэл сайн үр дүнтэй байдаг. Жижиг бүлгүүдээр ажиллуулж, үр дүнг эргэн тайлагнуулж байх нь хамгийн хойрго хүмүүсийг ч маш сайн дэмжиж, багт хувь нэмрээ оруулах, өөрийн мэдлэг ба туршлагыг өргөжүүлэн баяжуулахад нь тусалдаг. Ферм, тариалангийн талбай, барилгын талбай гэх зэрэг сурагч нарын өдөр тутамдаа нүүр тулж ажилладаг газрын бодит нөхцөл байдалд тулгуурлаж сургалтаа орох нь тухайн ажилтнуудад хамгийн үр дүнтэй байна.
- Арга хэмжээнүүд нь суралцагч нарыг нүүр тулдаг нөхцөл байдалдаа төвлөрч, сурч, түүндээ хамааралтайгаар дадлага хийхүйц тодорхой даалгаврууд байх хэрэгтэй. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний сургалтын удирдамж болгон зарим санал болгож буй үйл ажиллагааг доор үзүүлсэн тул та авч ашиглах буюу өөртөө нийцүүлэн ашиглах боломжтой. Та арга хэмжээнүүдийг өөрийн ажлын байрны үг хэллэг рүү хөрвүүлэн ашиглаарай.
- Тараах материал нь суралцагчид ирээдүйд сөхөн харж, ашиглахад нь тустай байдаг. Хэрэв танд цаг байгаа бол энэхүү удирдамжийн гол агуулгын заримыг нь (доор алхам-алхамаар үзүүлсэн удирдамж) суралцагч нартаа сургалтын дараа өгч болно.
- Сургалтыг үнэлүүлэх – ямар ч сургалтын дундуур албан болон албан бус үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөрт нь тэдний эрэлт хэрэгцээнд нийцэж буй эсэхийг дүгнэн шинжилж байх хэрэгтэй.

9 Accessed on: http://www.ilo.org/safework/info/instr/WCMS_113080/lang--en/index.htm

10 Accessed on: http://www.actrav.itcilo.org/actrav-english/telearn/osh/guide/gumain.htm

## Сургагчийн үүрэг

| **ШАЛГАХ ХУУДАС: Сургагчийн үүрэг** |
|---|
| Таны үүрэгт дараах орно:<br>▪ Суралцагчдын онцлогийг мэдэж, тэгш оролцоог дэмжих, ялангуяа хүйсийн хувьд, ичимхий оролцогчдыг нээн гаргах, давамгай оролцогчдыг бусдыгаа дэмжихэд чиглүүлэх.<br>▪ Багийн ажил, даалгавраа хийхэд нь болон хэрхэн ажиллахад нь тодорхой арга зам санал болгох замаар зохион байгуулалт хийх.<br>▪ Сургалтын зааврыг дагахад нь суралцагчдад туслах.<br>▪ Өөр үзэл бодол байж болохыг хүндэтгэх.<br>▪ Бие  даалт хийхэд нь туслах эх үүсвэр, үндсэн мэдээлэл, гарын авлага материал, ном хэвлэл, олшруулах төхөөрөмжөөр хангах (боломжтой бол).<br>▪ Сургалтын материалыг орон нутгийн хэл рүү хөрвүүлж, суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх.<br>▪ Зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх.<br>▪ Харилцан яриа үүсгэж, хариу авах.<br>▪ Зарим харилцан яриаг удирдаж, гол санаануудыг нэгтгэн дүгнэх.<br>▪ Хэрэв илүү нарийн мэргэжлийн юм уу, тухайн салбарын хүний мэдлэг хуримтлуулъя гэвэл гаднаас холбогдох мэргэжилтнийг урих. |

## Жижиг багийн ажил

Оролцогчдыг жижиг бүлгүүдэд ажиллахыг дэмжих нь сонгож болох гол сургалтын арга юм. Энэ нь ЖДБ-ын үнэлгээний сургалтанд сайн тохирдог. Насанд хүрсэн хүмүүсийг сургахдаа жижиг бүлгийн ажлыг сонгох хэд хэдэн сайн шалтгаан байдаг:

| **ШАЛГАХ ХУУДАС: Жижиг багийн ажил** |
|---|
| ▪ Энэ нь идэвхитэй амьд арга.<br>▪ Энэ нь хамтран ажиллахыг дэмждэг.<br>▪ Энэ нь өөртөө итгэл муутай оролцогчдыг харилцан ярианд татан оролцуулдаг.<br>▪ Энэ нь суралцагчдыг багш нь үргэлж харж байгаа гэсэн мэдрэмж өгөхгүйгээр хамтран ажиллах боломжийг олгодог.<br>▪ Энэ нь харилцан яриаг бүтэцжүүлэх үр дүнтэй арга зам болдог.<br>▪ Энэ нь оролцогчдыг аливаа зүйлийг судлан шинжлэх, харилцан ярилцах, өөрсдийнх нь ажилд тулгардаг асуудлуудад хариулт олох боломжтой болгодог. |

Онолын хувьд, жижиг бүлэгт хуваахдаа нэг багт гурваас дөрвөн оролцогч байлгах нь гишүүн бүрийн оролцоог хамгийн ихээр дэмждэг гэж үздэг.

## Идэвхитэй оролцоо

Насанд хүрэгчид сурах үйл явцад идэвхитэй оролцсон үедээ хамгийн сайн сурдаг. Мөн сургалтын үеэр өөрийн туршлагаа хуваалцан ярихыг нь дэмжсэн орчинд сайн сурдаг. Ийм төрлийн сургалтыг ерөнхийд нь “Оролцооны” эсвэл “Оюутан төвтэй сургалт” гэж нэрлэдэг. Энэ аргын давуу талд дараах орно:

→ Сурах процесс суралцагчдын туршлагаас эхэлж, туршлага дээр нь ажиллаж өнгөрнө.

→ Сургалтанд оролцогчид хамтран ажилладаг бүлгийн үйл ажиллагаа, харилцан яриагаар сурдаг.

→ Суралцагчид өөрсдийн асуудлын талаар бодож, дутагдлаа тодорхойлох, түүндээ үндэслэн олон тооны чадвараа сайжруулах боломжтой байдаг.

Оролцооны аргад суурилсан сургалт нь суралцагчдыг мэдээлэл өгөх, эсвэл авахыг шаарддаг. Энэ аргаар, оролцогчид өөрийн туршлагадаа суурилан бие биенээсээ суралцдаг. Оролцогчдын туршлагаас суралцах нь тэднийг мэдээлэл олж авах, сурах, мэдээллийг тогтоож үлдэхэд тусалдаг. Сургагчид зааварлан чиглүүлэх арга техникүүдийг ашиглаж болох бөгөөд дараах идэвхитэй оролцооны шалгах хуудаст заасан зарчмуудад ч суурилж болно.

**ШАЛГАХ ХУУДАС: Идэвхитэй оролцоо**

- Суралцагчдад аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хамгаалахын тулд авч хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээг санал болгох тал дээр санал бодлыг нь сонсон ярилцах боломжийг байнга олго.
- Оролцогчдын оруулж чадах чухал хувь нэмрийг нь хувь хүнийх нь туршлагад суурилан үнэлж, үнэ цэнэтэй мэдээлэл хуваалцахыг нь зөвшөөр.
- Сургалтандаа лекцийн хэлбэрийг аль болох бага хэрэглэ. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний сургалтын агуулгыг логик алхмуудад хувааж, оролцогчдыг сурч болохуйц үйл ажиллагаануудыг бий болгон хийлгэж, харилцан яриаг хөхүүлэн дэмж.
- Заавар өгөхдөө ардчилсан байр сууртай байж, тухайн сургалтын зарим хяналтыг суралцагч нарт өгч суралцагчид өөрсдөө удирдах боломжийг олго.
- Суралцагчдыг чиглүүлж, бүтцийг нь тодорхой болгох замаар сурах үйл явцад нь тусалж, чиглүүл.
- Дуу, бүжиг, жүжиг гэх зэргийг гол мэдээлэл болон сургах гэсэн зүйлдээ ашигла.
- Сургалтын танхимд сурах үйл ажиллагаан дээр нь нэмж, зохион байгуулалтай ба практик дадлагуудыг бодит ажлын байран дээр хийлгэ.
- Сургалтын турш суралцагчдыг өөр өөр даалгаврууд дээр төвлөрүүл.
- Оролцогчдод бусдаасаа сурах боломж олго.
- Сургалтанд хэн нэг суралцагч давамгайлах нөхцөл байдал үүсгэхээс сэргийл.
- Дуугүй суудаг оролцогчдыг илүү яриулж, сургалтанд оролцохыг нь дэмж.

## Төлөвлөгөө ба бэлтгэл

Сургагчид сургалтандаа нямбай бэлдсэн байх нь чухал. Гэхдээ энэ нь та суралцагчдын онцлог болон туршлагад хариу үзүүлэхгүй зөвхөн төлөвлөснөө л хий гэсэн үг биш. Гэхдээ та үндсэн төлөвлөгөөтэй байх хэрэгтэй ба төлөвлөсөн арга хэмжээнүүдээ хэрэгжүүлж, гарын авлага материалаа ашиглах, сурагчдад бал цаас өгөх, хөтөлбөрийн цагийн хуваарийг баримтлах зэрэг нь зайлшгүй бэлтгэлүүдийн нэг юм.

**ШАЛГАХ ХУУДАС:** Төлөвлөгөө, бэлтгэл

- Сургалт хийхээсээ өмнө хичээлийн төлөвлөгөө (доорх жишээг үзнэ үү) эсвэл сургалтын агуулгын төлөвлөгөөг боловсруул. Сургалтын төлөвлөгөөндөө: сургалтын зорилгыг танилцуулах, текстийн гол суурь, санаж авах ёстой гол агуулга, тойм ба ангид болон бие даан хийх ажлуудын танилцуулгыг багтаагаарай.
- Сургалтын материал, ялангуяа багийн ажлын даалгавруудыг орон нутгийн хэл рүү орчуулах хэрэгтэй.
- Сургалтанд ашиглах самбар, ватум цаас, маркер, цаас, үзүүлэн, зураг зэргийг марталгүй бэлтгэ.
- Зарим арга хэмжээний хувьд, сургалтын материалыг хувилж авсан байх.
- Оролцооны өөр өөр аргуудыг ашиглаж, оролцоонд суурилсан сургалтаа сонирхолтой болгоорой.
- Шинэ сургалтын материал эсвэл шинэ сургалтын аргуудаа боловсруулсан бол тэдгээрийг Сургалтын Багцдаа оруулаарай.

Та сургалтын хэсэг бүрт хичээлийн төлөвлөгөө бэлтгэх хэрэгтэй. Төлөвлөгөөний жишээг доор үзүүлэв:

| Сэдвийн нэр: | | | |
|---|---|---|---|
| Агуулга: | Хугацаа: | Сургалтын аргууд | Сургалтын туслах хэрэгслүүд (материал, тоног төхөөрөмж, үзүүлэн, багийн ажлын хуудсууд гм) |
| Сэдвийн зорилго | | | |
| Танилцуулга | | | |
| Тектсний гол агуулга | | | |
| Санаж байх ёстой агуулга | | | |
| Үйл ажиллагаа | | | |
| Харилцан яриа | | | |
| Тойм | | | |

## Сургалтын арга зүй

Доорх шалгах хуудсанд сургалтын олон төрлийн арга зүйн талаарх товч тайлбар болон удирдамжийг үзүүлэв:

| ШАЛГАХ ХУУДАС: Сургалтын арга зүй |
| --- |
| ▪ Асуулт асуух: Асуултыг харилцан яриаг өдөөх маягаар тавих бөгөөд хүнийг айлгах, мууг нь мэдрүүлэх маягаар тавьж болохгүй.<br>▪ Шалгах хуудас ашиглах: Шалгах хуудсыг суралцагчдад тохируулан ашиглах бөгөөд суралцагчдаар өөрсдөөр нь, болж өгвөл багаар ажиллуулж, боловсруулуулах хэрэгтэй.<br>▪ Түргэн зуур санаа гаргах, тархин шуурга хийх: Суралцагчдыг олон төрлийн санаа гаргахыг дэмжсэн техникүүд ашигла. Оролцогчид ярилцаж буй сэдвийнхээ талаар толгойд хамгийн түрүүнд орж ирсэн санаагаа дэвшүүлнэ.<br>▪ Арга хэмжээг төлөвлөх: Арга хэмжээний төлөвлөгөөг хувь хүн бүр эсвэл багаараа боловсруулж болно. Оролцогчид ажлын байрыг сайжруулах зэрэг арга хэмжээний стратегийг бодож олж, боловсруулах хэрэгтэй.<br>▪ Ажлын байрны болон бүлгийн ажлууд: ажлын байр болон олон нийтийн үйл ажиллагаатай уялдуулж болохоор бол, бодит ажлын байранд аюулыг илрүүлэх юм уу, олон нийтийн орчин дахь асуудлыг шийдлийн хамт эрж хайх даалгавар өгснөөр заасан хичээлийг бодит амьдралтай уялдуулан ойлгуулах боломжтой.<br>▪ Сургалтын уулзалтууд: Энд илүү ардчилсан зарчмаар суралцагчид сургалтын бүтэц болон агуулгад санал хэлэх уулзалтууд хийж болно.<br>▪ Жижиг бүлгийн ажлууд: Жижиг бүлгийн ажлаар ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийх нь гол сургалтын арга болох хэрэгтэй.<br>▪ Бүлгийн харилцан яриа: Сургагч нар оролцооны сургалтынхаа нэг хэсэг болгон харилцан яриаг өдөөж, хөхүүлэн дэмжиж, туслах нь хамгийн чухал.<br>▪ Кейсийг судлах: Кейс судлах ажлыг багш нар үр дүнтэй ашиглаж болно.<br>▪ Дүрд тоглох: Дүрд тоглох нь идэвхитэй сурах, оролцуулах арга бөгөөд оролцогчид маш сайн нягтарч, хоорондоо харилцдаг. Ялангуяа, оролцогчид тодорхой ажлын байранд хэн нэгний албан тушаалын дүрд тоглож болно. Дүрд тоглох ажиллагааны хэлбэр нь ярилцлага хийх, хэлэлцээр хийх, уулзалтанд оролцох, эсвэл ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд оролцох ажил байж болно. |

## Сургалтын үнэлгээ

Сургалт өөрөө бүлгийн ажил, идэвхитэй оролцоонд тулгуурласан тул үнэлгээ нь бас хамтын үйл явц байж болно. Энэ нь сургалтын талаар сурагчид хувьдаа болон багаараа өгөх үнэлгээ юм. Тэд сургалтын сэдэв ба агуулгад өөрт нь хамааралтай байсан эсэх, ямар мэдлэг мэдээлэл олж авсан, давуу ба сул тал нь юу байсан гэдгийг үнэлж болно. Энэ нь сургалтын дундуур явагдах хэрэгтэй.

**ШАЛГАХ ХУУДАС: Үнэлгээ**

- Сургалтаас өмнө, сургалтын зорилгоо тодорхойл.
- Эхний, эсвэл хоёр дахь хичээлийн дундуур, суралцагчид сургалтаас юу хүсч байгааг нь болон бүгдээрээ юу өөрчлөхийг хүсч байгааг нь мэдэж авах.
- Сургалтын уулзалтуудыг хийж, урьдчилан бэлтгэсэн уулзалтын хөтөлбөрийн дагуу санал хүсэлтийг нь сонс.
- Сургалт/дадлага тус бүрт суралцагчид даалгаврын зорилго болон тэднээр юу хийлгэх гэж байгааг ойлгосон эсэхийг шалгаж бай.
- Сургалтын дунд үед сургалтын явцыг дүгнэж байх.
- Сургалтын төгсгөлд үнэлгээ ав.
- Боломжтой бол, сургалт дууссанаас хойш хэдэн долоо хоног юм уу, хэдэн сарын дараа суралцагчдаас түүвэрлэн сургалтаас олж авсан мэдлэг нь ажил дээр хэр хэрэгжиж байгаа, хэрэгтэй байж чадаж байгаа эсэх талаар лавлаж бай.

## 2. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээгээр хийх арга хэмжээнүүд

Суралцагч нарт ЖДБ-ын эрсдлийн үнэлгээг ойлгуулж, энэ бол “хийж болохуйц” ажил гэсэн итгэл төрүүлэх гол аргуудын нэг бол тэдэнд төрөл бүрийн үйл ажиллагааг ашиглан алхам алхмаар үнэлгээ хийлгэж ажиллуулах явдал юм. Доор энэ зорилгоор хийлгэж болох дөрвөн үйл ажиллагааг санал болгосон ба эдгээр нь суралцагчдыг ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний үйл явцын 1-3 дугаар алхмыг хийхэд нь чиглүүлнэ.

Алхмууд нь: аюулыг илрүүлэх (Алхам 1), хэн яаж эрсдэлд байгаа вэ (Алхам 2), эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, шийдэх(Алхам 3.А ба 3.Б), арга хэмжээний ЖДБ-ын эрсдлийн зэргийг үнэлж, эрэмбэлэх (Алхам 4-ийн хэсэг). Арга хэмжээнүүд нь Алхам 4-ийн нөгөө хэсэг (хяналтын арга хэмжээг хэн хэрэгжүүлэхийг тодорхойлох) болон Алхам 5 (ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд мониторинг хийх, дүгнэн шинжлэх)-д зориулагдаагүй. Учир нь эдгээр нь “бодит амьдрал дээр” хийгдэх учиртай тул дэлгэрэнгүй ярих хэрэггүй юм.

Энд танилцуулсан үйл ажиллагаанууд нь өөр өөр ажил хийдэг суралцагчдаас бүрдсэн ангид хэрэглэвэл тохиромжтой. Жижиг бүлгүүдийг ажил мэргэжлээр нь ангилан бий болгоод, ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийсэн үр дүнгүүдийг нь харьцуулбал сонирхолтой байж болно. Мөн эдгээр үйл ажиллагаанууд нь илүү энгийн, өөрсдөд нь хамааралтайгаар ашиглагдаж болно, тухайлбал тухайн нэг ажлын байран дахь аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх, үүнд суурилан сайжруулах арга хэмжээ санал болгоход ашиглагдаж болно. Энэ нь тухайлбал сургалтын хамрах хүрээнд аль нэг ажлын байранд зочилж, бодит байдал дээр ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийж үзэх боломжтой үед илүү сонирхолтой байх болно. Эсвэл эдгээрийг заавал сургалтын нэг хэсэг болгож биш, бодит амьдрал дээр байгууллагын ажлын байранд ЖДБ-ын эрсдлийн үнэлгээ хийхэд ч ашиглаж болно. Ямар ч тохиолдолд ашиглагдсан байсан, үйл ажиллагааны хуудсууд нь зорилгодоо нийцэхүйц байдлаар өөрчлөгдөж, сайжруулагдах хэрэгтэй гэдгийг сануулъя.

### *Үйл ажиллагааны жагсаалт:*

*Үйл ажиллагаа 1*

АЛХАМ 1: Ажлын байрны аюулыг илрүүлэх

*Үйл ажиллагаа 2*

АЛХАМ 2: Хэн хэрхэн эрсдэлд байна вэ?

*Үйл ажиллагаа 3*

АЛХАМ 3.А ба 3.Б.: Эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, сонгох.

*Үйл ажиллагаа 4*

АЛХАМ 4: ЖДБ-ын эрсдлийн зэргийг үнэлж, арга хэмжээний эрэмбийг тогтоох.

## Үйл ажиллагаа 1 АЛХАМ 1: АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛЫГ ИЛРҮҮЛЭХ

- **ЗОРИЛГО:** Дараах зүйлсийг хийхэд тань тусална:
  - → Ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл мэндийн олон төрлийн аюул, тэдгээрийн онцлогийг тодорхойлох.
  - → ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний загвар дахь хүснэгтний эхний баганыг бөглөх буюу Алхам 1-ийг хийх.
- **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Багийн нэг гишүүнийг сонгон харилцан яриаг удирдаж, үр дүнг ватум цаас болон жижиг картууд дээр бичүүлнэ. Нөгөө гишүүнийг картуудыг ангийнхандаа тайлбарлан ярьж өгнө.
- **ДААЛГАВАР:** Энэ бол “тархин шуурга” хийх үе. Та бүхэн багуудад хуваагдана. Жижиг багууддаа, ажлын байран дахь ямар аюул ажилтнуудыг заналхийлж байгаа талаар ярилц. Та өөрийн ажлын байр эсвэл зочилж байсан ажлын байрныхаа аюулуудын талаар бодож болно. Мөн хуудас 61-70-д үзүүлсэн хэдийнэ ажилласан жишээг ашиглаж болно.

  Ватум цаасан дээр аюулуудыг жагсаан бич. ЖДБ-ын эрсдлийн үнэлгээндээ аюулын бүхий л төрлийг хамруулахын тулд системтэйгээр ажиллаж, дараагийн хуудсанд үзүүлсэн категорийг ашиглахыг хичээгээрэй. Тэрхүү категорид заавал тодорхойлох ёстой аюулгүй байдлын аюулууд; үргэлж далд оршин байдаг эрүүл мэндийн аюулууд; болон зохион байгуулалтын аюулууд багтсан байгаа. Хэрэв та аюулыг аль ангилалд багтахыг нь шийдэж чадахгүй байвал бүү санаа зов, зүгээр л бичээд бай. Хүн бүрийн санааг бичиж аваарай – хүн бүрийн санаа дараагийн хүнийх шигээ чухал бөгөөд хүчин төгөлдөр. Тэнд зөвшөөрөл өгөх хэрэг байхгүй.

  Хэрэв бүлэг аюулуудаа тодорхойлж дууссан бол одоо хамгийн чухал дөрвөн асуудал юу вэ? гэдгийг сонгож, бүлэгт тань өгсөн картуудад тэдгээрийгээ бичнэ. Үүний тулд, та бүхэнд мөн наалддаг цаас эсвэл цавуу өгсөн байгаа. Түүнийгээ ашиглаад, хананд картуудаа наана уу. Ярих хүн нь бүлгийнхээ картуудыг танилцуулан ярина. Харин картууд нь хананд байгаа ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний загварын эхний баганад наагдана.

## Энэ даалгаварт таныг аюулыг илрүүлэхэд туслах нь:

Аюул ба Эрсдэл гэсэн нэр томъёоны ялгааг Бүлэг 1-н 9-р хуудсанд байгаа Аюул ба Эрсдэл гэсэн хэсгээс үзнэ үү. "Аюул" гэдэг нь юу ч байж болно, жишээ нь ажилд ашиглах түүхий эд материал, аюултай химийн бодис, туслах бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, ажлын муу арга барил, дадал зуршил, хандлага гэх зэрэг аюул учруулж болох бүхий л зүйл орно гэдгийг санаарай. Дараах категорийг та ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээгээр бүхий л төрлийн аюулыг илрүүлэхийн тулд анхаарч авч үзээрэй:

**Аюулгүй байдлын буюу "илэрхий" аюулууд.** Жишээ нь:

→ Машины хөдөлдөг хэсэг хаалт хамгаалалтгүй байх
→ Хэрчих огтлох хэрэгслүүд
→ Хүнд ачаа гараар өргөх, ачаатай ажиллах
→ Цахилгаан: Барилгын цахилгааны сүлжээ, уртасгагчид, зөөврийн тоног төхөөрөмж
→ Хашлагагүй явган хүний зам, шат гм.
→ Унаж буй объект – хайрцаг, сав, баглаа боодол, хүнд юм, модны мөчир эсвэл жимс
→ Муу гэрэлтүүлэг
→ Саад – ажлын байрны эмх цэгцгүй байдал, ажлын талбайн зорчих хэсгийг юмаар тагласан байх
→ Шатамхай шингэн
→ Могой, зэрлэг амьтад

**Эрүүл мэндийн буюу "нуугдмал" аюул.** For example:

→ Дахин давтагддаг ажлууд
→ Дуу чимээ
→ Хортон устгагч ба бусад аюултай/хортой химийн бодис
→ Тоос
→ Өвчин үүсгэгч бичил организмууд
→ Чичиргээ
→ Урт хугацаанд зогсч ажилладаг, ажил нь суух боломжгүй байх
→ Сандал болон компьютерын дэлгэц
→ Эрс тэс уур амьсгал, цаг агаар

**Зохион байгуулалтын аюул.** Өмнө нь аюулгүй байдал ба эрүүл мэндийн нөхцөлтэй холбогдолтойгоор авч үздэггүй байсан зарим чухал асуудлууд байдаг. Тухайлбал:

→ Ажлыг зохион байгуулах арга зам – Ажлыг хийх тодорхой журам, практик байна уу? Аливаа ажлыг аюулгүй хийх тухай мэдээлэл, сургалтыг тохиромжтой байдлаар өгч байна уу?
→ Ажлаа хийхдээ ур чадвар муутай байх
→ Ажлын зохион байгуулалт муу, нэг хэвийн ажил байнга хийх
→ Урт цагаар ажиллах, амрах цаг бага байх, дараалсан ажил, ээлжийн ажил
→ Бэлгийн дарамт, эсвэл дээрэлхэж дарамтлах гэх зэрэг бүх төрлийн дарамт үзүүлэх
→ Хүчин, халдлага
→ Ажилтнуудын зиндаа бий болох
→ Ганцаараа ажиллах

Эдгээр нь зөвхөн цөөн жишээ юм. Ажлын байранд байдаг илүү олон төрлийн аюулууд бий.

## Үйл ажиллагаа 2 АЛХАМ 2: ХЭН ХЭРХЭН ЭРСДЭЛД БАЙНА ВЭ?

- **ЗОРИЛГО:** Дараах зүйлсийг хийхэд танд туслах:
  → Таны тодорхойлсон аюулуудад хэн өртөж байгаа, эсвэл хэн тухайн аюулын эрсдэлд өртөхөөр байгааг тодорхойлох.
  → "Нуугдмал" буюу "мартагдсан" ажилтнууд болох гэрээт ажилтнууд, засварын болон хүргэлт үйлчилгээний ажилтнууд, цэвэрлэгч үйлчлэгчид, олон нийтийн ажил хийдэг хүмүүс гэх мэт тухайн гүйцэтгэж байгаа ажил нь аюултайд тооцогдохгүй, анзаарагддаггүй ажлын шаардлага бүхий хүмүүсийн бүлгийг анхаарч үзээрэй.
  → Таны илрүүлсэн аюулд тэдгээр хүмүүс хэрхэн өртөж болохыг бод.
  → ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний загвар/хүснэгтний 2-р баганыг бөглөж, хэн хэрхэн эрсдэлд өртөж байгааг бичнэ.
- **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Багаасаа нэг хүнийг сонгож, харилцан яриаг удирдан зохион байгуулах, үр дүнгүүдийг ватум цаас болон картууд дээр бичихээр томил. Өөр нэг хүнийг ангийнхандаа ярьж танилцуулахаар томил.
- **ДААЛГАВАР:** Жижиг бүлгээр, дараах хүснэгтийг ватум цаасан дээр зур.

| Аюул | Хэн хамгийн их эрсдэлд байна вэ? | Өөр хэн эрсдэлд өртөж болзошгүй вэ? | Тодорхой эмзэг бүлэг (Яагаад тэд эмзэг вэ?) | ҮР ДАГАВАР (Аюулд өртсөн хүмүүс хэрхэн бэртэж гэмтэх, эсвэл хохирох вэ?) |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |

Эхний баганад, өмнөх даалгавраар тодорхойлж, ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний хүснэгтэнд жагсаасан аюулуудаас хамгийн ноцтой эсвэл аюултай дөрвөн аюулыг жасаан бич. Аюул тус бүрт, хэн хамгийн их эрсдэлд байгааг бодож хоёрдугаар баганад бич. Гуравдугаар баганад хэн эрсдэлд мөн өртөж болох вэ гэдгийг бүртгэ. Ажилтнууд, бүлэг хүмүүсийн талаар бод, тухайлбал гэр бүлийн гишүүд, олон нийт, эсвэл аюулд өртөж болох өөр хэн нэгэн. Дөрөв дүгээр баганад, эмзэг бүлгийн байж болох хүмүүсийн талаар бод (хүүхдүүд, жирэмсэн эхчүүд гэх мэт). Тэд яагаад эмзэг бүлэгт орсон бэ гэдгийг бас бичнэ. Тавдугаар баганад, тухайн аюулын үр дагавар юу байж болохыг бичнэ.

Хүн бүрийн санал болгосон зүйлсийг бичих бөгөөд хүн бүрийн санаа ижил тэнцүү чухал. Тиймээс дараагийн хүнийхийг сонсохын тулд эхний хүний санааг орхигдуулж болохгүй. Мөн ярьж, саналаа хэлэхэд ямар нэг дараалал, ач холбогдолтой эсэхийг нь шүүн тогтоох хэрэг байхгүй.

Ингээд баг тус бүр гаргасан дүгнэлтүүдийнхээ тоймыг картан дээр бичиж, "хэн хэрхэн эрсдэлд байна вэ?" гэсэн нэртэй ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний хэсэгт ханан дээр картуудаа наана. Багаа төлөөлөн ярих хүн нь багийнхаа картуудыг тус бүрт нь тайлбарлан ярина.

**Энэхүү даалгаварт та дараах зүйлсийн талаар бодоорой:**

**Эрсдэлд байгаа ажилтнууд:** Тодорхой нэг аюулын эрсдэлд бүх ажилтан өртөхөөр байна уу, эсвэл энэ нь зөвхөн тодорхой нэг жижиг бүлэг хүмүүст хамааралтай байна уу? Тухайлбал, мод боловсруулах, эсвэл метал боловсруулах байгууллагын харуул, эсвэл хөрөөн дээр ажилладаг ажилтнууд л аюулд өртөхөөр байж болно. Мөн тэрхүү бүлэг ажилтнуудын аюулгүй байдал ба эрүүл мэнд нь тухайн нэг аюулд өртсөнөөр ямар үр дагаварт хүрч болох вэ?

**Гадны ажилтнууд:** Засвар, үйлчилгээний ажилтнууд, хүргэлт/тээвэрлэлтийн ажилтнууд гэх мэт. Жишээлбэл, хүргэлтийн ажилтнууд харилцагч байгууллагын буюу танил бус ажлын байранд ачаа зөөж байгаад ачигч машинд дайруулах эрсдэл байж болно. Тэгвэл, энэ бүлэг хүмүүсийн тухайн аюулд өртсөнөөр үүсэх аюулгүй байдал ба эрүүл мэндийн үр дагавар нь юу вэ?

**Эмзэг бүлгийн ажилтнууд:** Байгууллага дотор тусгай эмзэг хүмүүс байж болно: залуу ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд, жирэмсэн ажилтнууд, гэх мэт. Тэгвэл, тэдгээр хүмүүсийн хувьд тодорхой аюулд өртсөнөөр ямар нэмэлт аюулгүй байдал ба эрүүл мэндийн эрсдэл үүсч болох вэ? Энэ бүлгийн ажилтнууд аюулд өртсөнөөр үүдэн гарах үр дагавар нь юу вэ?

**Бусад:** Өөр ямар хүн эрсдэлд байж болно гэж бодож байна вэ? Тухайлбал, барилгын талбайн хажуугаар алхан өнгөрч байгаа хүмүүс, эсвэл краны доогуур түр замаар явж байгаа хүн байж болно. Тэрхүү аюулд өртөж болох иргэд, хөршүүдэд үүсэх эрүүл мэнд, аюулгүй байдлын ямар үр дагавар байх вэ?

## Үйл ажиллагаа 3 АЛХАМ 3.А ба В: ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ, ШИЙДЭХ

- **ЗОРИЛГО:** Дараах зүйлсийг хийхэд танд туслах:

→ Одоогийн хамгаалалтууд тохиромжтой байгаа эсэхийг тодорхойлох.

→ Нэн түрүүнд анхаарах аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг эрэмбэлэх алхмуудыг бодох.

→ Арга хэмжээг хамгийн үр ашигтай байх талаас ажилла.

→ ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний загвар дахь эрсдэлийг бууруулах арга хэмжээний 3.А ба 3.Б алхмуудыг хүснэгтний гурав ба дөрөвдүгээр баганад бич.

- **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Багаасаа нэг хүнийг сонгож, харилцан яриаг удирдан зохион байгуулах, үр дүнгүүдийг ватум цаас болон картууд дээр бичихээр томил. Өөр нэг хүнийг ангийнхандаа ярьж танилцуулахаар томил.

- **ДААЛГАВАР:** Жижиг бүлгээр, дараах зургаан баганатай хүснэгтийг том цаасан дээр зур.

| АЮУЛ | ЯМАР АРГА ХЭМЖЭЭГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА ВЭ? | ТИЙМ? | ХЭРХЭН? | ҮГҮЙ? | ЯАГААД? |
|---|---|---|---|---|---|
| | Эрсдэлийг хянах арга хэмжээ 1: Аюулыг устгах буюу орлуулах | | | | |
| | Эсрдэлийг хянах арга хэмжээ 2: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи, инженерингийн аргуудыг ашиглах | | | | |
| | Эрсдэлийг хянах арга хэмжээ 3: Аюулгүй ажиллах арга барил, туршлага, зохион байгуулалт, мэдээ мэдээлэл түгээх, сургалт өгөх аргуудыг ашиглах | | | | |
| | Эрсдэлийг хянах арга хэмжээ 4: Эрүүл ахуй ба ахуй байдлыг сайжруулах аргууд | | | | |
| | Эрсдэлийг хянах арга хэмжээ 5: Хүнийг хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах арга | | | | |
| | Эрсдэлийг хянах арга хэмжээ 6: Эрүүл мэндийн үзлэг, эмчийн хяналтын үзлэгүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх (эмчийн хяналтын үзлэгт төрөл бүрийн шинжилгээ, рентген зураг багтана, орч.) | | | | |

Одоог хүртэл хийсэн байгаа ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний аюулуудыг хараад энэхүү даалгаврын суурь болгон ашиглаж, эхний баганад бич. Дараа нь дараагийн дөрвөн баганыг бөглө. Танай багийн авч үзэж байгаа аюул тус бүрт дараах зүйлсийг бод:

→ Та эрсдэлийг хянах хамгийн эхний арга хэмжээ болох аюулыг устгах, эсвэл аюултай бодис юм уу машиныг аюул багатайгаар орлуулж болох уу?

→ Хэрэв эхний арга хэмжээг “хийж болно” гэж хариулсан бол та дараагийн баганад хэрхэн аюулыг устгах буюу орлуулах талаар тайлбарла.

→ Хэрэв “болохгүй” гэж хариулсан бол яагаад яг энэ арга хэмжээ (устгах эсвэл орлуулах)-г сонгоогүй вэ гэдгээ бичнэ.

→ Дараа нь дараагийн арга хэмжээ (хамтад нь хамгаалах инженерингийн арга) рүү шилжиж, энэ мэтээр дасгалыг үргэлжлүүлэн хийнэ.

→ Үүнийг тодорхойлсон аюул тус бүрээр бүрэн хийнэ.

Та нэгээс олон шийдлийг сонгож болох бөгөөд сонгосон бүх арга хэмжээгээ жагсаан бичнэ. Хэрэв баг гаргасан бүх шийдвэр, түүний шалтгааныг ватум цаасан дээр бичсэн бол үүний үр дүн буюу хэрэгжүүлэхээр шийдсэн арга хэмжээгээ картууд дээр бичнэ. Картуудаа ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний хүснэгт зурсан хананы холбогдох баганад наана. Ингээд хийсэн үнэлгээгээ ангийнхандаа танилцуулан ярина.

## Үйл ажиллагаа 4 АЛХАМ 4: ЖДБ-ЫН ЭРСДЭЛИЙН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ, ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРЭМБИЙГ ТОГТООХ

- **ЗОРИЛГО:** Дараах зүйлсийг хийхэд танд туслах:
  - → ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээ ба аливаа хор хохирол учрах магадлал ба хүнийг гэмтээх, өвчлүүлэх хор хохирлын хэмжээний уялдаа холбоог ойлгох.
  - → Аль аюул нь хамгийн хор хохирол учруулах эрсдэлтэй байгааг бодож, түүнд үндэслэн эрсдэлийг хянах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын эрэмбийг тогтоох.
- **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Багаасаа нэг хүнийг сонгож, харилцан яриаг удирдан зохион байгуулах, үр дүнгүүдийг ватум цаас болон картууд дээр бичихээр томил. Өөр нэг хүнийг ангийнхандаа ярьж танилцуулахаар томил.
- **ДААЛГАВАР:** Жижиг бүлгээр, дараах ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний матрицыг том цаасан дээр зур.

| | | Боломжит хохирол буюу үр дагавар | | |
|---|---|---|---|---|
| Тохиолдож болох магадлал | | Бага зэрэг хохирол учруулна | Дундаж хохирол учруулна | Их хохирол учруулна |
| | Бага магадлалтай | Бага эрсдэлтэй | Бага эрсдэлтэй | Дундаж эрсдэлтэй |
| | Магадлалтай | Бага эрсдэлтэй | Дундаж эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй |
| | Их магадлалтай | Дундаж эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй |

ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний дасгалын хамгийн эхэнд тодорхойлсон аюулуудыг судална уу. Аюул тус бүрт, түүнд өртсөнөөр ямар хохирол учрахыг тооцоол. Үүнийг тарааж өгсөн жижиг наалттай цаасан дээр бич.

Тодорхойлсон үр нөлөө (хорт хавдар, уушигны өвчлөл, гараа тасдах, стрессээс болж ажил таслах, машины аюул, гэх мэт) тус бүртээ хохирлын зэргийг анхааран авч үзэх. Үр нөлөө нь бага зэргийн хохирол учруулах уу, дундаж эсвэл их хохирол учруулах уу?

Мөн та хохирол учруулахад хүргэж болох магадлалыг тооцоолох ёстой. Ийм төрлийн аюул тохиолдох магадлал бага уу, дунд зэрэг үү, эсвэл их үү? Энэ нь одоогийн байгаа нөхцөл байдалд үндэслэх ёстой. Та үр дагавар ба магадлалыг бодолцон сонголтоо хийсэн бол ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний матрицын зохих хэсэгт байрлуулаарай. Энэ нь ЖДБ-ын эрсдэлийн зэрэг өндөр, дундаж, эсвэл бага эсэхийг тодорхойлох ба эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлох, шийдэх, хэрэгжүүлэхдээ аль арга хэмжээг нэн түрүүнд хийх үү, алийг нь хэсэг хугацааны дараа хийх үү гэх зэрэг эрэмбийг тодорхойлоход тусална.

Үүний дараа, ЖДБ матрицын мэдээллийг картууд руу буулгаж, хананд байгаа ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний хүснэгтийн зохих нүдэнд (Алхам 4-т) байрлуулаарай. Танай багийн ажлыг тайлбарлах хүн нь юу хийснээ ангийнхандаа тайлбарлаж өгнө.

# БҮЛЭГ 3

## Зарим ажлын байранд ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээ хийх жишээнүүд

# СОНГОСОН АЖЛЫН БАЙРУУДАД ХИЙХ ЖДБ-ЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШЭЭ

Дараагийн хуудсуудад үзүүлсэн ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний жишээ нь ЖДБ-уудад ашиглаж болох арга замыг харуулах бөгөөд илрүүлж болох зарим аюулын талаар санаа авахад тань хэрэгтэй. Гэвч, аюулууд нь тухайн нэг аж ахуйн нэгж, байгууллагад илэрч болох бүх аюулыг хамраагүй бөгөөд эрсдэлийг хянах арга хэмжээг ч бүрэн санал болгоогүй гэдгийг анхаарна уу. Байгууллага бүр өөр бөгөөд тус бүртээ өөрийн ажлын аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх, хяналтын арга хэмжээг зохих ажлын байрандаа төлөвлөн хэрэгжүүлэх ёстой юм. Хэдийгээр аюул нь ижил байж болох ч эрсдэлийг хянах арга хэмжээ нь өөр өөр байж болно.

## ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийсэн бэ?

**1. Ажлын байрны менежер:**

- → Тухайн төрлийн байгууллагад байж болох аюулын төрлийг интернэтээр судалж, зөвлөгөөг авсан (маш олон нь үнэгүй байдаг) ба эрсдэлийг хянах арга хэмжээ (сайн туршлага)-г мөн интернэтээс олж бичсэн.
- → Ажлын байрны гадна ба дотор талаар алхаж, ажиглагдсан аюулыг тэмдэглэсэн.
- → Ажилтнуудтай ярилцаж, тухайн объектод мөрдөгддөг аюулгүй ажиллагааны системийн талаарх мэдлэгээс нь хуваалцаж, аюулгүй байдал эрүүл мэндийн талаарх тэдний бодлыг асуусан.
- → Бага хэрэгсэл, машин тоног төхөөрөмжид үйлдвэрлэгчдээс өгсөн зааврыг шалгасан.
- → Химийн бодис ба бусад бүтээгдэхүүнүүд ямар аюул учруулж болох талаар химийн бодисын аюулгүй байдлын хуудас болон бүтээгдэхүүн нийлүүлэгчдээс мэдээлэл авсан.
- → Урд нь гарч байсан ослуудын шалтгааныг тогтоохын тулд ослын бүртгэлийг харсан.
- → Ажлын байранд хяналт шалгалт хийсэн бүртгэлийг харсан.

**2. Менежер аюулд хэн хэрхэн өртөж байгаа, эсвэл өртөж болохыг бичсэн.**

**3.** Аюул тус бүрт менежер одоогоор авч хэрэгжүүлж байгаа эрсдэлийг хянах арга хэмжээг бичсэн. Эрсдэлийг хянах арга хэмжээг сайн туршлага ба өмнө нь хэрэглэж байсан заавар материалтай харьцуулсан. Хэрэв одоогоор авч байгаа арга хэмжээ байхгүй бол, эсвэл одоогийн арга хэмжээ нь хангалтгүй гэж үнэлэгдсэн бол, менежер дараагийн шатанд авах арга хэмжээг тодорхойлсон.

**4.** ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээг бодит амьдралд ашиглаж, хяналтын арга хэмжээг хэн хэзээ хэрэгжүүлэхийг шийдэж, бүртгэсэн. Мөн эдгээр арга хэмжээг юун түрүүн тодорхойлсон ЖДБ-ын эрсдэлийн зэргээс хамааруулан сонгож, арга хэмжээ бүр хэзээ хийгдсэн байх ёстой огноог товлосон. Менежер ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний үр дүнг ажилтнуудтай ярилцаж, ажилтнуудад харагдахаар газар байрлуулсан.

**5.** ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээг жил бүр эргэн хянаж, шинэчилж байхаар шийдсэн бөгөөд хэрэв нөхцөл байдал шаардвал, тухайлбал: байгууллагад шинээр тоног төхөөрөмж, ажлын байр нэмэгдсэн, эсвэл бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн бол, тухай бүр ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийнэ.

Энэхүү хавсралтанд11 үзүүлсэн жишээнүүд нь дараах салбарын байгууллагыг хамарсан:

1. Тоосго өрөх үйл ажиллагаа (Барилга)
2. Лавлах төвүүд
3. Үсчин
4. Авто машин засварын цех
5. Оффисын цэвэрлэгээний ажил

[11] Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь энэхүү хавсралтанд агуулагдсан мэдээлэл нь олон нийтэд зориулсан мэдээлэл бөгөөд Их Британи улсын Хөдөлмөрийн Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын Удирдах Газраас хэвлүүлж, Их Британийн Засгийн Газрын Нээлттэй Лиценз 1.0-р оюуны өмчийн гэрчилгээ эзэмшдэг болохыг баталгаажуулж байна.

# Хавсралтууд Жишээ 1. Тоосго өрөх ажил

Байгууллага: Барилга　　Хэлтэс/нэгж: Тоосго өрөх хэсэг　　Огноо: 2013/03/06

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Эрсдэлийг хянах арга хэмжээг | | |
| | | | | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн |
| Өндрөөс унах | Хэрэв ажилтан унавал хүнд гэмтэх, эсвэл бүр амь насаа алдах аюултай. | ▪ Барилгын шат, дүүжинт өргүүрүүдийн шаардлагуудыг гэрээний шатанд тохиролцох, үүнд ачаа даах түвшин, ачааны тавцангийн стандарт гэх мэт орно.<br>▪ Тоосго өрөх хэсгийн ахлах /супервайзор/ нь талбайн даамлын хамт аюулгүй ажиллагааны шаардлага хангасан дүүжинт өргүүр ашиглуулж байгаа эсэхийг шалгаж, баталгаажуулах.<br>▪ Ажилтнууд анхаарал сарниулахгүй байх, эсвэл дүүжинт өргүүрийг буруу ашиглахгүй байх талаар заавар авсан байх, ахлах / супервайзор/ нь гарч болзошгүй асуудлыг хянаж байх.<br>▪ Шат бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай байх, аюулгүй байдлыг сайн хангасан байх (бэхэлгээ сайн байх), мөн шатыг хуурай тэгш газар зөв байрлуулах.<br>▪ Дотор ханан дээр ажиллахдаа бариултай анхааруулах тэмдгийг тавих.<br>▪ Ажилтнуудыг ийм анхааруулах тэмдэг ашиглаж сургах. | ▪ Супервайзор буюу ахлах нь талбайн даамалтай тогтмол ярилцаж, дүүжинт өргүүрийн засвар ба шинэчлэлтийг төлөвлөж, долоо хоног бүр аюулгүй байдлыг шалгаж байх. | ТБ<br><br>ГБ | 2013/03/20<br><br>2013/05/01-ээс | 2013/03/20 |
| Дүүжинт өргүүр эвдрэх | Дүүжинт өргүүр доор ажиллаж буй ажилтны дээрээс унавал ажилтнууд цохиулж гэмтэх буюу бүр муу үр дүн гарч болно. | ▪ Барилгын шат, дүүжин өргүүрийн шаардлагуудыг гэрээний шатанд тохиролцох, үүнд ачаа даах түвшин, ачааны тавцангийн стандарт гэх мэт орно.<br>▪ Тоосго өрөх хэсгийн ахлах /супервайзор/ нь талбайн даамлын хамт аюулгүй ажиллагааны шаардлага хангасан дүүжинт өргүүр ашиглуулж байгаа эсэхийг шалгаж, баталгаажуулах. | ▪ Супервайзор буюу ахлах нь дүүжин өргүүрт хэт их материал ачихгүй байгаа эсэхийг тогтмол шалгаж байх. | ЛГ | 2013/05/01-ээс | |
| Хальтирах, бүдрэх | Бүх ажилчид хог тоосго өрөхөд ашигласан шаварны хатсан хаягдал, тавцан дээр байгаа хог хаягдал зэрэг дээр бүдэрвэл булчин шөрмөсөө таслах, гэмтээх аюултай. Хэрэв өндрөөс хальтирч унавал ноцтой гэмтэнэ. | ▪ Ажлын орчныг үргэлж цэвэр цэгцтэй байлгах.<br>▪ Аливаа хог хаягдлыг гарсан даруйд нь зайлуулж байх.<br>▪ Бүх ажилчдад хамгаалалтын гутал өмсгөх. | ▪ Хаягдлыг түр хадгалах байршлуудыг талбайн даамалтай тохиролцох.<br>▪ Супервайзорууд ажлын талбайд хүн бүрт хамгаалалтын гутал өмсүүлэх. | ТБ<br><br>ЛГ | 20/3/13<br><br>2013/05/01-ээс | 20/3/13 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Аюултай бодис, барилгын зуурмаг | Барилгын зуурмагтай шууд арьсаараа хүрэх нь тоосго өрөгч нарт гараа түлэх болон арьсны өвчин /дэрматитис/ тусгах магадлалтай. | ▪ Ажилчдад цементэнд түлэгдэх, арьсны өвчин тусах эрсдэл болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар тайлбарлаж өгөх.<br>▪ Цемент ба цемент агуулсан бүтээгдэхүүнийг ашиглах хугацаанд нь багтаан ашиглах.<br>▪ Тоосго өрөх ажил хийхдээ түүхий эд материалд гараар хүрэхээс зайлсхийж, PVC буюу химийн бодист тэсвэртэй бээлий хэрэглэх.<br>▪ Ажлын талбайд хүйтэн ба халуун ус, саван, гар тохойгоо бүрэн угаахад хангалттай угаалтуур бүхий сайн угаалгын хэрэгсэл байрлуулж, ашиглуулах. | ▪ Бүх ажилчдад химийн бодист хордохоос хэрхэн сэргийлэх талаар сургалт өгөх.<br>▪ Супервайзорууд арьсны өвчний анхан шатны шинж тэмдгүүдийг мэддэг байх, шалгадаг байх. | ТБ<br><br>ЛГ | 17/4/13<br><br>2013/05/01-ээс | 26/4/13 |
| Ажиллаж буй цемент холигч | Хэрэв цемент холигч унах юм уу, ажилтнууд хөдөлж буй хэсгүүдийн дунд хавчуулагдвал цохигдох буюу хэрчигдэх эрсдэлтэй. Тогонд цохиулах нь шоконд оруулна. | ▪ Цемент холигчийг тэгш газарт байрлуулах.<br>▪ Холигч ажиллах үеэр хаалт хашилт хийх.<br>▪ Холигч 100 вольтоор ажилладаг байх, гурван сар тутам шалгадаг байх. | Супервайзорууд ямар нэг хүн гэмтээгүй эсэхийг өдөр бүр шалгаж байх. | ЛГ | 2013/05/01-ээс | |
| Ажлын талбайд ажилтнууд хөдөлж буй авто машинд мөргөгдөх буюу дайруулах | Ажлын талбайд ажиллаж буй машин механизмд дайруулах буюу мөргүүлбэл, ялангуяа машин механизм онхолдож, хөмрөхөд, ажилтнууд ноцтой бэртэж гэмтэх буюу бүр нас барж ч болно. | ▪ Менежер ажлын бүст аюулгүй ажиллах чиглэлийг тохирох.<br>▪ Ажиллах талбай бүрт ажилтнуудыг ажиллаж эхэлсэн эхний өдөр зааварчилгаа өгөх.<br>▪ Менежер ажлын талбайд зөвхөн сургагдсан жолооч операторууд ажилладаг байлгах. | ▪ Ажлын талбайд ажиллаж буй хүн бүртэй явган хүн аюулгүй явах чиглэлийг тодорхойлж, хэлж, ойлголцох.<br>▪ Супервайзор аюулгүй гарц, замууд үргэлж цэвэр байхыг хариуцах.<br>▪ Супервайзорууд сургагдаагүй буюу эрх олгогдоогүй бүх ажилтнууд хэзээ ч ажлын талбайд машин механизм ажиллуулахгүй байхаар зааварлах.<br>▪ Тод харагддаг хувцсыг ажилтан бүрт олгож, супервайзорууд бүх хүн хувцсаа өмсч байгаа эсэхийг шалгадаг байх. | ТБ<br><br>ЛГ<br>ЛГ<br><br>ЛГ | 20/3/13<br>2013/05/01-ээс<br>2013/05/01-ээс<br>2013/05/01-ээс | 20/3/13 |
| **Алхам 5. Эргэн хянах өдөр: 2013/09/25** | | | | | | |
| Үнэлгээ хийсэн: ТБ менежер | | | | | | |

## Жишээ 2. Лавлах төв

**Байгууллага:** Пи Ар лавлах төв  **Хэлтэс/нэгж:** Лавлах төв  **Огноо:** 2013/03/06

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрсдэлийг хянах арга хэмжээг | | |
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн |
| Дэлгэцээр Харуулдаг тоног төхөөрөмж (ДХТТ) | Ажилтнууд ажлын орчин, эсвэл зохисгүй зохион байгуулалттай ажлын өрөө, эсвэл ДХТТ-г хэтрүүлэн буюу буруу хэрэглэснээс эвгүй байрлалд ажиллах, өвдөх, тухгүй ажиллах буюу бэртэж гэмтэх (тухайлбал, гар ба бугалгаараа) аюултай. Хэрэв гэрэлтүүлэг муу бол нүд аргах, толгой өвдөх боломжтой. | ▪ Шинээр ажиллаж эхэлж байгаа хүн бүрээр зааварчилгааны хүрээнд ДХТТ-ын сургалт ба үнэлгээг ажлын өрөө тус бүрт хийлгэж байх.<br>▪ Ажлыг төлөвлөхдөө тогтмол завсарлага авах буюу өөр ажил хийж байх зохицуулалтыг оруулж байх.<br>▪ Гэрэлтүүлэг ба агаарын хэмийг зохих түвшинд байлгаж, хянах.<br>▪ Цонхоор байгалийн гэрэл нэвтэрч, дэлгэцэн дээр тусахаас эвхэгддэг битүү хаадаг хөшгөөр хамгаалах.<br>▪ Хэрэгтэй хүмүүст нь харааны тест хийж, ажил хийх үүрэгтэй хүнд нь (ажил олгогч, орч.) нүдэнд хор оруулахгүйн тулд хамгаалалтын нүдний шилийг худалдаж авч өгөх (эсвэл зарим тохиолдолд зардлын заримыг нь төлөх). | ▪ Супервайзорууд ажилтнуудаар дэлгэцээс хол байх завсарлага авахуулж байх.<br>▪ Өөрийн үнэлгээнээс гарсан арга хэмжээнүүдэд аль болох хурдан хариу арга хэмжээ авсан эсэхийг шалгах.<br>▪ Компьютертай холбоотойгоор ямар нэг өвчин байгаа бол менежертээ хэлэхийг ажилтнуудад сануулах. | Супервайзор<br><br>Менежер<br><br>Менежер | 4/10/13<br><br>21/10/13<br><br>21/10/13 | 4/10/13<br><br>21/10/13<br><br>21/10/13 |
| Дуу | Ажилтнууд урт хугацаанд чанга яриа сонссоноос сонсголоо гэмтээж болно, мөн чихэвчний эрүүл ахуй муугаас сонсгол муудаж болно. Ажилтнууд телефон утасны тоног төхөөрөмж ашиглахдаа гэнэт чанга дуу сонссоноос шоконд орж болно. | ▪ Ажилтнууд нэг эсвэл хоёр хос чихэвчний сонголттой байх.<br>▪ Ажилтнууд өөрсдийн чихэвчний дуугаа (хэдийгээр зарим чанга дуу эсвэл шуугиан утсаар ярьсны дараа үндсэн тохиргоогоор хэвэндээ ордог ч) хянаж байх<br>▪ Ажилтнууд чихэвчний эрүүл ахуй болон тухтай байдлаар хэрэглэхэд сургагдсан байх.<br>▪ Утасны төхөөрөмжний чанга дуунаас ‘акустик шок’-ны хүсээгүй тохиолдол үүссэн бол тайлагнаж сурсан байх. | ▪ Дуу чимээний түвшинг хянах сургалтыг тогтмол явуулах.<br>▪ Арын фон дуу шуугианы түвшинг багасгахын тулд ажлын байрны дизайн болон ажлын практикийг сайжруулж эсвэл өөрчилж болохоор байгаа эсэхийг бодолц (тухайлбал, ажилтнуудад завсарлагын цаг байх).<br>▪ Агуулахт нөөц чихэвчний порлон байлгах.<br>▪ Акустик шокны талаар ямар нэг мэдээлэл ирсэн эсэхийг шалган судалж, мониторинг хийж байх. | Менежер<br><br>Менежер<br><br>Менежер<br><br>Менежер | 21/10/13<br><br>21/10/13<br><br>21/10/13<br><br>Одоо хэрэгжиж байгаа | 21/10/13<br><br>21/10/13<br><br>21/10/13 |
| Гал | Ажилтнууд гарч чадахгүй тохиолдолд галд түлэгдэх болон утаа амьсгалах боломжтой. | ▪ Галын ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээ хийсэн байх.<br>▪ Галын гарцуудыг цэвэр, түгжээгүй байлгах.<br>▪ Галын үзүүлэн сургалтууд хийж байх. | Байхгүй | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Стресс | Ажлын байрны хяналт дутмаг (жишээлбэл, ирж буй утасны дуудлагын цаг ба давтамжинд хяналт байхгүй) буюу хэрэглэгчдээс үгээр дайрч давшлах зүйл гарвал ажилтнуудад сөргөөр нөлөөлнө. | ▪ Дуудлагын зорилгыг бодит хэрэгцээтэй байлгах талаар супервайзортайгаа зөвлөлдөн, дуудлагын зорилгыг тодорхойлж байх.<br>▪ Ажилтнуудаа ажлаа хэрхэн хийх талаар сургалт өгч байх.<br>▪ Ажилтнууд ажлаасаа шалтгаалан амархан өвдөж байгаа бол супервайзортайгаа ярилцаж болно.<br>▪ Харилцагчид үгээр дайрсан тохиолдолд хэрхэх талаарх байгууллагын бодлого. | ▪ Ажилтнууд ажлаасаа шалтгаалан амархан өвдөж байгаа тохиолдолд санаа зоволтгүйгээр менежер эсвэл супервайзортайгаа зэмлэл хүлээлгүйгээр ярилцаж болно гэдгийг сануулах. | Менежер | 4/10/13 | 3/10/13 |
| Цахилгаан | Ажилтнууд гэмтэлтэй цахилгаан тоног төхөөрөмж ашигласнаас тогонд цохиулж шоконд орох буюу түлэгдэж болно. Цахилгааны гэмтэл нь мөн галын аюул үүсгэж болно. | ▪ Ажилтнууд аливаа залгуур дефекттэй байх, урт залгуурт өнгө орж харласан байх, эсвэл ямар нэг утас кабель, тоног төхөөрөмж гэмтэлтэй байвал олж хараад, тайлагнах чадварт сургагдсан байх.<br>▪ Тэдгээрийг хэрэглээнээс аюулгүй байдлаар гаргаж, зохистой хэрэгслээр солих систем хэрэгжиж байх. | ▪ Барилгын цахилгааны монтаж дараагийн удаа хэзээ шалгагдахыг товлох. | Менежер | 10/10/13 | 10/10/13<br>Шалгасан өдөр<br>15/11/13 |
| Өндөрт ажиллах, чимэглэл хийх гм. | Ажилтнууд ямар ч өндрөөс унасан шархдах, гэмтэл авах боломжтой. | ▪ Одоогоор шат байхгүй, ажилтнууд сандал дээр зогсож байгаа.<br>▪ Цонхны дотор талыг шат ашигладаг туслан гүйцэтгэгчээр цэвэрлүүлдэг. | ▪ Сандал дээр зогсохгүй байх<br>▪ Худалдаж авсан шатыг хэрэглээнд зохимжтой байдлаар нь сонгосон байх, ажилтнууд түүнийг хэрхэн аюулгүй ашиглахад суралцсан байх. | Менежер<br>Менежер | 1/10/13<br>1/12/13 | 1/10/13<br>1/11/13 |
| Хальтирах, бүдрэх | Ажилтнууд болон зочид аливаа зүйл дээр бүдэрч, эсвэл асгарсан зүйл дээр хальтирч унавал бэртэж гэмтэнэ. | ▪ Ахуйн хэрэглээ, цэвэрлэгээг ерөнхийд нь сайн байлгах.<br>▪ Бүх хэсэг, шат зэрэг нь сайн гэрэлтүүлэгтэй байх.<br>▪ Ямар нэг кабель, салаалагч нь хайлаагүй байх.<br>▪ Оффисыг орой бүр цэвэрлэж байх. | ▪ Ажилтнуудын цайны өрөөг илүү цэвэр цэгцтэй байлгах, ялангуяа асгасан зүйлсийг тогтмол цэвэрлэж байх.<br>▪ Хоёр давхрын урагдсан шалны хивсийг засах буюу шинээр солих. | Бүх ажилтнууд<br>Менежер | Одооноос<br>21/10/13 | 1/10/13<br>17/10/13 |
| **Алхам 5. Эргэн хянах өдөр: 2014/01/10** | | | | | | |
| Үнэлгээ хийсэн: Лавлах төвийн менежер ажилтнуудтайгаа зөвлөлдөж хийв. | | | | | | |

# Жишээ 3. Үсчин

**Байгууллага:** Үсчин **Хэлтэс/нэгж:** **Огноо:** 2013/07/01

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрсдэлийг хянах арга хэмжээг | | |
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн |
| Нойтон гартай ажиллах, тухайлбал үс угаах, нойтон үстэй ажиллах | Ажилтнуудын эмзэг, хэт хуурайшсан арьснаас болж арьсны өвчин /дэрматитис/ тусч болно. | ▪ Ажилтнууд хүсвэл гар түлдэггүй бээлийгээр хангах.<br>▪ Ажилтнууд нойтон ажлуудын хооронд гараа сайн хатааж сурсан байх.<br>▪ Үнэргүй гарын тос олгох. | ▪ Ажилтнууд нойтон ажил хийх бүртээ бээлий өмсөнө.<br>▪ Эзэн нь бүх ажилтанд таарах бээлий өгөхийн тулд өөр өөр хэмжээтэй бээлий авна.<br>▪ Ажилтнууд ээлж эхлэхээс өмнө гарын гоёл чимэглэлээ тайлах шаардлагатай. | ДС ба ажилтан<br><br>ДС ба ажилтан<br><br>ДС ба ажилтан | 15/7/13<br><br>15/7/13<br><br>15/7/13 | 11/7/13<br><br>11/7/13<br><br>11/7/13 |
| Үсчинд ашиглагддаг бүтээгдэхүүн, химийн бодисууд. Цайруулагч, будаг, буржийлгагч хэрэгсэл, ариутгах шингэн, цэвэрлэгч бодис гэх зэрэг бүх бодис орно. | Ажилтнууд болон үйлчлүүлэгчид нүд болон арьсны цочроо авч болно. | ▪ Ажилтнууд тухайн хэрэглэдэг бодисуудыг нийлүүлсэн нийлүүлэгчийн бэлтгэсэн ашиглах зааврыг шалгаж, дагаж хийх.<br>▪ Ажилтнууд бүтээгдэхүүнийг холих, ашиглах, дээр нь бүтээгдэхүүнийг хольж тавьсан тавгийг угаахдаа гар түлдэггүй бээлий өмсөх.<br>▪ Салон ба хадгалалтын өрөөг сайн агааржуулах.<br>▪ Үйлчлүүлэгчид нэг удаа ашигладаг алчуураар сайн хамгаалагдсан байх. | ▪ Эзэн нь бодис нүдэндээ оруулсан тохиолдолд нүд угаах хэрэгсэл худалдаж авах<br>▪ Ажилтнууд үйлчлүүлэгчдэд эвгүй байгаа эсэхийг үргэлж шалгаж байх.<br>▪ Химийн ямар ч бодисыг нүдний түвшнээс дээш хадгалахгүй байх. | ДС<br><br>Ажилтан<br>Ажилтан | 31/1/13<br><br>31/7/13<br><br>15/7/13 | 25/7/13<br><br>25/7/13<br><br>15/7/13 |
| Гэрэлтүүлэгч (цайруулагч) бүтээгдэхүүн | Ажилтан ба үйлчлүүлэгч нүд, арьс, амьсгалын замын цочроо буюу аллерги авч болно. | ▪ Зөвхөн тоосонцор гаргадаггүй цайруулагч худалдаж авах. | ▪ Эзэн нь ажилтнуудад 3 сар тутам арьсны эсвэл аллергины асуудал байгаа эсэхийг шалгах. | ДС | 1/8/13 then every 3 months | 1/8/13 |
| Хүнд устөрөгч үүсгэгч, саармагжуулагч | Ажилтан ба үйлчлүүлэгч нүд, арьс, амьсгалын замын цочроо авч болно. | ▪ Ажилтнууд зааварласан концентрацийг ашиглахад сургагдсан байх. Гэрэл, халуун болон бусад бүтээгдэхүүнээс хол хадгалах. | Байхгүй | | | |
| Исэлдүүлэгч будаг | Ажилтан ба үйлчлүүлэгч нүд, арьс, амьсгалын замын цочроо авч болно. Ноцтой аллергины реакц үзүүлэх бага зэргийн магадлал бий. | ▪ Ажилтнууд үйлчлүүлэгчид будганд аллерги өгч байсан эсэх, хуйх ямар нэг байдлаар гэмтэж байсан эсэхийг асууж, шалгах. Хэрэв тийм бол үйлчлүүлэгч нь эмчийн зөвлөгөө аваагүй л бол үсийг будахгүй. | ▪ Ажилтнуудыг үйлчилгээ хийлгэхээс 48 цагийн өмнө үйлдвэрлэгчээс өгсөн зааврын дагуу арьсны аллергины тест хийж байх. | ДС ба ажилтан | 31/5/13 | 25/5/13 |
| Ганцаараа ажилах | Ажилтан ганцаараа ажиллаж байхдаа үгээр болон биеэр хүчирхийлэл амсах. | ▪ Ажилтнууд ганцаараа ажиллаж байхдаа цоожлох аргыг мэдэж байх. | ▪ Салоноос кноп дарж мэдээлэл өгөхөд, эзэн/менежерийг яаралтай зарлан дуудлаг систем байршуулах. | ДС ба ажилтан | 3/7/13 | 3/7/13 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Сахлын хутга ба бусад хэрэгсэл | Ажилтан ба хэрэглэгч зүсэгдэх, шалбарах.<br>Нэг хүнээс нөгөө хүнд цусаар дамжин халдвар тархаж, өвчин тусах боломжтой. | ▪ Бүх хурц иртэй хэрэгслийг хэрэглэсэний дараа ариутгах шингэнээр цэвэрлэдэг байх.<br>▪ Ариутгагч шингэний өдөр бүр сольж, үйлдвэрлэгчээс өгсөн бохирдлын талаарх зааврыг нь дага.<br>▪ Боломжтой бол нэг удаагийн сахлын хутга хэрэглэж, хэрэглэсний дараа шууд хайрцганд хийж устгаж байх.<br>▪ Анхны тусламжийн хэрэгслийн бэлэн байлгах. | ▪ Эзэн нь ажилтнууд ариутгах журмыг мөрдөж байгаа эсэхийг тогтмол шалгадаг систем нэвтрүүлэх.<br>▪ Ажилтнууд хүний нүүрэнд юм гарсан эсвэл тодорхой хэсэг нь зүсэгдсэн тохиолдолд бээлийтэй ажилладаг байх. | ДС<br><br>Ажилтан | 2013/06/30<br><br>2013/07/15 | <br><br>2013/07/15 |
| Хальтирах, бүдрэх | Ажилтнууд болон зочид ямар нэг зүйл эсвэл гэмтсэн цахилгаан хэрэгслийн утсан дээгүүр явахдаа бүдрэх, эсвэл тайрсан үс, асгарсан зүйл, нойтон шалан дээр хальтирч унавал бэртэж гэмтэнэ. | ▪ Салон эмх цэгцтэй байх.<br>▪ Тайрсан үсийг нэн даруй шүүрдэж авах.<br>▪ Ямар нэг асгарсан ус, бүтээгдэхүүнийг нэн даруй цэвэрлэх.<br>▪ Салоны үүдэнд шалавч тавих.<br>▪ Гэмтсэн цахилгааны утас байлгахгүй байх.<br>▪ Ажилтнууд тохиромжтой гутал өмсөх. | ▪ Ажилтнуудын цайны өрөөг илүү цэвэр эмх цэгцтэй байлгах, ялангуяа асгасан зүйлсийг тогтмол цэвэрлэж байх.<br>▪ Хоёр давхрын урагдсан шалны хивсийг засах буюу шинээр солих. | ХС ба ажилтан<br><br>ДС | 2013/08/31<br><br>11/8/13then every 6 months | 2013/08/25<br><br>7/8/13 |
| Урт хугацаанд зогсох | Ажилтнууд булчин шөрмөсний гэмтэл авч болно, тухайлбал нуруу өвдөх, хүзүү эсвэл мөр гэмтэх, өвдөх, хөл ба гуя чилэх. | ▪ Үйлчлүүлэгчийн сандал бүрэн тохируулагчтай байх.<br>▪ Угаалтуурын крант мушгих шаардлагыг хамгийн бага байлгах.<br>▪ Ажилтнууд үс засахдаа ашиглаж болох эргэлддэг түшлэгтэй сандалтай байх. | ▪ Эзэн ажилтнуудаа тогтмол завсарлага авахуулж байхын тулд цагийн хуваарь гаргах.<br>▪ Эзэн жирэмсэн гэх зэрэг онцлог нөхцөлтэй ажилтнуудын анхааран авч үзэж, зохих байдлаар ажиллуулахаар өөрчлөлт хийх. | ДС<br><br>ДС | 31/8/13<br><br>31/8/13 | 25/8/13<br><br>25/8/13 |
| Цахилгаан | Ажилтнууд тогонд цохиулж, түлэгдэж болно. Мөн нойтон эсвэл гэмтэлтэй цахилгаан төхөөрөмж ашигласнаас гал гарч болно. | ▪ Ажилтнууд ямар нэг залгуур, кабель шатсан, гэмтсэн бол мэдээлж байх.<br>▪ Ажилтнууд цахилгааны щит хаана байгааг, хэрэгтэй үед хэрхэн унтраахыг мэддэг байх.<br>▪ Үсний сэнс болон бусад цахилгаан хэрэгслийг уснаас хол хадгалагддаг байх, нойтон гараар ашиглахгүй байх.<br>▪ Цахилгаан хэрэгслийг зөвхөн найдвартай эх үүсвэрээс худалдаж авах. | ▪ Эзэн залгуур, уртасгагч, кабелуудыг 6 сар тутам нүдээр шалгаж байх.<br>▪ Менежер бүх цахилгаан хэрэгслийг уснаас хол хадгалуулж байх.<br>▪ Салоны бүх цахилгааныг таван жил тутам мэргэжлийн цахилгаанчнаар шалгуулж байх, усны термостатыг жил бүр шалгуулж байх. | ДС<br><br>ХС<br><br>ДС | 11/8/13<br><br>11/8/13<br><br>30/9/13 | 7/8/13<br><br>4/8/13<br><br>20/9/13 |

**Алхам 5. Эргэн хянах өдөр: 2014/07/01**

**Үнэлгээ хийсэн: ДС ба ХС**

## Жишээ 4. Авто машины засварын цех

**Байгууллага: Пи Кюу цех** **Хэлтэс/нэгж:** **Огноо: 2013/07/01**

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрсдэлийг хянах арга хэмжээг | | |
| **Ямар аюул байна вэ?** | **Хэн хэрхэн хохирч болох вэ?** | **Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ?** | **Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ?** | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн |
| Хэрэглэсэн моторын тосны аюултай химийн бодисд өртөх | Ажилтнууд урт хугацаанд арьсаараа хүрч ажилласнаар хүнд арьсны өвчин / дэрматитис/ болон арьсны хорт хавдар тус болно. | ▪ Нитрилийн бээлийгээр хангаж, өмсгөх.<br>▪ Гаражд ажиллах бүтэн биеийн ажлын хувцсаар хангаж, хэрэглүүлэх.<br>▪ Бүтэн биеийн хувцсыг тогтмол цэвэрлэж өгөх. | ▪ Супервайзор бээлий өмсч байгаа эсэхийг шалгаж эхлэх.<br>▪ Дэрматитис болон арьсны хорт хавдрын талаар ажилтнуудад тайлбарлаж өгөх. | ЖБ | 14/3/13 | 12/3/13 |
| Сул ажиллуулж буй машины моторoос ялгарах хорт утаа, тухайлбал нүүрстөрөгчийн исэл. | Утаа нь ажилтнуудын нүдийг гэмтээж, амьсгалахад хүнд болгоно. | ▪ Моторыг зөвхөн сайн агааржуулалттай хэсэгт ажиллуулах. | ▪ Менежер моторыг ажиллаж байхад нь тохируулахын тулд шахагч хэрэгсэл ашиглах боломжийг тодорхойлох. | СП | 6/9/13 | |
| Баттерей цэнэглэх | Ажилтнууд баттерей цэнэглэж байхдаа, ялангуяа баттерейг хэт илүү цэнэглэж, дэлбэлснээр, баттерейны хүчилд хүрч түлэгдэж болно. | ▪ Цахилгаанчнаар суурилуулсан өмчлөгчийн цэнэглэгчийг зааврын дагуу ашиглах.<br>▪ Хүчилд тэсвэртэй бээлий, нүдний шилээр хангах, ашиглуулах. | Байхгүй | | | |
| Цахилгаан тоног төхөөрөмж Засварын тоног төхөөрөмж: Гар чийдэн гэх зэрэг олон төрлийн зөөврийн хэрэгсэл | Бүх ажилтнууд гэмтэлтэй цахилгаан тоног төхөөрөмж, ялангуяа зөөврийн хэрэгсэл ашигласнаар түлэгдэж гэмтэх буюу амь насаараа хохирох боломжтой. Гэмтэлтэй тоног төхөөрөмж нь мөн галын аюултай. | ▪ Гар чийдэн гэх зэрэг нь бага вольттой байх (24 вольт).<br>▪ 240 вольтын цөөхөн хэрэгсэл ашиглах, бүгд үйлдвэрлэлд зориулсан залгуур ба салаалагчтай байх.<br>▪ 240 вольтын зөөврийн хэрэгсэлд жил бүр үзлэг шалгалт хийж байх, хэрэгслийг ашиглагч ажилтнуудыг нүдээр шалгаж, дефектийг тайлагнахад сургах.<br>▪ Суурилуулсан тоног төхөөрөмждөө тогтмол засвар үйлчилгээ хийж байх. | ▪ Менежер 240 вольтын тоног төхөөрөмжийг 110 вольтынхоор солих боломжийг үнэлэх. | СП | 26/6/13 | |
| Гар ажиллагаа | Бүх ажилтан, ялангуяа агуулахад ажилладаг хүмүүс, бүх зүйлийг тогтмол өргөж зөөх, эвгүй объектуудыг өргөж зөөснөөс нуруу өвддөг болох. | ▪ Ачигч машин материалыг агуулахад хүргэж өгөх, эсвэл засварын цехт хүргэж өгөх.<br>▪ Бусад гар ажиллагааны туслах хэрэгслийг ашиглах, тухайлбал түрдэг сагс, дугуйтай түрдэг тэрэг. | ▪ Менежер гар ажиллагааны сургалтыг агуулахын ажилтнуудад товлож өгөх, зохион байгуулалтыг хийх. | СП | 10/5/13 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хальтирах, бүдрэх | Ажилтнууд шатнаас, өндөр авто машинаас, өндрөөс унасан тохиолдолд бэртэж гэмтэнэ. | ▪ Сургалт ба мониторингийн арга хэмжээгээр ахуйн стандартыг сайн барих.<br>▪ Шалыг 7 хоног бүр тоосыг нь цэвэрлэж байх.<br>▪ Ямар нэг зүйл асгасан бол яаралтай модны үртэс юм уу, үр тариагаар далдлах.<br>▪ Орц гарцыг засварлах. | ▪ Явган хүн алхах зам болон агуулахад зориулсан хэсгүүдийг шар зураасаар тэмдэглэх.<br>▪ 7 хоног тутам аж ахуйн шалгалт хийж эхлэх. | ЖБ<br>ЖБ | 12/4/13<br>10/3/13 | 10/4/13<br>17/3/13 |
| Өргөгч машины үйл ажиллагаа | Дараах зүйлсээс шалтгаалан бэртэж гэмтэж болно:<br>▪ жолооч өргөх машинаар юм мөргөх;<br>▪ ажилчид болон зочид өргөх машинд мөргүүлэх;<br>▪ ажилчид өргөх машинаас унах;<br>▪ өргөх машинаас ажилчид болон зочдын дээрээс юм унах;<br>▪ өргөх машин унах. | ▪ Бүх операторууд өргөгч машиныг ашиглах талаар сургагдсан, зөв ашиглах чадвартай байх.<br>▪ Өргөгч машиныг тогтмол үйлчилгээнд оруулж, зургаан сар тутам ямар нэг доголдол байгаа эсэхийг шалгаж байх.<br>▪ Шалыг зохих стандартад байлгах. | ▪ Супервайзорууд ажиллаж буй өргөгч машины дэргэд явган ажиллахад аюулгүй байгаа эсэхийг үнэлж байх.<br>▪ Операторуудад 3 жил тутам давтан сургалт өгч байх. | ЖБ<br>СБ | 1/6/13<br>25/7/13 | |
| Авто машины хөдөлгөөн | Хэрэв машин ажилчид болон зочдыг мөргөвөл бэртээж гэмтээнэ. | ▪ Ухрах шаардлагагүйгээр машинаа зогсоохуйц аюулгүй зогсоолоор хангах.<br>▪ Явган хүнд зориулсан замыг тусгайлан тэмдэглэх.<br>▪ Ажлын талбайд машинууд удаанаар орж, гарах. | ▪ Супервайзор нь орж, гарч байгаа машинуудын хурдыг хянах. | ЖБ | 29/3/13 | 31/3/13 |
| Ерөнхий галын аюул | Барилга шатаж болно, Ажилтнууд болон зочид шатаж буй барилгад хашигдаж болно. | ▪ Бүх хэсэгт тамхи татахыг хориглох.<br>▪ Галын дохиоллыг үйлдвэрлэгчээр нь шалгуулж, засуулж байх.<br>▪ Галын хорыг гэрээгээр өгч, эргэн шалгаж байх.<br>▪ Бүх ажлын байрнаас шууд гадагшаа гарах боломжтой тул тусгай галын гарц хэрэггүй. | ▪ Менежер нь бүх ажилчдад галын хор ашиглах талаар сургалт зохион байгуулж, өгөх.<br>▪ Жил бүр галын үзүүлэн сургалт зохион байгуулах. | СП<br>РП | 1/5/13<br>11/9/13 | |
| Шатахуунаас үүдэх галын аюул | Хэрэв шатахуун ажилтнуудад хүрч, авалцвал ажилтнууд хүнд гэмтэл авах буюу амь насаа алдаж болно. | ▪ Машины шатахууны танкийг гадаа байхад хоослохын тулд шатахуун гаргаж авагч ашиглах.<br>▪ Асгарсан бол тэр дор нь цэвэрлэх.<br>▪ Шатахуунаар биш, дахин ашигладаг керосиноор цэвэрлэж чаддаг ажилтнууд ажиллах. | ▪ Ажилчдад шатахуунтай аюулгүй ажиллах талаар давтан зааварчилгаа өгч байх. | СП | 20/3/13 | |
| **Алхам 5. Эргэн хянах өдөр: 2014/07/01** | | | | | | |
| **Үнэлгээ хийсэн: ДС ба ХС** | | | | | | |

# Жишээ 5. Оффисын цэвэрлэгээ

Байгууллага: ЛЖ Цэвэрлэгээ Хэлтэс/нэгж: Оффисын цэвэрлэгээ Огноо: 2013/08/01

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | | Алхам 4 | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ямар аюул байна вэ? | Хэн хэрхэн хохирч болох вэ? | Та эрсдэлийг хэрхэн хянаж байгаа вэ? | Эрсдэлийг хянах ямар шинэ арга хэмжээ авах вэ? | Эрсдэлийг хянах арга хэмжээг | | |
| | | | | Хэн хийх | Хэзээ хийх | Хийсэн |
| Хальтирах, бүдрэх, унах | Ажилтнууд болон бусад хүмүүс ямар нэг зүйлд бүдрэх, нойтон шал буюу асгарсан шингэн дээр хальтирч унах, бусад байдлаар унах зэргээс шархдах, булчин шөрмөсөө сунгах, таслах, бусад байдлаар бэртэж гэмтэх эрсдэлтэй. | ▪ Харилцагч байгууллагын ажлын байранд аж ахуйн ажил цэгцтэй, сайн байх.<br>▪ Нойтон шалтай хэсэгт анхааруулах конус байрлуулах.<br>▪ Харилцагч компани нойтон шалтай хэсгээр бүх ажилтан явж болохгүй гэдэг зааварчилгаа өгөх.<br>▪ Цэвэрлэгчид ажиллаж буй хэсэгтээ хамгийн ойр залгуураас цахилгаан хэрэгслээ залгаж, урт утсан дээгүүр бүдрэх эрсдэлийг багасгах. | ▪ Бүдрэх эрсдэлийг цаашид улам бууруулахын тулд хоёр шалны модтой системийг нэвтрүүлэх (чийгтэй цэвэрлэсэн шалны модны араас хуурайгаар арчдаг шалны модоор арчих).<br>▪ Цэвэрлэгчид ажилд тохиромжтой гутал өмсөх, тухайлбал сайн зуурдаг намхан ултай гутал өмсөх. | Менежер<br><br>Менежер | 31/8/13<br><br>31/8/13 | Системийг 8/8/13-нд нэвтрүүлсэн<br><br>15/8/13 |
| Цайруулагч болон бусад цэвэрлэгээний бодист хүрэх | Ажилтнууд цайруулагч, уусгагч, угаалгын нунтаг гэх зэрэгт арьсаараа хүрснээс арьсны өвчин /дэрматитис/ тусах буюу нүдээ гэмтээх. Химийн бодис уурших нь амьсгалын замын асуудал үүсгэнэ. | ▪ Ажилтнууд химийн бодисоор юм угаахдаа арьсны асуудал үүсч байгаа эсэх, өөр бусад өвчин мэдэгдэж байгаа эсэхийг асууж байх.<br>▪ Урт бариултай шалны мод, сойтог, зузаан резинэн бээлий зэргийг ажилтнуудад өгч, хэрхэн хэрэглэх талаар сургах.<br>▪ Бүх ажилчид цэвэрлэгээний бодисыг хэрэглэх, хадгалах болон тэдгээрийн талаар сургагдсан байх. | ▪ Харшил өгөх буюу аливаа өвчин үүсгэж байгаа цэвэрлэгээний бодисоо “цочроодог” гэж тэмдэглээд, арай зөөлөн, аллерги өгдөггүй бодисоор орлуулах.<br>▪ Ажилтнуудад цэвэрлэгээ хийснээс бий болж байгаа аливаа эрүүл мэндийн асуудлаа тайлагнаж,гар нь хуурайшсан, улайсан, загатанасан бол үзүүлж байхыг сануулах.<br>▪ Ажилтнууд угаалга цэвэрлэгээнд хэрэглэсэн бээлийгээ угааж, цэвэрлэж байхыг сануулах. | Менежер<br><br>Бүх ажилтан<br><br>Менежер | 7/10/13<br><br>7/8/13<br><br>7/8/13 | <br><br>4/7/13<br><br>4/7/13 |
| Булчин шөрмөс ясны өвчин (БШЯӨ) ба бэртэл гэмтэл | Угаалгын машин, усаар дүүргэсэн шал угаах хувин гэх зэрэг хүнд зүйлсийг биед эвгүй байдлаар өргөх, зөөх ажил хийснээс нуруу өвдөх гэх зэргээр өвдөх буюу бэртэж гэмтэх. | ▪ Давхар бүрт цэвэрлэгээний хэрэгсэл байх.<br>▪ Хүний бөхийх, тонгойх давтамжийг багасгахын тулд урт иштай шалны мод, сойз, тоос арчигчаар хангах.<br>▪ Ажилчид хувинг хэт дүүргэхгүй байх. | ▪ Шалны модыг нааш цааш түлхэх болон хувинг өргөж зөөхөд шаардагдах хүчийг багасгахын тулд урт иштэй, өөрөө мушгигддаг шалны модны системээр хангах (хальтирах, бүдрэх, унах хэсгийг үзнэ үү). | Менежер | 1/11/13 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Өндөрт ажиллах | Ажилтнууд өндрөөс унавал бэртэж гэмтэнэ. | ▪ Ажилтнуудад хэрэв өндөрт ажилла гэж зааварлаагүй бол өндөрт ажиллах хэрэггүй.<br>▪ ‘Сандал дээр зогсохгүй байх’ бодлого баримтлах.<br>▪ Ажилтнууд цэвэрлэгээний шатан дээр ажиллахдаа аюулгүй ажиллагааны талаар сургагдсан байх. | ▪ Байхгүй | | | |
| Ганцаараа ажиллах | Ажилтнууд ганцаараа ажиллаж байхдаа, ялангуяа хүн дуудах боломжгүй үед гэнэтийн өвчин буюу хүсээгүй тохиолдолд өртөх аюултай. | ▪ Цэвэрлэгээний ажилтнууд ресепшинд ажлаас буух цагаа бүртгүүлэх. Хэрэв тэд оройн 19:15 цагт гарын үсэг зурж, бүртгүүлээгүй бол хамгаалалтын ажилтнууд ажилтныг хайна. | ▪ Байхгүй | | | |
| Шал угаадаг машин | Ажилтнууд болон бусад хүмүүс машиныг буруу хэрэглэснээс бэртэж гэмтэнэ, тухайлбал машины хүч ихдэж, хөл буюу шагайг цохиж болно. | ▪ Ажилд тохирох машиныг сонгож хэрэглүүлэх.<br>▪ Цэвэрлэгчид машиныг аюулгүй ажиллуулахад сургагдсан байх.<br>▪ Машиныг ур чадвартай хүнээр тогтмол шалгуулж, шаардлагатай бол засуулж байх. | ▪ Машины аюулгүй байдлын талаар итгэлгүй байвал түүнийг ашиглахгүй байх талаар цэвэрлэгчдэд сануулах. | Менежер | 7/8/13 | 2/8/13 |
| Цахилгаан | Ажилтнууд доголдолтой цахилгаан тоног төхөөрөмжнөөс болж тогонд цохиулах, түлэгдэх эрсдэлтэй. | ▪ Ажилтнууд цэвэрлэгээний машин хэрэглэхээсээ өмнө залгуур ба кабелууд гэмтээгүй эсэх, асаах унтраах товчлуур нь ажиллаж байгааг шалгах.<br>▪ Хэрэв ямар нэг алдаа доголдол илэрвэл, машиныг хэрэглээнээс гаргаж, ур чадвартай хүнээс засуулна.<br>▪ Ажилтнууд цахилгаан хэрэгсэл болон залгуурын ойр ус тавихгүй, асгахгүй байхад сургагдсан байх. | ▪ Менежер цэвэрлэгээний машины залгуур, кабель, унтраалгыг тогтмол шалгаж байх. | Менежер | 2/8/13 | 2/8/13 |

**Алхам 5. Эргэн хянах өдөр: 2014/08/01**

**Үнэлгээ хийсэн: Менежер**

# Хавсралт: Бусад мэдээлэл

Аж ахуйн нэгж, байгууллагуудад эрсдэлээ үнэлэхэд нь туслах ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний олон арга, хэрэгсэл байдаг. Аль аргыг сонгох нь ажлын байрны орчин, үүн дотор ажилтнуудын тоо, үйл ажиллагааны төрөл, тоног төхөөрөмжийн төрөл, ажлын байрны тодорхой онцлог болон бусад тусгай эрсдэлүүдээс хамаарна.

Хамгийн түгээмэл хэрэгсэл нь шалгах хуудас бөгөөд аюулыг тодорхойлоход хэрэгтэй байдаг. Бусад төрлийн ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл болон заавар, зааварчилсан баримт бичигт гарын авлагууд, брошур, асуулга ба "харилцан ярилцах хэрэгслүүд" (харилцах программ хангамж, үүн дотор ихэвчлэн тухайн салбартаа тусгайлан хэрэглэгддэг татаж авч болдог хэрэглэгдэхүүнүүд) багтдаг. Хэрэглэгдэхүүнүүд нь ерөнхий буюу салбарын эсвэл тухайн нэг эрсдэлд зориулсан байж болно. Ийм төрлийн мэдээлэл ба хэрэгслийг авч болох зарим эх үүсвэрийг доорх сайн туршлага ба мэдээллийг хэсэгт оруулав.

## Сайн туршлага ба мэдээллийг хаанаас олж авах вэ

### Олон улсын ба бүсийн байгууллагууд

*1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)*

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны удирдамж: Женев, ОУХБ Аюулгүй Ажил, 2001. http://www.ilo.org/wcmsp5/groups/public/@dgreports/@dcomm/@publ/documents/publication/wcms_publ_9221116344_en.pdf
- Жижиг байгууллагуудын ажлын сайжруулалт (ЖБАС). Женев, ОУХБ Ажлын Нөхцөл ба Хөдөлмөр Эрхлэлтийн Хөтөлбөр (АНБХЭХ). http://www.ilo.org/wcmsp5/groups/public/ed_protect/---protrav/---travail/documents/instructionalmaterial/wcms_152469.pdf
- Сургагч багш нарт зориулсан УХААЛАГ багц. Женев, ОУХБ Ажлын Нөхцөл ба Хөдөлмөр Эрхлэлтийн Хөтөлбөр (АНБХЭХ). http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/instructionalmaterial/wcms_110322.pdf

*2. Ажил дээрх Аюулгүй Байдал ба Э рүүл Мэндийн төлөөх Европын Холбооны Агентлаг (ЕХ ХАБЭАА)*

- ЖДБ-ын эрсдлийн үнэлгээнд аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар Европын Холбооноос тогтоосон Хамрах Хүрээний Удирдамж гол үүргийг гүйцэтгэдэг: ажилчдын ажил дээрх аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулахыг дэмжих арга хэмжээний танилцуулга болсон 1989 оны 6 сарын 12-ны өдрийн Консулын Удирдамж 89/391/EEC. http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CONSLEG:1989L0391:2008
- 1211:EN:PDF
- ЕХ ХАБЭАА нь Европ даяар ашиглагдаж буй ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний мэдээллийн эх үүсвэр ба хэрэгслүүдийг ашиглан ЖДБ-ын эрсдлийн үнэлгээний хэрэгсэл боловсруулсан. Тэдгээр нь үнэгүй ба интернэтэд байршдаг. Мэдээллийн баазыг тогтмол шинэ хэрэгслээр баяжуулж байдаг. http://osha.europa.eu/en/practical-solutions/risk-assessment-tools
- Ажил дээрх ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний заавар: Эрүүл мэнд ба аюулгүй бадал. Европын Хороо, Ерөнхий Удирдамж 5 (Олон нийтийн ажил дээрх эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж), 1996, ISBN 92-827- 4278-4. http://osha.europa.eu/en/topics/riskassessment/guidance.pdf
- ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээнд заавал шаардагдах зүйлс. Энэ нь ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний суурь заавар ба эрсдэлийг бууруулахад ашиглаж болох өөр өөр салбар, ажил үйл ажиллагаа болон аюулын төрөлд зориулсан шалгах хуудсууд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний жишээнүүдийг агуулсан. http://osha.europa.eu/en/campaigns/hwi/about/material/rat2007

## Үндэсний байгууллагууд

Олон байгууллага ажил дээрх аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар ном хэвлэл гаргасан нь ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээ хийхэд нэмэлт мэдээлэл болсоор байна. Материалууд брошур ба мэдээллийн хуудаснаас практик гарын авлага байдгаараа ялгардаг. Зарим нь тодорхой нэг салбарт чиглэсэн бөгөөд тусгай аюулуудыг анхаарч үздэг. Тэдгээрийн олон нь үнэгүй бөгөөд орон нутгийн хэл рүү орчуулагдсан байдаг давуу талтай. Зарим сонирхолтой мэдээллийн эх үүсвэрт дараах орнуудын байгууллагууд орно:

- Канад: Канадын Хөдөлмөрийн Эрүүл мэнд ба Аюулгүй байдлын төв. http://www.ccohs.ca/ccohs.html
- Финлянд: Финляндын Хөдөлмөрийн Эрүүл Мэндийн Институт http://www.ttl.fi/en/safety/risk_assessment/
- pages/default.aspx
- Франц: Үнэлгээ мэргэжилтнүүдийг эрсдэлгүй болгодог, Осол ба мэргэжлийн өвчлөлөөс сэргийлэх Судалгаа ба Аюулгүй Байдлын Институт, 2009. http://www.inrs.fr/htm/evaluation_des_risques_professionnels.html
- Ирланд: ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээ ба аюулгүй байдлын тодорхойлолт, Ирландын Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын Удирдах Газар 2006. http://www.hsa.ie/eng/Publications_and_Forms/Publications/Safety_and_Health_Management/
- Guidelines_on_Risk_Assessments_and_Safety_Statements.pdf
- Норвеги: Норвегийн Хөдөлмөрийн Хяналтын Байгууллага. http://www.arbeidstilsynet.no/artikkel.
- html?tid=79289
- Испани: Үндэсний Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Мэндийн Институт (ҮХАБЭМИ) нь ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний 17 цуврал техникийн зааврыг нийтэлсэн. http://www.insht.es/portal/site/
- Insht/menuitem.1f1a3bc79ab34c578c2e8884060961ca/?vgnextoid=d8388dd6caa62110V
- gnVCM100000dc0ca8c0RCRD&vgnextchannel=75164a7f8a651110VgnVCM100000dc
- 0ca8c0RCRD
- Швед: Ажлын орчны системтэй менежментэд эрсдэлийг судалж, үнэлэх нь - заавар, Шведийн Ажлын Орчны Байгууллага (Arbetsmiljцverket) 2003. 2 дахь хув., 2004, ISBN 91-7464-449-1. http://www.av.se/dokument/inenglish/books/h375eng.pdf
- Их Британи: Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын Удирдах Газрын вэб сайт нь эрүүл мэнд, аюулгүй байдлын өөр өөр сэдвүүдээр, өөр өөр салбарт зориулсан бодит амьдралд хэрэгжиж байгаа олон ЖДБ-ын эрсдэлийн үнэлгээний мэдээллийг агуулж байгаа. http://www.hse.gov.uk/risk/

# ТЭМДЭГЛЭЛ

Хаяг:
92 тоот, 34–р байр, 15141, 5–р хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас/Факс: 976–76113838,
Шуудангийн хайрцаг: 46/906,
И–Мэйл: training@oshmi.mn,
Вэб сайт: http://www.oshmi.mn

ISBN 978-92-2-127063-8
9 789221 270638